## Өмнөх үг

Улс төрд анхлан орж ирсэн цагаас миний сэтгэлийг байнга түгшээж байсан нэг гол асуудал бол манай төрд авилга өргөн тархаж буй явдал байлаа. Энэ талаар зарим нэг ажил эхлүүлсэн боловч үнэхээр ганцаардаж, хүч дутаж байв.

Олон улсын болон гадаадын нэлээд байгууллага цөөнгүй удаа шахаж шаардсаны эцэст "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр" батлан гаргасан нь энэ талаар хийсэн бараг цорын ганц бодит ажил болсон юм. Харин түүний биелэлт хэр зэрэг байгаа, ямар бодит үр дүн гаргасан эсэх нь ахиад л санаа зовоох асуудал болон хувирав.

Үүнийг шинжлэх ухааны үндэстэй мониторингийн судалгаагаар л гүйцэтгэж болох байв. Удаан хайсны эцэст Монгол Улсын Их Сургуулийн Социологийн тэнхмийн дэргэдэх "Социологийн Академи" сургалт, судалгааны төв, түүнийг ахалж буй судлаач Д.Ганхуягийг сонгож түүнтэй энэхүү судалгааг хамтарч хийх санал тавьсан юм. Бидний тохиролцсон ганц зүйл бол судалгааг цэвэр шинжлэх ухааны үндэстэйгээр хийж бодит байдлыг байгаагаар нь гаргах явдал байсан юм.

Өнөөдөр Та бүхэнд энэхүү томоохон судалгааны дүнг танилцуулж байгаадаа нэн баяртай байна. Судалгааны үнэлэлт, дүгнэлтэд би тайлбар хийхгүй. Гэхдээ энэ судалгаа нь авилгалын өнөөгийн төлөв байдал, түүний аюулын түвшинг нэн бодитойгоор харуулж чадсан бөгөөд авилгалтай хийх тэмцэлд бүх нийтийн анхаарлыг хандуулах, цаашдын ажлыг зохион байгуулахад нэн чухал ач холбогдолтой гэж үзэж болох байна. Мөн энэ судалгаагаар манай улсын авилгалын индексийг анх удаа тооцон гаргаж, олон улстай харьцуулан үзэх боломж бий болсонд би их баяртай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабандийн хэлснээр "хар тахал" болсон авилгал манай төрийн байгууламжид үлэмж нэвтэрч, нийгмийн хөгжлийг чөдөрлөгч болсон бөгөөд үүнтэй тэмцэж чадвал арилгах, ядвал багасгах талаар нийт ард түмний тэмцэл хийх зайлшгүй шаардлага үүсээд байна. Хэрэв ингэж эс чадваас мянган сайхан парлемант, мянган сайхан сонгууль явуулаад төрийн ажил урагшлана гэж хэзээ ч байхгүй гэдэгт би итгэлтэй байна.

Улсын Их Хурлын дэд дарга С. Оюун.

2004 оны 09 дүгээр сар.

Энэхүү судалгаанд:

Багийн ахлагч: Д.Ганхуяг

Судлаач: С.Баяр
Ц.Болд
О.Мөнхбат
Г.Түмэннаст
М.Батбаатар
Ч.Тамир
С.Мөнхбаатар
Б.Бат-Өлзий
Ц.Галцог
Э.Загдсүрэн
О.Ганзориг
Ж.Нарантуяа
Б.Анужин

Мэдээлэл цуглуулах ажилд МУИС-ийн Социологийн III курсийн оюутан Т.Сонинхүү, О.Төмөр, Н.Нямбаатар, А.Батцэцэг нар болон Социологийн II курсийн оюутнууд З.Зоригтсайхан, Г.Цогтбаатар, Т.Сэлэнгэ, Э.Эрдэнэбаатар, Х.Анхтамир, П.Арвинжаргал, М.Ариунбат, М.Ариунтунгалаг, Б.Батжаргал, Н.Батцэцэг, Н.Бахытнур, Ц.Баянжаргал, З.Болормаа, Д.Гантөмөр, Б.Дариймаа, Г.Мөнхгэрэл, Д.Наранцацрал, М.Оюун, П.Очирбат, Д.Пунсанцогвоо, Н.Саранзаяа, П.Төрмөнх, О.Түмэнжаргал, Б.Хаш-Эрдэнэ, Бх.Хаш-Эрдэнэ, Г.Цагаанцэцэг, Т.Цэцэгмаа, Х.Чанцалдулам, Ц.Энхтуяа, Н.Эрдэнэбат нар оролцлоо.

**“Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр” - ийн хэрэгжилт, авилгалтай тэмцэх талаарх олон нийтийн санал бодол**

/мониторингийн судалгааны тайлан/


**§ Судалгааны хөтөлбөр, арга зүй**

**§ Бүлэг 1 : Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, баримтын шинжилгээ**

**§ Бүлэг 2 : Авилгалын талаарх олон нийтийн санал бодол, үнэлгээ**

**§ Бүлэг 3 : Авилгалтай тэмцэж буй өнөөгийн байдалд олон нийтийн зүгээс өгч буй үнэлгээ**

**§ Бүлэг 4 : Өдөр тутмын хэвлэлийн материалд контент анализын аргаар хийсэн судалгааны дүн**

**§ Судалгааны үндсэн дүгнэлтүүд, санал зөвлөмж**

**§ Хавсралтууд**

## § МОНИТОРИНГИЙН СУДАЛГААНЫ ХӨТӨЛБӨР, АРГА ЗҮЙ

### *1. Судалгаа явуулах хэрэгцээ, шаардлага*

Монгол Улсад авилгал бодитойгоор байгаа талаар бид олон жил ярьж ирсэн бөгөөд харин түүний эсрэг дорвитой хийсэн зүйлээр хомс байгаа билээ. Авилгал нь манай орны хөгжилд саад тотгор учруулж, ардчиллын үнэт зүйлс, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцад чөдөр тушаа болж байгааг ч бид мэддэг. Энэхүү сөрөг үзэгдэлтэй тэмцэх талаар өнгөрсөн хугацаанд хийсэн зарим нэг алхмууд бий. Тухайлбал, Төрийн эрх барих дээд байгууллагаас авилгалын эсрэг хууль батлагдан гарсан явдал. Гэсэн хэдий ч энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн зэрэгцээ, авилгал нь нийгэмд баттай хэвээрээ үлдсэн болно.

Төрийн болон бизнесийн байгууллагууд авилгалд үндсэндээ автагдсан нь өмнө нь хийсэн судалгаануудын үр дүнгээс тодорхой байгаа билээ.

2002 онд Монгол улс авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрөө батлан гаргасан явдал нь авилгалтай тэмцэх салбарт онцгой үйл явдал болсон юм. Энэхүү үндэсний хөтөлбөр батлагдаад нэлээд хугацаа өнгөрсөн ч өнөөдөр түүний хэрэгжилт нийгэмд тодорхой бус байна.

Тиймээс уг баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааны өнөөгийн үр дүн, явцыг олон нийтэд нээлттэй байлгах, бодлого боловсруулагчид хийгээд иргэний нийгмийн анхаарлыг энэ чигт хандуулах нь тулгамдсан асуудлын нэг мөн юм. Үүний тулд давын өмнө авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдан гарснаас хойших өнөөг хүртэл хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөхүйц үндэсний хэмжээний мониторингийн судалгааг явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх нь :

1. Хөтөлбөрийн үйл явц, хэрэгжилтийн явц, байдлыг олон нийт, иргэний нийгэмд нээлттэй байлгах
2. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд гарсан ололт, алдаа доголдлыг илрүүлэх
3. Олон нийтийн санал бодол, үзэл хандлагыг өмнө явуулж байсан томоохон судалгааны үр дүнгүүдтэй харьцуулах замаар уг үзэгдлийн хувьсал өөрчлөлт, хандлагыг тодорхойлох
4. Иргэд, төрийн бус байгууллагуудыг энэ ажилд татан оролцуулах зэрэг ач холбогдолтой болно

Авилгалтай тэмцэх нийгмийн механизмыг хэрхэн бүрдүүлснийг зөвхөн олон нийтийн асуулга судалгаагаар тодорхойлох боломжгүй бөгөөд олон нийтийн санал асуулгийн зэрэгцээ хөтөлбөрийн хүрээнд хуримтлуулсан болон бусад янз бүрийн баримтыг шинжлэх, төрийн бус байгууллага, мэргэжилтэн шинжээчдийг татан оролцуулах зэргээр өргөн бөгөөд гүнзгийрсэн арга зүйг шаардаж байна.

### *2. Судалгааны шинэлэг тал*

- Урьд нь Авилгалын талаар нилээдгүй хэдэн судалгаа хийгдсэн бөгөөд үндэсний хэмжээний суурь судалгааг 3 удаа (1997, 1999, 2002 онуудад тус тус) хийсэн байна. Энэ удаагийн судалгаа нь авилгалтай тэмцэх талаарх олон нийтийн санал бодлыг тодорхойлох хийгээд "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар мониторинг хийхэд үндсэндээ чиглэгдэж байна.
- Ингэхдээ "Хөтөлбөрийг" хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл бүрээр үнэлгээ өгөхийг эрмэлзэх ба тэр болгонд тоон болон чанарын судалгааны баримтаар дэлгэрэнгүй үнэлгээ өгөх суурь судалгаа хийгдэнэ.
- Төслийн шинэлэг тал нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд авилгалтай тэмцэх төрийн болон төрийн бус байгууллагуудын өргөн хүрээний хамтын ажиллагааны сүлжээг байгуулах эхний алхам хийхэд оршино.

### *3. Мониторингийн зорилго*

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийж, хөтөлбөрийн хэрэгжилт, өнөөгийн үр дүнг олон нийтэд нээлттэй байлгах, бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн анхаарлыг энэ чигт хандуулна.

Мөн манай нөхцөлд тохирсон үзүүлэлтийн системийг бий болгох, авилгалын хэмжээ далайцыг байнга хэмжих арга зүй боловсруулах, түүнийг боловсронгуй болгох, авилгалын индексийг бодож олон улсын байгууллагад явуулах үндсэн зорилготой.

### *4. Гарах үр дүн*

- "Авилгалтай тэмцэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтэнд өнөөгийн байдлаар үнэлгээ хийж, цаашдын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий тайлан санал зөвлөмжийг боловсруулан гаргана.
- Авилгалыг судлах, мониторинг хийх, хэмжих арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулна.
- Авилгалын индексийг тооцоолж, олон улсын байгууллагад хүргүүлнэ.
- Бодлого боловсруулагчдын анхаарлыг авилгалын асуудалд хандуулахын тулд судалгааны үр дүнд тулгуурлан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт" эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна.
- Судалгааны үр дүнгийн талаар мэдээллийг ОНМХ-ээр цуврал болгон нийтэд түгээнэ.
- "Авилгалтай тэмцэх хөтөлбөрийн хяналт үнэлгээ" гарын авлага хэвлүүлнэ.

### *5. Мониторингийн үйл ажиллагаа / аргачлал*

Судалгааг 2003 оны 09 сарын нэгнээс 2004 оны 04 сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн.

1. Авилгалтай тэмцэх Үндэсний зөвлөлийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаанд шинжилгээ хийсэн
2. Өмнөх судалгаануудаар авилгалд өртөмтгий байсан яам, агентлагийн авилгал хээл хахуультай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг эрхэлсэн зөвлөлийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаанд шинжилгээ хийсэн
3. Нийслэлийн 3 дүүрэг, 3 – 4 аймгийн авилгалтай тэмцэх талаар хийж буй үйл ажиллагаанд шинжилгээ хийж гүйцэтгэсэн
4. Авилгалтай идэвхитэй тэмцэж буй болон тэмцэх боломжтой төрийн бус байгууллага, иргэдээс хөтөлбөрийн биелэлтийн талаар үнэлгээ хийсэн
5. Сэтгүүлчид, төрийн албан хаагчид, шүүх, хүчний байгууллага, хувийн хэвшлийнхэн зэрэг эксперт бүлгээс судалгаа авах, үнэлгээ хийсэн
6. Албан болон албан бус баримт материалд гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж, томоохон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд контент – анализ хийсэн

### *6. Аргачлал*

Мониторингийн судалгаанд судалгааны хэд хэдэн арга зэрэгцүүлэн хэрэглэсэн юм. Үүнд:

*Нэгд*, Өмнөх судалгаануудаар авилгалд өртөмтгийд тооцогдсон яам, агентлагийн авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг эрхэлсэн зөвлөлийн ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаанд бичиг баримтын судалгааны аргаар шинжилгээ хийсэн

*Хоёрт,* Төр, иргэний хоорондох харьцаа, түүнээс үүсч буй авилгал, түүний илрэл, тэмцэх арга замын талаар сэтгүүлчид, төрийн албан хаагчид, шүүх, хүчний байгууллага, хувийн хэвшлийнхэн зэрэг эксперт бүлгээс фокус-группын аргаар судалгаа авч үнэлгээ хийсэн

*Гуравт,* Албан болон албан бус баримт материалд гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж, томоохон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд контент – анализ хийсэн

*Дөрөвт*, Авилгалын хэв загвар, олон нийтийн авилгалын талаар мэдрэмж тодорхойлох зорилгоор социологийн санал асуулга явуулсан

Нийслэл Улаанбаатар хот, Ховд, Дорнод, Дорноговь, Орхон зэрэг аймгуудад 2003 оны 10-11 сард санал асуулга явуулж 1286 респондентоос анкет сурвалжлагын аргаар анхдагч мэдээлэл авсан. Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллийг шалган, компьютерт шивж, статистикийн дан тоолoлтын боловсруулалтыг SPSS-8 программаар гүйцэтгэв.

## § БҮЛЭГ 1. АВИЛГАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, БАРИМТЫН ШИНЖИЛГЭЭ

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Монгол улсын их хурлаас 2002 оны 07 сарын 04-ний өдөр, 41 тоот тогтоолоор баталсан. Энэ хөтөлбөр нь 3 бүлэгтэй. Хөтөлбөрт дурьдсан бүлгүүдийн агуулгыг тоймлон авч үзвэл:

**Эхний бүлэгт** хөтөлбөрийн үндэслэлийн талаар дурдсан байна. Энэ бүлэгт авилгал нь улс орнуудын хөгжилд саад учруулдаг болохыг дурдаад 1996 онд авилгалын эсрэг хууль батлагдсан боловч түүний хэрэгжилт хангалтгүй байгаа, иймд төрд итгэх олон түмний итгэл алдагдаж болох аюултай тул авилгалын цар хүрээ, уг сурвалж, үр дагаврын талаар бодитой судалгаа дүгнэлт өгч, энэ үзэгдэлд нийтээр дасах хандлага бий болохоос сэргийлэн, төр засаг иргэний нийгмийн хүч, боломжийг нэгтгэн авилгалын эсрэг тэмцэхэд чиглэсэн урт хугацааны бодлого болон Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, авилгалын эсрэг тэмцлийг төр засаг өөрөөсөө эхэлж байгаа тухай өгүүлсэн.

**Дараагийн бүлэгт** авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүнгийн талаар нарийвчлан авч үзсэн.

*Авилгалтай тэмцэх хөтөлбөрийн зорилго* нь авилгалтай тэмцэх нөхцөл бүрдүүлэх, нийгэмд авилгалыг үл тэвчих уур амьсгал бий болгох, төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр авилгалаас урьдчилан сэргийлэх, түүний үүсч буй шалтгаан нөхцөлийг хязгаарлах, арилгахад оршино гэж тунхагласан.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн шинэ орчныг бүрдүүлэх, авилгалтай тэмцэх байгууллагын бүтцийг боловсронгуй болгох, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэгтэйгээр олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, иргэдэд авилгалын хор уршгийн талаар цэгцтэй мэдээлэл өгөх, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүх шатны байгууллагын шинэтгэлийг түргэтгэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зэрэг *зорилтуудыг* хангаснаар шийдвэрлэх юм.

Үндэсний хөтөлбөрийг ойрын буюу 2002.07.01-2005 он, хэтийн буюу 2006-2010 онд гэсэн хоёр үндсэн үе шаттай хэрэгжүүлнэ гэж заажээ.

*Ойрын.* 2002.07.01-2005 онд авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төр ба улс төрийн хүчин нэгдмэл байр суурьтай болж, хүчээ нэгтгэх, эрх зүйн орчныг шинэ нөхцөлд нийцүүлэх, төр засгийн байгууллагын шинэтгэлийг түргэсгэх, авилгалыг бууруулах шинэ загварыг бий болгон хэрэгжүүлж, түүнийг үл тэсвэрлэх уур амьсгалын эхлэлийг тавина.

*Хэтийн.* 2006-2010 онд өмнөх шатанд олсон ололтоо баталгаажуулахын зэрэгцээ авилгалтай холбоотой хэргийн илрүүлэлтийг сайжруулж, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төр иргэний хоорондын итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд өөрчлөлт гаргана.

**Гуравдугаар бүлэгт** үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг дараахь 7 чиглэлд тухайлбал сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, авилгалаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн албыг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах, гүйцэтгэх ба нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудаас авах арга хэмжээ, эдийн засгийг либеральчлах, иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх зэргээр явуулах ажээ.

Энэ удаа бид авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 7 чиглэлийн үндсэн 31 зүйл заалтыг сонгон авч мониторинг үнэлгээ хийсэн. Үүнд:

**1. Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр**

- Авилгалтай холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аливаа сонгуульд нэр дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохыг хориглох /1.а/
- Сонгуульд оролцох улс төрийн намууд сонгуулийн зардал, хандивын талаар сонгууль болохоос өмнө сонгуулийн ерөнхий хороонд танилцуулж, нийтэд мэдээлдэг журам тогтоох /1.б/
- Иргэн, хуулийн этгээдээс сонгуулийн сурталчилгаанд өгч байгаа хандивын хэмжээнд хязгаар тогтоох /1.в/
- УИХ, засгийн газрын гишүүн, төрийн бусад өндөр албан тушаалд томилогдсон, сонгогдсон хүн тангараг өргөхийн өмнө болон бүрэн эрхийнхээ хугацаанд жил бүр хөрөнгө, орлогынхоо тухай нийтэд зарладаг журам тогтоох /1.г/

**2. Авилгалаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр**

- Авилгал үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцлийг тусгайлан судалж, санал дүгнэлт гаргах /2.а/
- Авилгалтай тэмцэх талаар төрийн бүх шатны байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хүлээх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг чангатгах /2.в/
- Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа иргэд, олон нийт, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн эрх үүргийг хүчтэй болгох хөшүүрэг, механизмыг бий болгох /2.г/

**3. Төрийн албыг боловсронгуй болгох чиглэлээр**

- Өндөр албан тушаалтны болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр буюу шинэчлэн баталж, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих иж бүрэн тогтолцоог бий болгох /3.а/

- Хууль тогтоох, шүүх эрх мэдлийн болон хуулийн байгууллага, засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад хяналт, шалгалтыг сулруулснаас буюу удирдлагын алдаанаас шалтгаалж хээл хахууль авилгал авсан тохиолдолд шууд удирддаг сайд, дарга нь ёс зүйн хариуцлага хүлээдэг журам тогтоох /3.б/
- Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилохдоо ил тод, шударгаар өрсөлдүүлэх тогтолцоог боловсронгуй болгох /3.в/
- Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэн, амьдралын баталгааг сайжруулах дэс дараатай арга хэмжээ авах үндсэн дээр тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах /3.д/
- Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнд хяналт тавих механизмыг улам боловсронгуй болгох/3.е/
- Төрийн албан хаагч нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос давсан их хэмжээний хөрөнгөтэй болсон, үүнийгээ хэрхэн олсон тухай тайлбарлаагүй буюу үнэн зөв тайлбар өгөөгүй бол холбогдох эрх бүхий байгууллагаас шалгадаг байх /3.ж/
- УИХ-ын гишүүний үйл ажиллагаа, ёс зүйн талаар гарсан гомдлыг тухай бүр шийдвэрлэж, нийтэд ил тод мэдээлж байх /3.и/
- Төрийн бүх шатны байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх, орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах /3.к/

**4. Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах чиглэлээр**

- Шүүхийн үйл ажиллагааны талаар иргэнээс гарсан гомдлыг нягтлан үзэх, түүнийг шийдвэрлэх журмыг боловсронгуй болгож байх /4.г/

**5. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээ**

1. *Засгийн газар, яам, агентлаг*

- Яам, агентлаг, аймаг, нийслэлд авилгал, хээл хахуультай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг эрхэлсэн зөвлөл байгуулан, төлөвлөгөө, чиглэлтэй ажиллуулах /5.1.б/
- Гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллагын албан хаагчийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, үйл ажиллагаа, ёс зүйд тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцох, тогтвор суурьшилтай ажиллуулах тогтолцоог төлөвшүүлэхэд байнга анхаарах /5.1.г/
- Төрөөс олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор ил тод, нээлттэй болгох, төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг чангатгах /5.1.д/

2. *Аймаг, нийслэл, сум дүүргийн захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд*

- Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр төлөвлөхдөө энэхүү Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг бие даасан хэсэг болгон авч үзэж, нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхой зорилт дэвшүүлэн ажиллах /5.2.а/
- Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад авилгалыг төрүүлэгч буюу өдөөгч хүчин зүйл бий болохгүй байхад байнга анхаарч, авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй ажлын явцыг тогтмол шалган туслах /5.2.в/
- Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг өргөн оролцуулж, идэвх зүтгэлтэй ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг урамшуулж байх /5.2.г/
- Орон нутгаас олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагааг ил тод нээлттэй болгох, төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг чангатгах /5.2.д/
- Авилгалын эсрэг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт жил тутам хүрэлцэх хэмжээгээр тусган тухай бүр санхүүжүүлж байх /5.2.е/

**6. Эдийн засгийг либералчлах чиглэлээр**

- Төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах, зарцуулах үйл ажиллагаа ил тод, олон нийтийн хяналттай байх, төсвийн зарцуулалтын тайланд хяналт тавих механизм бүрдүүлэх /6.д/
- Төсвийн байгууллага төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд хөрөнгийг тендерийн журмаар худалдан авдаг байх /6.е/
- Өмч хувьчлалыг ил тод олон нийтийн хяналтын доор явуулах /6.к/
- Өмч хувьчлалын үйл ажиллагаанд хэвлэл, мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шалгалтын дүн, шийдвэрийн талаар нийтэд байнга мэдээлж байх /6.о/
- Гаалийн үзлэг, шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх /6.ө/

**7. Авилгалтай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр**

- Авилгалын асуудлаар улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүрээнд иргэд, олон нийтийг хамарсан зөвлөлгөөн, семинар, сургалт зохион байгуулах /7.е/
- Авилгалын асуудлаар олон нийтийн санал, хандлагыг хоёр жил тутам судлан дүгнэлт хийж байх журам тогтоох /7.ж/

Эдгээр нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болох яамд, аймаг нийслэлийн захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд дээр хэрхэн хэрэгжиж, биелж байгааг үнэллээ.

**Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажил, хэрэгжилтийн байдал**

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн нэгэн томоохон хэсэг нь Авилгалтай тэмцэх хөтөлбөр юм. Хүний эрх Удирдлага Төслөөс санхүүжүүлэн хийсэн уг хөтөлбөрийн явцад хийсэн үнэлгээний үндсэн зорилго нь Авилгалтай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд аймаг болон яамдууд ямар төлөвлөгөөгөөр, хэрхэн ажиллаж байгааг авч үзэхэд чиглэсэн болно. Ингэхдээ бид юуны өмнө баримтыг хэт харлуулах, өө сэв хайх, эсвэл магтан зулгуйдахыг хүссэнгүй. Харин хөтөлбөртэй эдгээр төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн уялдаж байна, цаашид юунд анхаарах вэ? гэдэгт голлон анхаарсан.

Баримт бичгийн судалгааны хүрээнд нийт 9 яам, 16 аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас авилгалтай хэрхэн тэмцэх тухай хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн талаар ирүүлсэн тайлан, материалд тулгуурлан үнэлгээ мониторинг хийлээ. Бусад аймаг, яамд тайлан мэдээгээ ирүүлээгүй болно.

Үнэлгээнд хамрагдсан яамд ба аймгуудыг дурдвал:

| Яамд | Аймгууд |
|---|---|
| • Хууль зүй дотоод хэргийн яам<br>• Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам<br>• Санхүү эдийн засгийн яам<br>• Гадаад хэргийн яам<br>• Батлан хамгаалах яам<br>• Үйлдвэр худалдааны яам<br>• Дэд бүтцийн яам<br>• Хүнс хөдөө аж ахуйн яам<br>• Байгаль орчны яам | • Увс<br>• Өвөрхангай<br>• Орхон<br>• Баян-Өлгий<br>• Сүхбаатар<br>• Төв<br>• Хэнтий<br>• Дорноговь<br>• Говь-Алтай<br>• Завхан<br>• Хөвсгөл<br>• Ховд<br>• Архангай<br>• Өмнөговь<br>• Дархан-Уул<br>• Булган |

**Бусад:**

- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол

Дээрх яамд, аймаг, агентлаг, иргэдийн хурлын авилгалтай тэмцэх талаар явуулсан ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, төлөвлөгөө, биелэлт гэсэн үндсэн хэсгүүдээр тус бүрд нь авч үзье.

## А. Монгол улсын засгийн газрын яамдууд дахь “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдал

- **Хууль зүй, дотоод хэргийн яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | Б.Цэрэндорж/ Төрийн нарийн бичгийн дарга | Ажлын хэсгийн ахлагч | Тодорхойгүй |
| 2 | Нэр дурьдагдаагүй/ ТЗУГ-ын Дээд байгууллагын шийдвэр, шуурхай мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |
| 3 | Нэр дурьдагдаагүй/ Төрийн захиргааны удирдлагын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Нэр дурьдагдаагүй/ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Нэр дурьдагдаагүй/ Мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээний газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Нэр дурьдагдаагүй/ Хууль зүйн бодлогын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Нэр дурьдагдаагүй/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ахлах мэргэжилтэн | Гишүүн | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

| | **Төлөвлөсөн зүйл** | **Хугацаа** | **Биелэлт** |
|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагааны журам төлөвлөгөөг батлах/5.1.б/ | 2003 он 2, 4-р улиралд | Төрийн нарийн бичгийн даргын 2003 оны 77 тоот тушаалаар батлагдсан. |
| 2 | Харъяа агентлаг, байгууллагуудад авилгалтай тэмцэх талаар зөвлөмж гаргаж хүргүүлэх | 2-р улиралд | 2003 оны 7-р сарын 3-нд 4/1546 тоот албан бичгээр зөвлөмжийг хүргүүлсэн. |
| 3 | ХЗДХЯ-ны аппаратын хэмжээнд Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй танилцуулах | 2003 оны 07 сарын 1-ний дотор | 2003 оны эхний хагас жилийн газар, хэлтсийн тайлангийн хурал дээр газрын дарга нар яамны ажиллагсадад Үндэсний хөтөлбөрийн талаар танилцуулсан. |
| 4 | Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар салбар зөвлөлүүдийн зохиож байгаа ажлын явцын мэдээллийг хэлэлцэх | 2003-2004 | Уг асуудлыг судалж байна. |
| 5 | Хууль тогтооомжид зохих нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал бэлтгэх | 2003-2004 | Уг асуудлыг судалж байна. |
| 6 | Авилгалтай тэмцэх үйл ажиллагаанд Хөндлөнгийн хяналтын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх. Үүнд: Холбогдох ТББ-ын жагсаалтыг гаргах Тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гаргах | Жилдээ | Нийт 78 байгууллага үүнд орсон бөгөөд эдгээр байгууллагууд нь хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж эхний ээлжинд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ТББ-ын нэгдсэн сүлжээ байгуулж улсын бүртгэлд бүртгүүлээд байна. |
| 7 | Олон улсын бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх тухай 1997 оны 12 дугаар сарын 17-ны конвенцид нэгдэн орох талаар судалж санал боловсруулах. | 2003-2004 | Уг асуудлыг толгойлон боловсруулах ГХЯ-аас одоогоор тодорхой санал ирээгүй байна. |
| 8 | Иргэдийн санал гомдлоо гаргаж | 2003 | 2003 онд “Иргэдээс төрийн байгууллага, |

| | | | |
|---|---|---|---|
| | шийдвэрлүүлэх механизмыг улам боловсронгуй болгох.\4.г\ | | албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль" –д нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| 9 | Зарим хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж санал бэлтгэх. | 2003-2004 | Засгийн газар хууль санаачлагчийн хувьд боловсруулж буй хуулийн төслүүдийг "Нээлттэй засаг" ВЭБ хуудсанд тогтмол тавьж иргэдээс авч ирсэн саналыг хүлээн авах ажлыг хийж байна. |
| 10 | Яам болон харьяа агентлаг байгууллагуудад Ёс зүйн дүрмийг оролцооны аргаар боловсруулан батлах ба хэвшүүлэн бүрдүүлэх тогтолцоог байгууллага бүрт нэвтрүүлэх. | 2003 | Уг асуудлыг судалж байна. |
| 11 | Авилгалын талаар мэдээлэгч болон гэрчийг хамгаалах талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулах. | 2003 | Уг асуудлыг судалж байна. |
| 12 | Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар харьяа агентлаг, байгууллагын албан хаагчдад сургалт семинар зохион байгуулах.\7.е\ | 2003 оны 10 сарын 15-ны дотор | 2003 оны 9-р сард тус яамны зөвлөлөөс харьяа агентлаг, албадын салбартай танилцаж цаашдын үйл ажиллагааны талаар заавар зөвлөгөө өгсөн бөгөөд 9 –р сарын 18-ний өдөр "Монгол дахь авилгал ба түүний үр дагавар " сэдвээр уулзалт семинар зохион байгуулсан. |
| 13 | Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авах.\3.е\ | 2004 оны 1-р улирал | Тус яамны хэмжээнд төрийн жинхэнэ албан хаагчдаас зохих журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг авсан бөгөөд нийт 54 хүн үүнд хамрагдсан. |

- **Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | С.Чинзориг, дэд сайд | Салбар зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | Г.Ганболд, ТЗУГазрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 3 | Д.Ганхүү, Хөдөлмөрийн газрын орлогч дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Т.Батсүх ХАНХГазрын хэлтсийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | И.Чулуунхүү ТЗУГазрын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | Гишүүн | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга О.Байгальмаагийн явуулсан бичигт "авилгал, хээл хахуультай тэмцэх, урьдчилан сэргийлэх зөвлөл байгуулсан шийдвэр, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөө болон хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлсэн" тухай мэдэгдсэн боловч ажлын төлөвлөгөө ба биелэлтийн талаар дурьдаагүй байна.

- **Санхүү эдийн засгийн яамны салбар зөвлөлийн тухай**

| | Нэрс, Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Нэр дурьдаагүй. Төрийн нарийн бичгийн дарга | Зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | Нэр дурьдаагүй Эдийн засгийн нэгдсэн бодлого, Төлөвлөлтийн газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 3 | Нэр дурьдаагүй Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Нэр дурьдаагүй Орлого татварын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Нэр дурьдаагүй Төрийн захиргааны удирдлагын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Нэр дурьдаагүй Төрийн сангийн газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Нэр дурьдаагүй Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 8 | Нэр дурьдаагүй Санхүүгийн зах зээл, салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 9 | Нэр дурьдаагүй<br>Нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 10 | Нэр дурьдаагүй<br>Захиргаа, хуулийн хэлтсийн мэргэжилтэн | Зөвлөлийн нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

Төлөвлөгөөний биелэлтэнд салбар зөвлөлөөс хяналт шинжилгээг хийнэ гэжээ.

| | **Төлөвлөсөн зүйл** | **Хугацаа** | **Хариуцах газар** | **Биелэлт** |
|---|---|---|---|---|
| **Авилгалаас урьдчилан сэргийлэх чиглэлээр** | | | | |
| 1 | Салбарын хэмжээнд авилгал үүсэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг тусгайлан судалж, санал дүгнэлт гаргах | 2003.4-р улирал | ТЗУГ | Тодорхойгүй |
| 2 | Авилгалтай тэмцэх талаар яамны газар хэлтэс, тэгээрийн албан тушаалтны хүлээх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг чангатгах | 2003.4-р улирал | Захиргаа, хуулийн хэлтэс | Тодорхойгүй |
| 3 | СЭЗ-ийн холбогдолтой хууль тогтоомж, шийдвэрийг эдийн засгийн бүлэглэлүүдийн эрх ашигт нийцүүлэн гаргах боломжийг таслан зогсоох | 2003. 4-р улирал | ТЗУГ, ТСГ, СЗЗСХБЗГ | Тодорхойггүй |
| 4 | Яамнаас олгох зөвшөөрөл лицензийг цөөрүүлэх, тендер зарлах, шалгаруулах ажиллагааг олон нийтийн оролцоотой ил тод, нээлттэй болгох төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх | 2003-2004 | ТЗУГ, ТСГ, СЗЗСХБЗГ, НБББАЗГ, ЭЗХАБЗГ | Тодорхойгүй |
| **Төрийн албыг боловсронгуй болгох чиглэлээр** | | | | |
| 1 | Яамны дотоод хяналт, шалгалтыг сулруулснаас буюу удирдлагын алдаанаас шалтгаалж хээл хахууль, авилгал гарсан тохиолдолд шууд удирддага дарга нь ёс зүйн хариуцлага тогтоодог журам тогтоох | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилохдоо хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, хээл хахууль авилгал гарсан тохиолдолд шууд удирддаг дарга нь ёс зүйн хариуцлагад хүлээдэг журам тогтох | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 3 | Яамны газар, хэлтсийн ажилд хүнд суртал, шат дамжлагыг багасгах, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох | 2003 | Бүх газар | Тодорхойгүй |
| 4 | Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, түүнд хяналт тавих, ажлыг эрчимжүүлэхТАХ-ийн хөрөнгө орлогын мэдүүлгийг жил бүрийн 2.15-ны дотор гаргуулан авах, орлогын мэдүүлгээ зохих журмын дагуу өгөөгүй бол хуулийн дагуу хариуцлага тооцох | Жил бүр | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 5 | ТАХ нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос давсан их хэмжээний хөрөнгөтэй болсон, үүнийгээ хэрхэн олсон тухай тайлбарлаагүй буюу үнэн зөв тайлбар өгөөгүй бол холбогдох эрх бүхий байгууллагаар шалгуулж байх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 6 | Мэдээллийн орчин үеийн технологид суурилсан, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод явуулах чиглэлээр яамны бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 7 | Яамны газар хэлтэс, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаа, ёс зүйд хяналт тавьж, энэ талаар гарсан гомдлыг тухай бүр шийдвэрлэж ил тод мэдээлж байх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 8 | Гадаадын зээл тусламжийн хуваарилалт, ашиглалтанд тавих хяналтыг эрс чангатгах | 2003 | ТЗУГ, ТСГ, ЭЗХАБЗГ | Тодорхойгүй |
| 9 | Яамны газар, хэлтэс, албан хаагчдын ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх, шагнаж урамшуулах зэрэгт авилгалтай тэмцэх талаарх хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг гол шалгуур үзүүлэлт болгож байх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 10 | Яамны хэмжээнд авилгал үүсэж буй шалтгаан нөхцөлийг жил тутам судалж, түүнд өртөж болзошгүй албан тушаалын нэрсийг гарган урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| **Эдийн засгийг либеральчлах чиглэлээр** | | | | |
| 1 | Төрийн эдийн засгийн бодлого боловсруулахдаа авилгал үүсэх бодит шалтгааныг багасгах чиглэл баримтлах \экспорт, импортод элдэв хязгаарлалт, хориг, квот тогтоохгүй байх гм.\ | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |
| 2 | Төрөөс аж ахуйн үйл ажиллагааг зохицуулахдаа “боломжийн бага оролцоо” зарчмыг баримтлах | 2003 | ЭЗНБЗГ, ТБЗГ, СЗЗСХБЗГ | Тодорхойгүй |
| 3 | Төсвийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн үйлчилгээ, эд хөрөнгийг тендерийн журмаар авдаг байх | 2003 | ЭЗНБЗГ, ТБЗГ | Тодорхойгүй |
| 4 | Татвар ногдуулалт, төлөлтөд тавих үйл ажиллагааг боловсронгуй болгох | 2003 | ТБЗГ | Тодорхойгүй |
| **Авилгалтай тэмцэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр** | | | | |
| 1 | Хэвлэл, мэдээллийн байгууллага яамнаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж хэвлэл мэдээлэлд үнэн зөв мэдээлэл өгдөг тогтолцоог бий болгох | 2003 | ТЗУГ, МХШҮХ | Тодорхойгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Авилгалаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллага, сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж хамтран ажиллах | 2003 | ТЗУГ, МХШҮХ | Тодорхойгүй |
| 3 | Авилгалын чиглэлээр хандивлагч орон, олон улсын байгууллага төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн хэмжээнд тодорхой асуудлаар төсөл хэрэгжүүлэх | 2003 | ЭЗНБЗГ, ЭЗХАБЗГ | Тодорхойгүй |
| 4 | Авилгалын асуудлаар ажил мэргэжлийн онцлогт тохируулан яамны нийт албан хаагчдыг хамруулан, зөвлөлгөөн, семинар сургалт зохион байгуулах | 2003 | ТЗУГ | Тодорхойгүй |
| 5 | Санхүү эдийн засгийн салбар дахь авилгалын асуудлаар олон нийтийн санал хандлагыг 2 жил тутам судлан дүгнэлт хийж байх журам тогтоох | 2003 | ТЗУГ, МХШҮХ | Тодорхойгүй |
| 6 | Долоо хоног бүрийн тав дахь өдрийг иргэдийн өргөдөл, гомдлыг биечлэн хүлээн авах уулзах өдөр болгон хариуцуулан өгч, авилгал, хээл хахууль, хүнд суртал болон бусад асуудлаар санал, хүсэлтийг нь авч ажиллаж байх | 2003 | ТЗУГ, ЗХХ | Тодорхойгүй |

- **Гадаад хэргийн яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | Раднаабазарын Алтангэрэл /Төрийн нарийн бичгийн дарга/ | Салбар зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | Батмөнхийн Ганболд /Төрийн захиргааны удирдлагын газрын захирал/ | Салбар зөвлөлийн гишүүн | Тодорхойгүй |
| 3 | Сүх-Очирын Болд/ Эрхзүй консулын газрын захирал | Салбар зөвлөлийн гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Цэрэнпилийн Доржсүрэн /Бодлого төлөвлөлт мэдээлэл үнэлгээний назрын дэд захирал/ | Салбар зөвлөлийн гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Цогтын Нямсүрэн /Олон талт хамтын ажиллагааны газрын 1 дүгээр нарийн бичгийн дарга/ | Салбар зөвлөлийн гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Өлзийдаваагийн Өнөрмөнх /Хуулийн мэргэжилтэн/ | Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

Салбар зөвлөлөөс 2003 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөнд нийт 11 асуудал тусгаснаас 89,0 хувь нь биелсэн гэж дүгнэжээ. Гэвч төлөвлөсөн ба хэрэгжүүлсэн ажлын тайлангаас харахад үндсэн 7 асуудлыг төлөвлөснөөс 3 нь биелсэн ба үлдсэн 4 нь хэрэгжсэн эсэх нь тодорхойгүй байгаа болно.

| | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Сайдын тушаалаар салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлуулах, зөвлөлийн ажиллах журам боловсруулах, ажлын төлөвлөгөө боловсруулах | 2003 оны эхний хагас жил | Тодорхойгүй |
| 2 | Авилгалын эсрэг хууль, УИХ-ын 2002 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийг сурталчлах сургалт зохион байгуулах | Жилдээ | Тодорхойгүй |
| 3 | Төрийн албан хаагчийн болон дипломат ажилтны ёс зүйн дүрмийг дотоод журманд тусган нэмэлт өөрчлөлт оруулах | Жилдээ | Тодорхойгүй |
| 4 | Зөвлөлөөс 2003 онд зохиох ажлын төлөвлөгөөг газар, хэлтэс, ДТС-уудад хүргүүлэх | 2003 оны эхний хагас жил | Тодорхойгүй |
| 5 | Авилгалтай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч судлах, холбогдох газарт шилжүүлж шийдвэрлүүлэх | Жилдээ | Тодорхойгүй |
| 6 | Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэх. Тайлан мэдээ гаргаж холбогдох газруудад хүргүүлэх | Жилдээ | Тодорхойгүй |
| 7 | Төрийн захиргааны болон тусгай албан тушаал эрхэлж байгаа албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулинд заасан хугацаанд гаргуулан авах ажлыг зохион байгуулах | 2003 оны 12 сараас | Тодорхойгүй |

- **Батлан хамгаалах яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | Нэрс, Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Хошууч генерал С.Баасанхүү<br>Яамны төрийн нарийн бичгийн дарга | Салбар зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | Ч.Батжаргал<br>Яамны хуулийн зөвлөх, сайдын зөвлөлийн хуралдааны асуудал хариуцсан мэргэжилтэн | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |
| 3 | Хурандаа<br>В.Бат-Эрдэнэ Мэдээлэл үнэлгээний газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Хошууч генерал<br>М.Борбаатар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч, ЦУСТГ-ын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Хурандаа<br>Ё.Цэрэндаваа УИХГ-ын дэд дарга бөгөөд штабын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Хурандаа<br>Ц.Цэвээнсүрэн ЕХИС-ийн тэргүүн дэд захирал | Гишүүн | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

| | Зохион байгуулах, ажил, арга хэмжээ | Биелүүлэх хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Батлан хамгаалахын удирдлагаас авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар шийдвэр гаргахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх | Жилдээ | Тодорхойгүй |
| 2 | Засгийн газраас санаачилж, УИХ-д оруулах хуулийн төсөл болон хуулийн нэмэлт өөрчлөлт, засгийн газрын шийдвэрийн төсөлд саналаа хүргүүлэх | Тухай бүр | Тодорхойгүй |
| 3 | Авилгалтай тэмцэх ажлын төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх | Хагас бүтэн жилд | Тодорхойгүй |
| 4 | Авилгал, сахилгын зөрчилгүй тэргүүний хамт олныг шалгаруулж, үр дүнг тооцох | Жилдээ | Тодорхойгүй |
| 5 | Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах | 2 сард | Тодорхойгүй |
| 6 | Авилгалын эсрэг сургалт семинарт оролцох | Жилдээ | Тодорхойгүй |
| 7 | Салбар комиссын хуралдааныг зохион байгуулж, дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлнэ.<br>-тус зөвлөлөөс 2004 онд хийх ажлын төлөвлөгөө батлуулах<br>-ЗХЖШ, БХИС-ийн авилгалтай тэмцэх салбар зөвлөлөөс 2004 онд хийсэн ажлын тайланг хэлэлцэх | 1 сард<br>хагас бүтэн жилд | Тодорхойгүй |
| 8 | Авилгалтай тэмцэх салбар зөвлөлийн ажил байдалтай танилцах, салбар зөвлөлийн гишүүдэд аргазүйн зөвлөгөө өгөх | Улирал бүр | Тодорхойгүй |
| 9 | Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд үзлэг явуулж, зөвлөмж боловсруулан, байгууллага аж ахуйн нэгжид хүргүүлэх | Жилдээ | Тодорхойгүй |
| 10 | Яам, агентлаг, харъяа байгуулагуудад ирүүлсэн сахилга дэг журам, албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нэгтгэн судалж, дүн шинжилгээ хийх, хэрхэн шийдвэрлэсэн байдалтай танилцаж, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх | Улирал бүр | Тодорхойгүй |
| 11 | Салбарын хэмжээнд авилгал үүсч болох шалтгаан нөхцлийг судалж , түүнд өртөж болзошгүй байгууллага, ажил албан тушаалын жагсаалтад өөрчлөлт хийх | Жилд | Тодорхойгүй |
| 12 | Авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар мэдээ, сургалтын материалыг “Соёмбо” сонинд нийтлүүлэх | Сар бүр | Тодорхойгүй |
| 13 | Авилгалын эсрэг сурталчилгааг тогтмол хийж, анги салбар, байгууллагуудад сургалт зохион байгуулах | Жилд | Тодорхойгүй |

- **Үйлдвэр худалдааны яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | Нэрс, албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Д.Сүрэнхор Үйлдвэр худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга | Зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | Ш.Эрдэнэ Төрийн захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |
| 3 | Д.Ганболд ТЗУГазрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Б.Баярсайхан мөн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Д.Дэлгэрцогт засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Г.Алтанцэцэг<br>Мөн яамны ТЗУГазрын ахлах мэргажилтэн | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Д.Тогтохбаяр Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны | Гишүүн | Тодорхойгүй |

| | | | |
|---|---|---|---|
| | гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/ | | |
| 8 | Н.Алгаа<br>Монголын уул, уурхайн үндэсний ассоциацын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор | Гишүүн | Тодорхойгүй |
| 9 | Д.Алтанцэцэг<br>Монголын ноос ноолуурын холбооны гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/ | Гишүүн | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

| | **Хийх ажлын товч агуулга** | **Биелүүлэх хугацаа** | **Биелэлт** |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргуулж, хяналт тавих ажлыг зохион байгуулах | 2 дугаар улиралд | Тодорхойгүй |
| 2 | Төрийн албан хаагчдыг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, үйл ажиллагаа , ёс зүйн асуудалд тогтмол хяналт тавих | Жилийн турш | Тодорхойгүй |
| 3 | Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх яамны салбар зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хөрөнгийг яамны төсөвт суулгуулах арга хэмжээ авах | 7 дугаар сард | Тодорхойгүй |
| 4 | Яамнаас зөвшөөрөл, эрх олгох, сонгон шалгаруулах /тендер/ ажиллагааг холбогдох хууль тогтоомж , эрхийн актын хүрээнд олон нийтийн оролцоотойгоор ил тод нээлттэй болгох | Жилийн турш | Тодорхойгүй |
| 5 | Олон нийт, иргэдээс ирүүлсэн яам боллон харьяа агентлагуудын төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шалгаж тодруулан яамны удирдлагад танилцуулж, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж байх | Жилийн турш | Тодорхойгүй |
| 6 | Яамны эрхлэх асуудлын хүрээний аливаа асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэхдээ авилгалтай тэмцэх, түүнээс сэргийлэх арга хэмжээг авах | Жилийн турш | Тодорхойгүй |
| 7 | Төрийн албан хаагчдын үр дүн мэргэшлийн ур чадварыг үнэлж дүгнэх, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох механизмыг боловсронгуй болгох | 3 дугаар улиралд | Тодорхойгүй |
| 8 | Яамны харьяа агентлагуудад авилгалтай тэмцэх талаар төрөөс тогтоосон хэр хэмжээг хэрхэн биелүүлж байгаа талаар хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх | Жилд 2 удаа | Тодорхойгүй |
| 9 | Яам түүний харъяа агентлагуудын төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийн ашиглалт зарцуулалтад байнгын хяналт тавих | Жилийн турш | Тодорхойгүй |
| 10 | Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг яам түүний харьяа агентлагуудад хэвшүүлэн мөрдүүлэх ажилд байнгын хяналт тавих | Жилийн турш | Тодорхойгүй |
| 11 | Яамны эрхлэх асуудлын хүрээний аливаа асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэхдээ төрийн бус олон нийтийн байгууллагыг идэвхитэй оролцуулах арга хэмжээг авах | Жилийн турш | Тодорхойгүй |

- **Дэд бүтцийн яамны зохицуулах зөвлөлийн тухай**

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | Яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл | Зөвлөлийн дарга | Салбар зөвлөлийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан баталж, хэрэгжүүлэх |
| 2 | Нэр дурьдаагүй. Яамны хуулийн зөвлөх | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |
| 3 | Нэр дурьдаагүй. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Нэр дурьдаагүй.<br>Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Нэр дурьдаагүй.<br>Түлш, эрчим хүчний бодлого, зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Нэр дурьдаагүй. Зам, тээвэр аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Нэр дурьдаагүй. Барилга, хот байгуулалтын борлого, зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 8 | Нэр дурьдаагүй. Мэдээлэл, холбооны технологийн бодлого зохицуулалтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |

Төлөвлөгөө, Биелэлт

Дараахь төлөвлөгөөг гаргасан ба биелэлтийн талаар дурьдаагүй байна. Харин үүнийг хариуцан хийх эздийг дурьджээ.

| | **Төлөвлөсөн зүйл, хийх ажлын товч агуулга** | **Хугацаа** | **Биелэлт/хариуцах эзэн** |
|---|---|---|---|
| 1 | Авилгалтай тэмцэх салбар зөвлөл, түүний ажиллах журмыг сайдын тушаалаар батлуулах | 03-р сар | ТЗУГ- Б.Махбал |
| 2 | Салбарын онцлогт тохируулан тодорхой зорилго зорилт дэвшүүлэх үндсэн дээр тусгай төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах | 03-р сар | ТЗУГ- Б.Махбал |
| 3 | ТАХ-ыг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, үйл ажиллагаа, ёс зүйд тогтмол хяналт тавих | Жилдээ | Төрийн албаны салбар зөвлөл-Б.Цэцэгсайхан |
| 4 | ТАХ-ын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу гаргуулах, тавих хяналтыг боловсронгуй болгох | Жилдээ | ТЗУГ-Б.Цэцэгсайхан |
| 5 | Хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор зохих хөрөнгийг яамны төсөвт суулгуулах | 07 сард | ТЗУГ- Ш.Сономдагва |
| 6 | ТАХ-ийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, хориглосон зүйлийг хуульд заасанаар мөрдүүлэх | 04 сард | Яамны газрууд |
| 7 | Зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, шалгаруулалт хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах | Жилдээ | Яамны газрууд |
| 8 | ХМХ-д гарсан болон иргэд байгууллагаас ирсэн авилгалын холбогдолтой өргөдөл гомдлыг шалгаж тодруулах | Тухай бүр | Яамны газрууд |
| 9 | Хүнд суртал, шат дамжлагыг багасгах | Тухай бүр | Яамны газрууд |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Харилцаа холбоо шуудангийн үйлчилгээнд тусгай зөвшөөрөл олголт хуулийн дагуу явагдаж байгаад шалгалт хийх | 10-р сард | Мэдээлэл холбооны технологийн бодлого, зохицуулалтын газар-Ж.Бат-эрдэнэ |
| 11 | Иргэний нисэхийн авилгалтай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаарх ИНЕГ-ын даргын илтгэлийг сонсох, дүгнэлт өгөх | 08-р сард | Зам тээвэр, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар-Ж.Сэрээтэр |

- **Хүнс хөдөө аж ахуйн яам**

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | Н.Батсуурь Төрийн нарийн бичгийн дарга | Зөвлөлийн дарга | Яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, тендер зарлах, шалгаруулах ажиллагаанд хяналт тавьж ажиллах |
| 2 | Д.Жанцанхорол | Гишүүн | Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчилж авах, яамнаас байгууллага, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, шат дамжлагыг багасгах |
| 3 | Г.Даваадорж | Гишүүн | Төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийн ашиглалт, зарцуулалтын явцад хяналт тавьж ажиллах |
| 4 | Ш.Нямхүү | Гишүүн | Төрийн албан хаагчийн ёс дүрмэнд хяналт тавьж ажиллах |
| 5 | П.Цэдэнбал | Гишүүн | Төрийн албан хаагчийн орон байрны нөхцөлийг сайжруулах, орон сууцны зээлд хамруулах асуудлыг судалж, санал боловсруулан, банк санхүүгийн байгууллагад уламжлах\хөтөлбөртэй уялдаагүй\ |

Төлөвлөгөө, Биелэлт

Биелэлтийн талаар дурьдаагүй ба хариуцах эздийн нэрсийг бичжээ.

| | **Төлөвлөсөн зүйл** | **Хугацаа** | **Биелэлт** |
|---|---|---|---|
| 1 | Авилгалтай тэмцэх талаар гарсан хууль тогтоомжуудыг яамны аппаратын ажилтнуудад таниулж сурталчлах | 05-р сард | ТЗУГ |
| 2 | ТАХ-ийн хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчилж авах | 02-р сард | Д.Жанцанхорол |
| 3 | ТАХ-ийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, үйл ажиллагаа ёс зүйд хяналт тавих, тогтвор суурьшилтай ажиллуулах тогтолцоог төлөвшүүлэх | Жилдээ | ТЗУГ |
| 4 | Яамнаас олгож буй зөвшөөрөл, тендер зарлах, шалгаруулах ажиллагаанд хяналт тавих | 05-08-р сард | МХШҮГ. Н.Батсуурь |
| 5 | Төрийн өмч, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийн ашиглалт, зарцуулалтын явцад хяналт тавих | 07-р сард | Г.Даваадорж |
| 6 | ТАХ-ийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих | Улирал бүр | Ш.Нямхүү |
| 7 | Яамнаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний шат дамжлагыг багасгах | 06-р сард | Д.Жанцанхорол |
| 8 | ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төсөл боловсруулж, батлуулах | 2-р улиралд | Д.Жанцанхорол, Ш.Нямхүү |
| 9 | ТАХ-ийн орон байрны нөхцөлийг сайжруулах, орон сууцны зээлд хамруулах асуудлыг судлах | 2-р улиралд | П.Цэдэнбал |

- **Байгаль орчны яам**

| | Нэрс, албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Я.Адъяа. Төрийн нарийн бичгийн дарга | Дарга | Тодорхойгүй |
| 2 | Г.Энхтүвшин. ТЗУ, хяналтын газрын дарга | Дэд дарга | Тодорхойгүй |
| 3 | Э.Хоролдаваа. байгаль ой, усны нөөцийн газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | С.Энхтүвшин. ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Ю.Дэлгэрмаа. Стратегийн төлөвлөлт, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | С.Бахнаа. Санхүү төсвийн хэлтсийн ахлах мэргэжилтэн | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | А.Сайнбаяр. ТЗУ, хяналтын газрын мэргэжилтэн | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |

Төлөвлөсөн зүйл байхгүй байна.

- **Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас авч буй арга хэмжээ**

| | Нэрс, албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Г.Маналжав | Дарга | Нийслэлийн дүүргүүдэд авилгалтай тэмцэх ГХУСАЗЗ-ийн дэргэд дэд зөвлөл, харъяа газруудад салбар зөвлөл байгуулж ажлын төлөвлөгөө гарган ажиллах талаар чиглэл өгөх, нийслэлийн хэмжээнд авилгалын шалтгаан нөхцлийг тодорхойлох, шаардагдах хөрөнгийн асуудлыг 2003 оны төсөвт тусгах |
| 2 | Д.Цэрэндаш | Гишүүн | УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах |
| 3 | Ц.Болдсайхан | Гишүүн | Авилгалд өртөмтгий байгууллагуудад авилгалаас урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэлт хийх, мөн ажилтануудын ёс зүйн байдалд дүгнэлт хийх |
| 4 | К.Айнагуль | Гишүүн | Нийслэлийн хэмжээнд авилгалын шалтгаан нөхцлийг тодорхойлох |
| 5 | Г.Галсанпунцаг | Гишүүн | УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах |
| 6 | Ч.Баттогтох | Гишүүн | УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах |
| 7 | Ц.Эрдэнэбат | Гишүүн | УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах |
| 8 | Ч.Зоригтбаатар | Гишүүн | Авилгалд өртөмтгий байгууллагуудад авилгалаас урьдчилан сэргийлэх, мөн ажилтнуудын ёс зүйн байдалд дүгнэлт хийх |

Төлөвлөгөө, Биелэлт

| | Хэрэгжүүлэх арга хэмжээ, зохиох ажил | Хэрэгжүүлэх хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Нийслэлийн дүүргүүдэд авилгалтай тэмцэх ГХУСАЗЗ-ийн дэргэд дэд зөвлөл, харьяа газруудад салбар зөвлөл байгуулж ажлын төлөвлөгөө гарган ажиллах талаар чиглэл өгөх | 1 сард | Тодорхойгүй |
| 2 | УИХ-ын 2002 оны 41-р тогтоолоор батлагдсан авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах | Жилдээ | Тодорхойгүй |
| 3 | Нийслэлийн хэмжээнд авилгалын төлөв байдлыг судалж шалтгаан нөхцлийг тодорхойлох | 1 улиралд | Тодорхойгүй |
| 4 | Авилгалд өртөмтгий байгууллагудад авилгалаас урьдчилан | Жилдээ | Тодорхойгүй |

| | | | |
|---|---|---|---|
| | сэргийлэх, мөн ажилтнуудын ёс зүйн байдалд дүгнэлт хийх | | |
| 5 | Нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилд хүнд суртал, шат пдамжлагыг багасгах, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, хяналт тавих | Жилдээ | Тодорхойгүй |
| 6 | Авилгалтай тэмцэх түүнийг таслан зогсоох илрүүлэхэд иргэдийн хүч дэмжлэгийг аван авилгалтай холбоотой гомдол мэдээллийг тухай бүр хүлээн авч холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлүүлэх, иргэдийн мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах | Жилдээ | Тодорхойгүй |
| 7 | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг Нийслэлийнхээ 2003 оны төсөвт тусгах | Эхний хагас жилд | Тодорхойгүй |
| 8 | Авилгалтай тэмцэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, энэ чиглэлээр иргэд аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудаас гаргаж буй санаачилгыг дэмжих, тэдний авилгалтай тэмцэх талаар зохиож байгаа ажлыг уялдуулан зохицуулах, хяналт тавих | Жилдээ | Тодорхойгүй |
| 9 | Хэвлэл мэдээллийн болон ТББ-ын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах | 1 улиралд | Тодорхойгүй |
| 10 | Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэргэжүүлэх асуудлаар Нийслэл дүүргийн төр захиргаа, хууль хяналт , аж ахуйн нэгж байгууллага олон нийтийн төлөөллийг оролцуулсан зөвлөгөөн, семинар сургалтыг зохион байгуулах | Эхний хагас жилд | Тодорхойгүй |
| 11 | Авилгалыг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд бий болгох зорилгоор авилгалын хор уршиг, түүнтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ач холбогдлын талаар иргэдийг соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны чиглэл гаргаж ажиллах | 1 улиралд | Тодорхойгүй |

## Б. Аймгууд дахь "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн байдал

### 1. Увс аймаг

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2003.04.04-ны 23 тоот тогтоолоор тус аймгийн ГХУСАЗЗ-ийн дэргэд 5 ажлын хэсэг байсныг 6 болгон өргөтгөж Авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийг нэмж байуулжээ.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Нэр | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Айтехмет | Ерөнхий прокурор | Дарга |
| 2 | М.Батжаргал | ЗДТГ-ын дарга | Нарийн бичгийн дарга |
| 3 | А.Чимэд-Очир | МХГ-ын санхүү хяналтын албаны дарга | Гишүүн |
| 4 | Д.Буянжаргал | ЦХ-ийн Эдийн засгийн албаны төлөөлөгч | Гишүүн |
| 5 | Батсүх | Шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |

· Дурдсан бүрэлдэхүүнээс Авилгалын асуудал эрхэлсэн ажлын гишүүд өмнө нь аймгийн ГХУСЗЗ-д багтаж байсан бол харин ажлын хэсгийн дарга болон нарийн бичгийн дарга шинээр орсон хүмүүс байлаа.

· Тус ажлын хэсгээс 2003, 2004 онд хийж гүйцэтгэх ажлаа төлөвлөж, түүний хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудаа ГХУСАЗЗ-ийн ажлын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулан, энэхүү зөвлөлөөс зохион байгуулалтын дэмжлэг авч, байнгын холбоотой ажиллах шаардлагатай гэж үзсэн байна.

· Увс аймгийн хэмжээнд авилгалтай тэмцэх үйл ажиллагааны зорилт, чиглэлүүдийг улирал, хагас жил, жилдээ багтаах зэргээр тодорхой цаг хугацаанд харгалзуулсан байна. Энэ нь тухайн зорилт, үйл ажиллагааны хамрах хүрээ, багтаамж зэргээс хамаарах бөгөөд энэ нь тэдгээрийг хэрэгжүүлэхэд илүү бодитой болж өгчээ.

· Авилгалд өртөмтгий салбар, байгууллага, албан тушаалтны талаар судалгаа хийж, мэдээлэл лавлагааны санг 2003 оны эхний хагаст багтаан бүрдүүлэх зорилт тавин аймгийн хэмжээнд удирдах болон дунд шатны албан хаагчдаас авилга авч, өгч болох хүмүүсийн судалгаа гаргаж, орлогын мэдүүлэг авсан гэжээ. Гэсэн ч энэхүү судалгаагаар авилга авч, өгч болох ямар албан тушаалтнууд байсан, мөн тэдний хэнээс орлогын мэдүүлэг гаргуулж авсан, ингэх явцад ямар бэрхшээл тохиолдсон, хэдэн хувьтай биелэлээ олсон талаар бүрхэг байна.

· 2003 онд багтаан авилгалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох нэгж байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл өгч түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцох зорилт төлөвлөгдсөн боловч энэ талаар бодитой зүйл хийгдсэн, түүний жишээ баримт болох зүйл тайланд тусгагдаагүй, мөн энэ чиглэлээр орон нутагт гарсан үр дүнг харах боломжгүй болжээ.

· Учир нь ирүүлсэн тайланд авилгалын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор жилийн төлөвлөгөө батлан цагдаагийн тасаг, албад ажлаа хуваарилан үр дүнг тооцож ажиллав гэсэн нь бүрхэг, хийсвэр зүйл бөгөөд хилээр сум гаргасан Улаангом сумын иргэн Б, Г нарын хэргийг эс тооцвол аймгийн хэмжээнд хэдэн тооны авилгалын гэмт хэргийг илрүүлсэн, үр дүнг хэрхэн тооцсон талаар дүгнэх боломжгүй юм.

· Харин энэ төрлийн гэмт хэргийн гарч буй шалтгаан, нөхцөл болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар төрийн албаны болон хувийн хэвшлийн удирдах ажилтнуудад 2 удаа лекц яриа хийсэн, албан мэдэгдэл өгсөн, гарын авлага тараасан гэжээ. Гэвч энэ зорилт нь нэг жилийн турш төлөвлөгдсөн зүйл ба тухайлбал лекц ярианд чухам ямар албан тушаалын хэдэн хүн хамрагдсан, тэдний уг асуудалд хандах хандлагад ямар өөрчлөлт гарсан, хэдэн газар албан мэдэгдэл өгсөн, хэдэн хүнд, ямар хүрээнд гарын авлага тараасан зэрэг асуултанд хариу авч чадахгүй байна.

· Авилгал хүнд суртлын талаар иргэдтэй 4 цагийн яриа хийж, түүнтэй тэмцэхэд хамтын хүч хэрэгтэй гэдгийг ойлгуулсан гэжээ. Гэхдээ олон нийт энэ яриаг ойлгосныг нь хэрхэн мэдсэн, эсвэл тэд ойлгосноо ямар нэг бодитой үйлдлээр илтгэсэн үү зэрэг нь эргэлзээтэй тодорхойгүй зүйл юм.

· Авилгалтай тэмцэх ажилд иргэд, ТББ- ын дэмжлэг, оролцоог авах, хамтран ажиллах, баталгаатай мэдээлэл өгсөн оролцогчдыг урамшуулах тухай төлөвлөгөөнд байтал тус аймгийн хэмжээнд цагдаагийн хэлтэст авилгалын талаар саяхныг хүртэл мэдээ, мэдээлэл шалгагдаагүй гэсэн юм.

**2. Өвөрхангай аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулан ажиллаж байна.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын дарга | Дарга |
| 2 | Аймгийн засаг дарга | Орлогч дарга |
| 3 | Төрийн захиргаа хууль зүйн хэлтэсийн зөвлөх | Нарийн бичгийн дарга |

| | | |
|---|---|---|
| 4 | Төрийн албаны салбар зөвлөлийн дарга | Гишүүн |
| 5 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 6 | Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн |
| 7 | Тагнуулын хэлтэсийн дарга | Гишүүн |
| 8 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |
| 9 | Аудитын газрын дарга | Гишүүн |
| 10 | Хэвлэлийн хүрээлэнгийн төлөөлөгч | Гишүүн |
| 11 | Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч | Гишүүн |
| 12 | Худалдаа аж үйлдвэрлэлийн танхимын тэргүүн | Гишүүн |
| 13 | НДЭХ-ний ӨВ аймаг дахь зохицуулагч | Гишүүн |

Дээрхи гишүүдийн бүрэлдэхүүнтэй авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн салбар зөвлөлийг аймгийн ИТХТ-ийн дарга бөгөөд ГХУСАЗА зөвлөлийн даргаар ахлуулан хууль хяналт хэвлэл мэдээлэл аймагт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. ТББ -уудын төлөөллийг оролцуулан аймгийн ИТХТ- ийн шийдвэрээр байгуулан ажиллуулж байна.

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж тус зөвлөл нь авилгалийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох дүгнэлт гаргах буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах сургалт сурталчилгаа хийх урьдчилан сэргийлэх үүрэг бүхий ажлыг явуулж байна.

Иргэдээс авилгалын талаар судалгааг авах ажлыг зохион байгуулах ажлыг төлөвлөж тус ажилд аймгийн хэмжээнд авилгалтай холбоотой болон хээл хахуулийн хэрэг зөрчлийн шалтгаан нөхцлийг судлах зорилгоор шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын сүүлийн 5 жилийн судалгааг түүвэрлэн судлахад авилгалтай холбоотой хэрэг гараагүй болно. Харин албан тушаалын гэмт хэрэг сүүлийн 3 жилийн байдлаар 13 гарсан байна.

Иргэдээс авилгалын талаар судалгааг авч 9 сумын 185 хүн хамрагдсан байна. Судалгаанд хамрагсадын 38.5 % нь ямар нэг албан тушаалтанд шан харамж, өгөх гар цайлгахаас аргагүй байдалд орж байсан гэж хариулсан байна. Ингэж иргэдээс санал асуулга авсан хэдий ямар мэргэжилтэй, боловсролтой хүн орсон эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх судалгаагаар авилгалд хамгийн түрүүнд өртөж болзошгүй байгууллагуудыг нэрлүүлсэн байна. Судалгаанд оролцогчдын 40.1 % цагдаа шүүх прокурор, 22.1 % нь сургууль эмнэлэг газрын алба, улсын байцаагчдийг нэрлэсэн байна.

Тус ажлын хүрээнд иргэдийн санал бодол байгууллагуудын хоорондох сургалт семинар сурталчилгааны олон арван ажлыг төлөвлөсөн хэдий ч зарим ажлууд нь биелээгүй нь тайлангаас харагдаж байна. Гэхдээ бас тус аймагт үйл ажиллагаа явуулдаг

хэвлэл мэдээллийн хэрэгсэл "Ноён –Уул" FM 102.6 радио,"Гурвалжин мэдээ" сонинд үндэсний хөтөлбөр хууль тогтоомжийн талаар болон санал асуулгын дүн, дүгнэлтийг иргэдэд мэдээлж байсан байна. Аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 15 удаа нэвтрүүлэг мэдээлэл явуулсан гэж тайланд бичсэн хэдий ч, ямар сонины хэзээний дугаар, хэдний нэвтрүүлгээр явуулсан нь тодорхой биш байна.

Авилгалын эсрэг хууль авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар 2 цагийн сургалт явуулж 1400 гаруй хүн хамрагдсан гэж байгаа нь хэдэн сум оролцсон эсэх нь тодорхойгүй байгаа юм.

Авилгалтай тэмцэх энэ ажилд ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах гэж төлөвлөгөөнд заасан нь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 23 ТББ -ын удирдлагыг хүлээн авч авилгалын эсрэг үндэсний бага хурлын шийдвэрийг сурталчлан, энэ ажилд хамтран идэвхитэй оролцохыг уриалсан байна.

Хуулийн байгууллагуудын ажилтнуудын дунд авилгалын тухай сэдвээр онол практикийн бага хурал зохион байгуулна гэж төлөвлөгөөнд заасан хэдий ч энэ талаар тайланд өгүүлээгүй байгаа учир энэ ажил биелэлээ олж зохиогдоогүй байна.

Орон нутгийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох ялангуяа төрийн бүх шатны байгууллагад оршиж буй хүнд суртал шат дамжлагыг багасгах зөвшөөрлийн тогтолцоог өөрчлөхөд онцгой анхаарч байна гэж тайланд тусгасан нь ямар арга замаар багасгах нь бүрхэг хийсвэр бөгөөд үр дүнд хүрсэн тухай тайланд дурдаагүй байна.

Шүүхийн дэргэд мэдээлэл лавлагааны орон тооны бус алба ажиллуулж иргэдэд үйлчилж байгаа нь өнөөгийн түвшинд иргэдийн саналыг сонсох арга хэрэгсэлийн төдий юм. Шүүх, прокурорын ажлын талаар сонирхсон асуудлаар мэдээлэл авах бололцоог нэмэгдүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх иргэдийн мэдээллийг үнэлж авах нууцлалыг чанд хадгалахад онцгой анхаарч ажиллаж байгаагаар батлагдаж байна.

**2. Орхон аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2003 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор гүйцэтгэх хороог байгуулан ажиллаж байна.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| **Д/д** | **Албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын дарга | Дарга |
| 2 | Аймгийн ИТХ -ын нарийн бичгийн дарга | Нарийн бичгийн дарга |

| | | |
|---|---|---|
| 3 | Аймгийн ЗДТГ дарга | Гишүүн |
| 4 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 5 | Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн |
| 6 | Аймгийн аудитын газрын дарга | Гишүүн |
| 7 | Цагдаагийн хэлтсийн дарга | Гишүүн |
| 8 | Хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн |
| 9 | Тагнуулын газрын дарга | Гишүүн |
| 10 | Аймгийн ХЭҮК ийн Орхон аймаг дахь төлөөлөгч | Гишүүн |
| 11 | Аймгийн нийтийн мэдээллийн төвийн дарга | Гишүүн |
| 12 | Баян өндөр сумын ИТХ - ын дарга | Гишүүн |
| 13 | Жаргалант сумын ИТХ - ын дарга | Гишүүн |

· Авилгал хээл хахуультай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулах аймгийн зөвлөл байгуулагдан 13 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж үйл ажиллагаагаа явуулсан байна.

· Тайлангийн хугацаанд зөвлөлийн хурлыг 3 удаа хийж 17 заалт бүхий жилийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

· Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор Орхон аймгийг "төрийн үйлчилгээний" соёлтой загвар аймаг болгох хүрээнд авилгалтай тэмцэх олон ажил зохиож төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, хүнд суртал чирэгдлийг багасгах, тэр утгаараа авилгатай тэмцэх өргөн хүрээний ажил зохиогдсон гэж тайланд байгаа нь бодит ямар ажил хийгдсэн нь тодорхой бус байна.

· Аймгийн хэмжээнд авилгал хээл хахуулийн талаар 5000 хүний социологийн судалгаа авсан боловч одоо болтол дүн нь гараагүй байгааг анхаарах хэрэгтэй. Гол нь энэ судалгаанаас хамаарч бусад ажлаа зохион байгуулах ёстой байтал судалгааны дүнг харгалзахгүй бусад ажилд орсон нь бүрхэг байна.

· Авилгал шан харамжийн асуудлаар аймгийн авилгалтай тэмцэх зөвлөл, төрийн албаны зөвлөл, аудитын газар, шүүх прокурор, цагдаагийн газрын хооронд мэдээлэл солилцдог журмыг 1-р улиралд тогтооно гэж заасан ч одоо болтол биелэлээ олоогүй байгаа нь төлөвлөгдсөн ажил цагтаа хийгдэхгүй байгааг харуулж буй хэрэг мөн.

· Татвар ноогдуулалт, төлөлт түүний хяналт шалгалтын ажилд холбогдох судалгаа дүгнэлт хийнэ гэж заасан хэдий ч, энэ ажлын талаар тайланд тусгагдаагүй байна.

· Ерөнхийдөө Орхон аймаг авилгалтай тэмцэх ажлын хүрээнд төлөвлөсөн ажлаа амжилттай биелүүлж гүйцэтгэж байгаа нь тайлангаас харагдлаа.

**4. Баян Өлгий аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулан ажиллаж байна.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын дарга | Дарга |
| 2 | Аймгийн ЗДТГ дарга | Дэд дарга |
| 3 | Аймгийн ИТХ -ын Санхүү эдийн засгийн байнгын хорооны дарга | Гишүүн |
| 4 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 5 | Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн |
| 6 | Тагнуулын хэлтэсийн дарга | Гишүүн |
| 7 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |
| 8 | Аудитын газрын дарга | Гишүүн |
| 9 | Татварын хэлтэсийн дарга | Гишүүн |
| 10 | Гаалийн газрын дарга | Гишүүн |
| 11 | Боловсрол соёлын газрын дарга | Гишүүн |
| 12 | Мэргэжлийн хяналтын газрын дарга | Гишүүн |
| 13 | Статистикийн хэлтэсийн дарга | Гишүүн |
| 14 | Хэвлэл мэдээллийн төвийн дарга | Гишүүн |
| 15 | Аймаг хөгжүүлэх сангийн захирал | Гишүүн |
| 16 | Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга | Гишүүн |
| 17 | Эмэгтэйчүүдийн хорооны дарга | Гишүүн |
| 18 | Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга | Гишүүн |
| 19 | Залуучуудын холбооны дарга | Гишүүн |

· Тус аймгаас ирсэн материалд аймгийн авилгалтай тэмцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, тайлан хоёроос өөр төлөвлөгөө, дүрэм журам хүрэлцэн ирээгүй байна.

· Энэ онд багтан төрийн албан хаагчдын орлогын мэдүүлгийг төрийн албаны зөвлөл аймгийн засаг даргын тамгын газарт авахаар тохиролцов гэж тайланд тусгагдсан нь төлөвлөгөөний шинж чанартай буюу хэтийн ажлын талаар өгүүлсэн. Үнээс үзэхэд энэ талаарх цаг хугацаа тодорхой бус байна.

· Төгсөлтийн баяртай холбоотой багш нарт бэлэг өгөхгүй байхыг анхааруулсан гэж заасан боловч энэ талаар өгсөн болон авсан тохиолдолд ямар шийтгэл хариуцлага хүлээлгэх шийдвэр гараагүйг анхаарах хэрэгтэй байна.

**5. Сүхбаатар аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2000 оны 11 сарын 20-ны өдрийн 56 тоот тогтоолоор байгуулсан.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Цагдаагийн хэлтсийн дарга | Нарийн бичгийн дарга |
| 2 | Аймгийн ЗДТГ-ын дарга | Гишүүн |
| 3 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 4 | Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн |
| 5 | Тагнуулын хэлтсийн дарга | Гишүүн |
| 6 | Засаг даргын хуулийн зөвлөх | Гишүүн |
| 7 | Аудитын газрын дарга | Гишүүн |
| 8 | СЭЗТС - ийн хэлтсийн дарга | Гишүүн |
| 9 | ГХУС ийн ахлах байцаагч | Гишүүн |
| 10 | ТЗХЗХ ийн мэргэжилтэн | Гишүүн |
| 11 | Баруун Урт сумын ИТХ тэргүүлэгчдийн дарга | Гишүүн |
| 12 | Хүүхдийн төлөө төвийн дарга | Гишүүн |
| 13 | Эмэгтэйчүүдийн хорооны дарга | Гишүүн |
| 14 | Залуучуудын холбооны дарга | Гишүүн |

· Тус аймгаас ирсэн материалд аймгийн гишүүдийн бүрэлдэхүүн тайлан хоёроос авилгал хээл хахуултай холбогдсон иргэдийн санал хүсэлт , өргөдөл, гомдлын талаар судалгаа хийнэ гэсэн нь биелэгдээгүй байна. Гэхдээ тус аймгийн хэмжээнд авилгал хээл хахуулийн талаар төрийн албанд болон хууль хяналтын байгууллагад гарсан гомдол хүсэлт , шалгагдсан хэрэг зөрчил бүртгэгдээгүй гэж үзсэн байна.

· Мөн авилгалтай тэмцэх баримт бичиг , гарын авлага, зурагт хуудсыг хувилж олшруулан тараах тухай дурдсан боловч мөн хийгдээгүй байна.

· Авилгалтай тэмцэх сургалт сурталчилгааны мэдээллийг төрийн албан хаагчдад болоод ард иргэдэд хүртээмжтэй зөв хийснийг тэмдэглэх хэрэгтэй.

· Төрийн албан хаагчдын хөрөнгө орлого мэдүүлгийг бүрдүүлэх , түүнд хяналт тавих талаар авсан арга хэмжээ нь биелэгдсэн байна.

**6. Төв аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 12 тогтоол гаргажээ.

· Авилгалтай тэмцэх ажлын төлөвлөгөөнд нийт 13 ажлыг төлөвлөж гүйцэтгэхийн зэрэгцээ авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих үндэсний зөвлөлийн албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын 8 төлөвлөгөө боловсруулан гаргасан байна.

· Авилгалтай холбоотой ямар нэгэн санал гомдол авах хайрцаг ажиллуулж байгаа хэдий ч энэ талаар иргэдийн санал гомдол гарсан эсэх, үр дүн ямар байгаа нь бүрхэг байна.

· Тус аймаг нь гүйцэтгэсэн ажлынхаа тайландаа гол төлөв хийж байна гэх буюу цаашид хийх ажлын талаар өгүүлсэн байгаа нь учир дутагдалтай юм. Тодорхой гүйцэтгэсэн ажил бараг байхгүй гэж хэлж болохоор байна. Төлөвлөгөөнд заагдсан ажлуудаас хүртэл байхгүй байгаа нь бүрхэг байна.

**7. Хэнтий аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулан ажиллаж байна.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын дарга | Дарга |
| 2 | Аймгийн прокурор | Нарийн бичгийн дарга |
| 3 | Аймгийн өмгөөлөх албаны дарга | Гишүүн |
| 4 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 5 | Аймгийн засаг дарга | Гишүүн |
| 6 | Тагнуулын хэлтэсийн дарга | Гишүүн |
| 7 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |
| 8 | Төрийн захиргаа хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн |
| 9 | ШШБЕГ дарга | Гишүүн |
| 10 | Мэргэжилийн хяналтын газрын дарга | Гишүүн |
| 11 | Эмэгтэйчүүдийн хорооны дарга | Гишүүн |

· Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авилгалын эсрэг үндэсний бага

хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумд албан байгууллагуудаас гүйцэтгэх ажлын дөрвөн бүлэг, 35 зүйл хэрэгжүүлэх асуудлаар төлөвлөж, зөвлөлийн хуралдаанаас батлан ажиллаж байна.

· Тус аймаг өөрийн төлөвлөж, гүйцэтгэж байгаа ажлаа тайландаа сар бүрээр нь авч бичсэн байна.

· Төв хөдөөгийн төсөвт байгууллагын 220 гаруй эдийн засагч, нягтлан бодох мөнгөтэй ажилладаг, санхүү барьдаг хүмүүст авилгал, түүний эерэг сөрөг үр дагаварын талаар зөвлөгөө өгч, чиглэл баримжаа олгосон нь онцлог зүйл юм.

· Сумдад хийсэн авилгалын эсрэг үндэсний бага хурал олны анхаарлыг татаж байна гэж өгүүлснийг тодруулах шаардлагатай юм. Тус хуралд ямар хүмүүс хамрагдсан хэрхэн явагдсан талаар тайланд тусгаагүй байна.

· Энэхүү ажлуудыг зохион байгуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслийг түлхүү ашиглаж байгаа хэдий ч бүгд хувьд шилжсэн учир мөнгө санхүүгийн асуудал хүндээр тусч байгааг дурдсан нь авууштай юм. Гэвч хөтөлбөрт тусгагдсан “авилгалын эсрэг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсөвт жил тутам хүрэлцэх хэмжээгээр тусган тухай бүр санхүүжүүлж байх” 5.2.е –г эш үндэс болгон санхүүжүүлэхийг анхаарах хэрэгтэй.

· Итгэлтэй утас ажиллуулж байгаа гэсэн боловч уг утсаа хаана байрлуулдаг, хэдэн номерын утас байдаг талаараа иргэдэд сурталчилсан эсэх нь бүрхэг байгаа юм.

· Хяналт шалгалтын ажлын үр дүнд судалгааны дүнгээс цагдаагийн газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, замын цагдаагийн тасгийн байцаагч нар хамгийн их авилгал авдаг гэсэн байна. Үүнийг нийгмийн бүлгүүдээр нь нарийвчлан үзэх шаардлагатай юм.

· Хөрөнгө орлогын мэдүүлгийг аймгийн прокурорын газар, аймгийн шүүхээс бусад газар гаргаагүй байв гэж өгүүлсэн нь аймагт энэ ажил сунжирч байгаагийн илрэл ба тухайн тогтсон хугацаанд заасны дагуу гаргах ёстой билээ.

**8. Дорноговь аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутагт энэ ажлыг зохион байгуулах бүтцийг бүрдүүлэх зорилгоор Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулан ажиллаж байна.

· Аймгийн авилгалтай тэмцэх асуудал эрхэлсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах байдлаар бүрдсэн байна.

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга | Дарга |
| 2 | Аймгийн прокурор | Нарийн бичгийн дарга |
| 4 | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга | Гишүүн |

| | | |
|---|---|---|
| 5 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 6 | Аймгийн засаг дарга | Гишүүн |
| 7 | Аймгийн хянан шалгах хорооны дарга | Гишүүн |
| 8 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |
| 9 | Төрийн захирагаа хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн |
| 10 | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга | Гишүүн |
| 11 | Мэргэжлийн хяналтын газрын дарга | Гишүүн |
| 12 | Аймгийн ахмадын хорооны дарга | Гишүүн |
| 13 | Сайн шанд сумын ИТХ-н тэргүүлэгчийн дарга | Гишүүн |

· Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөрийн 9-д заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөл хариуцан ажиллаж ирлээ.

· Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдлыг ажлын төлөвлөлт болон тайланг харьцуулан үзэхэд тайланд ажлын гүйцэтгэл, биелэлтийг тодорхой тусгаж өгөөгүй байна.

· Авилгалтай тэмцэх, түүнийг таслан зогсоож илрүүлэхэд иргэдийн хүч дэмжлэгийг авах "итгэмжлэгдсэн утас" ажиллуулах санал нь шинэлэг бөгөөд оновтой болж хэрэгжсэн байна.

· Авилгалаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг сонинд 2 удаа зарласан тайлбар ард иргэдэд хүргэсэн байна.

· Албан газрын дарга нар төрийн үйлчилгээг хүргэх үүргээ биелүүлж байгаа байдлыг судлан хяналт тавьж хэрхэн ажилласан нь тодорхой бус байна.

**9. Говь-Алтай аймаг**

· Тус аймагт авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хариуцан ажиллаж байгаа бөгөөд авилгалын эсрэг үндэсний бага хуралд Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн гишүүн , Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга , мөн зөвлөлийн гишүүн АЗДТГ дарга нар оролцож сургалтанд хамрагдсан тухай өгүүлжээ.

· Улмаар дээрх хүмүүс авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт удирдан зохион байгуулж дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу хийгдсэн ажил.

· Аймгийн ИТХ-н дэргэдэх нийгмийн бодлогын хэлтэс, байнгын комиссоос аймгийн төрийн байгууллагын ажилчдад байнгын өндөр хяналт тавьж, авилгалд өртөж буй талаар ард иргэдэд шууд мэдээлж байсан байна.

· Аймгийн авилгалд өртөж болзошгүй агентлагуудад ажилладаг 64 ажилтанг судалгаагаар гарган хяналт тавьсан ба 4 удаа үзлэг шалгалт хийн 5640.0 төгрөгийн татварыг нөхөн оруулав.

· Авилгалаас урьдчилан сэргийлэх үүднээс өртөж болзошгүй төрийн ажилчдын дунд мэдээлэл хийсэн байна.

· Дээрхи ажлуудаас үүдэн тус аймагт аймгийн хэмжээнд гэмт хэрэг 78 хэргээр буюу 29 % -иар буурч гэмт хэрэг илрүүлэлтийн түвшин 4.3 % иар дээшилж 138.8 сая төгрөгний хохирол учруулсан 191 гэмт хэрэг гарсан бөгөөд авилгалын гэмт хэрэг гараагүй гэж дурджээ.

**10. Завхан аймаг**

· Монгол улсын авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дахь заалтын дагуу авилгал, хээл хахуултай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн зөвлөл байгуулж төлөвлөгөө чиглэлтэй ажиллаж байна гэсэн албан тоот ирүүлсэн боловч, төлөвлөгөө, хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан байхгүй байна.

· Тус албан тоотод авилгал хээл хахуултай холбогдсон мэдээ, мэдээлэл одоогоор иргэд байгууллагаас аваагүй болно. гэжээ.

**11. Хөвсгөл аймаг**

· Монгол улсын Их Хурлаас баталсан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5.1 -ийн б-д заасны дагуу аймагт зөвлөл байгуулах асуудал аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2003.04.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж 39 дүгээр тогтоолоор авилгалтай тэмцэх үндэсний зөвлөлийн үүргийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн даргаар ахлуулан ГХУСАЗЗ-д хариуцсан юм."

· Аймгийн ГХУСАЗЗ-ийн 04 дүгээр сарын 3 дугаар хуралдаанаар аймгийн ГХУСАЗЗ -н дэргэдэх авилгал , хээл хахуультай тэмцэх , түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг эрхэлсэн салбар зөвлөлийг байгуулж , авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулж , хяналт тавин ажиллаж байна.

Авилгалтай тэмцэх хөтөлбөрийн гишүүдэд

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ынтэргүүлэгчдийн дарга | Дарга |
| 2 | Аймгийн прокурор | Нарийн бичгийн дарга |
| 4 | Аймгийн аудитын газрын дарга | Гишүүн |
| 5 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 6 | Аймгийн засаг дарга | Гишүүн |
| 7 | Төрийн сангийн хэлтсийн дарга | Гишүүн |
| 8 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |

| | | |
|---|---|---|
| 9 | Төрийн захиргаа хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн |
| 10 | Аймгийн ҮЭ-н дарга | Гишүүн |
| 11 | Радио телевизийн нэгдсэн эрхлэгч | Гишүүн |

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил

· Иргэдээс ирсэн авилгал хээл хахууль ихэссэн гэдэг шалтгаанаар судалгаа авч дүгнэсэн байна.

· Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн гэрээнд ёс зүйн талаар нэмэлт оруулан мөрдөж байна.

· Гадны болоод дотоодын зээл , буцалтгүй тусламжаар ирсэн төрөл бүрийн бараанд аймгийн УЗН-ийн төлөөлөгчийн газартай хамтран хяналт тавьж тайлан мэдээг авч дүгнэлт хийн ажиллаж, улаан загалмайн нийгэмлэгийн болон онцгой комиссын шугамаар ирсэн барааны тараалт ашиглалтын талаар аймгийн аудитын байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргалаа.

· Иргэдийн санал хүсэлтийг авч ажилдаа хэрэглэж байна.

· Мөн аймгийн ИТХ, ЗДТГ -аас суманд ажиллаж буй ажлын хэсэгт , авилгалтай тэмцэх , урьдчилан сэргийлэх талаар семинар өгч, 2003 оны 6 дугаар сард 73 баг, 506 өрхөөр орж 5123 хүнд яриа хийж тэдний санал хүсэлтийг авчаа.

· Уг арга хэмжээний явцад аймгийн хэмжээний төрийн болон төсөвт байгууллагуудад ажлын цагаар, ажлын байранд архи уудаг явдал таслан зогсоогдлоо гэж тайлагнасан нь учир дутагдалтай байгаа юм.

· Авилгалын эсрэг сурталчилгаанд зарим нэг санал ирж байна гэж өгүүлсэн нь учир дутагдалтай, ямар санал ирж байгаагаа тодорхой тусгах хэрэгтэй юм.

· Мөн тус аймагт авилгалтай холбоотой ямар нэг санал гомдол, мэдээлэл гараагүй болно гэж өгүүлсэн нь дээрх хүчин зүйлийг үгүйсгэж байна.

**12. Ховд аймаг**

· Монгол улсын Их хурлаас баталсан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5.1 -ийн б-д заасны дагуу аймагт зөвлөл байгуулан ажиллаж байна. Уг зөвлөлийн гишүүд :

| Д/д | Албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг |
|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга | Дарга |
| 2 | Аймгийн прокурор | Нарийн бичгийн дарга |
| 4 | Аймгийн ерөнхий аудитор | Гишүүн |
| 5 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн |
| 6 | Аймгийн засаг дарга | Гишүүн |
| 7 | Төрийн сангийн хэлтсийн дарга | Гишүүн |
| 8 | Цагдаагийн хэлтэсийн дарга | Гишүүн |

| | | |
|---|---|---|
| 9 | Төрийн захирагаа хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн |
| 10 | Аймгийн ҮЭ-н дарга | Гишүүн |
| 11 | Радио телевизийн нэгдсэн эрхлэгч | Гишүүн |
| 12 | Хэв журмын хэлтсийн дарга | Гишүүн |
| 13 | Аймгийн эдийн засгийн ГХ-тэй тэмцэх дарга | Гишүүн |
| 14 | Аймгийн эдийн засгийн ГХ-тэй тэмцэх албаны мөрдөгч | Гишүүн |
| 15 | ЗЦ-гийн тасгийн байцаагч | Гишүүн |
| 16 | Жаргалант сумын Засаг дарга | Гишүүн |
| 17 | Жаргалант сумын ИТХ-н дарга | Гишүүн |

· Комиссоос саяхан аймгийн цагдаагийн газартай хамтран авилгалын хэрэгт холбогдож болзошгүй албан тушаалтан, иргэдийн орлогын мэдүүлгийн судалгааг авсан байна.

· Нийтийн мэдээллийн төвтэй хамтран тус аймагт Телевизээр 2 удаа авилгалтай тэмцэх төрийн бодлого шийдвэрийг танилцуулах нэвтрүүлэг явуулсан.

· Энэ хяналтыг хийхэд хүндрэлтэй хүнд сурталтай байсан нь тайланг бичсэн байдлаас харагдаж байгаа бөгөөд аймаг орон нутагт үйл ажиллагаа хангалттай явагддаггүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

**13. Архангай аймаг**

· Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөрийн 9-Г-д заасны дагуу аймгийн зөвлөл хариуцан ажиллаж байна.

· Тус хөтөлбөрийг сурталчлах ажил муу хийгдсэн нь харагдаж байна. Нийтдээ аймгийн төвийн иргэдийн дунд 4 удаа зохион байгуулж "Дээж мэдээ " сонинд 2-хон удаа тайлбар хэвлүүлж уншигчдад хүргэснээс энэ нь харагдана.

· Тус аймаг дахь багшийн коллежийн багш нар ямар учраас оюутнуудаас мөнгө авдаг нь тодорхойгүй байгаа нь уг ажлыг зохион байгуулаагүйн илрэл юм. Энэ нь албан ёсоор авах ёстой юм уу, эсвэл хувьдаа авилгал байдлаар авч болно. Харин ямар ч үндэслэлгүй авч байгаа гэсэн тайлбар хангалтгүй юм..

· ХЗДХЯ болон аймгийн засаг даргын тамгын газарт заавал хянуулан мөрдөж буй тул авилгалыг өдөөсөн зөрчил гараагүй байна гэж өгүүлсэн нь уг асуудлаар тодорхой дүгнэлт хийгээгүй, үйл ажиллагаагаа явуулаагүй байгаа нь харагдаж байна. Зөвхөн хяналт хийж авилгалыг зогсооно гэж таамгаар үйл ажиллагаа явуулдаг байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

**14. Өмнө-говь аймаг**

Монгол улсын Их хурлаас баталсан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5.1 -ийн б-д заасны дагуу аймагт зөвлөл байгуулан ажиллаж байгаа ба уг зөвлөлийн гишүүдэд дараахь нэр бүхий хүмүүс оржээ.

| Д/д | Нэрс, албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | А.Үрчээ | Зөвлөлийн дарга | Зохион байгуулах, тайлагнах |
| 2 | С.Сумъяа | Орлогч дарга | Байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах\Зөвлөлийн нийт гишүүдийн хамт\ |
| 3 | Г.Төмөртогоо | Нарийн бичгийн дарга | 1. Аймгийн хэмжээнд авилгалын талаар судалгаа явуулж шалтгаан нөхцөлийг арилгах, цаашид авах арга хэмжээний чиглэл зорилтыг тодорхойлох, 2.авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд идэвхтэй ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага иргэдийг урамшуулах\А.Үрчээгийн хамт\, 3. Байгууллагуудын дунд жил бүр тогтмол явуулдаг дэвжээ тэмцээнийг “Аюулгүй авилгалгүй орчинд амьдарцгаая” сэдвээр зохион явуулах 4.Авилгалтай холбоотой гарын авлага, материал бэлтгэж сум, байгууллага бүрт тараах |
| 4 | Ц.Сумъяа | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Ж.Баярсүрэн | Гишүүн | Нутаг дэвсгэрийн хэмжээнд сүүлийн 10 жилд авилгалтай холбоотой болон хээл хахуулийн хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах\Д.Батмөнхийн хамт\ |
| 6 | Д.Батмөнх | Гишүүн | Нутаг дэвсгэрийн хэмжээнд сүүлийн 10 жилд авилгалтай холбоотой болон хээл хахуулийн хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах\Ж.Баярсүрэнгийн хамт\ |
| 7 | Ц.Жаргалтөгс | Гишүүн | Тодорхойгүй |
| 8 | Ж.Гамбаа | Гишүүн | Орон нутгаас олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарах |
| 9 | О.Болдбаатар | Гишүүн | Тодорхойгүй |
| 10 | Д.Наранчимэг | Гишүүн | Орон нутгийн FM радиогоор тогтмол сурталчлах\Г.Төмөртогоо, Ж.Бүдээ нарын хамт\ |

***Төлөвлөгөө, биелэлт***

Биелэлтийн талаар дурьдаагүй ба хариуцах эздийн нэрсийг бичжээ.

| | Төлөвлөсөн зүйл | Хугацаа | Оролцох байгууллага | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн хэмжээнд авилгалын талаар судалгаа явуулж шалтгаан нөхцөлийг арилгах, цаашид авах арга хэмжээний чиглэл зорилтыг тодорхойлох | 2-р улиралд | Цагдаагийн хэлтэс, Хүний эрхийн төсөл | Тодорхойгүй |
| 2 | Байгууллага бүрт ёс зүйг сахиулах, авилгалаас урьдчилан сэргийлэх асуудлыг эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах | 2-р улиралд | Сумдын зөвлөл | Тодорхойгүй |
| 3 | Авилгалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд идэвхтэй ажиллаж байгаа төрийн | 4-р улиралд | ЗДТГ | Тодорхойгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | болон төрийн бус байгууллага иргэдийг урамшуулах | | | |
| 4 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд сүүлийн 10 жилд авилгалтай холбоотой болон хээл хахуулийн хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлан, түүнийг арилгах арга хэмжээ авах | 3-р улиралд | Прокурор, Цагдаагийн хэлтэс | Тодорхойгүй |
| 5 | Орон нутгаас олгох зөвшөөрөл, лицензийг аль болох цөөрүүлэх, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарах | 3-р улиралд | МХГ, сумдын зөвлөл | Тодорхойгүй |
| 6 | Байгууллагуудын дунд жил бүр тогтмол явуулдаг дэвжээ тэмцээнийг “Аюулгүй авилгалгүй орчинд амьдарцгаая” сэдвээр зохион явуулах | 2-р улиралд | Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасаг, АСЗХолбоо | Тодорхойгүй |
| 7 | Орон нутгийн FM радиогоор тогтмол сурталчлах | Улирал бүр | Говийн долгион мэдээллийн төв, Монгол говь сонин, Говь телевиз | Тодорхойгүй |
| 8 | Авилгалтай холбоотой гарын авлага, материал бэлтгэж сум, байгууллага бүрт тараах | Улирал бүр | ЗДТГ | Тодорхойгүй |

**15. Дархан уул аймаг**

Монгол улсын Их хурлаас баталсан "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5.1 -ийн б-д заасны дагуу аймагт зөвлөл байгуулан ажиллаж байна.

| | **Нэрс, албан тушаал** | **Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1 | Л.Гүнчин, Аймгийн ИТХ-ын дарга | Дарга | Тодорхойгүй |
| 2 | Д.Хаянхярваа, Аймгийн ЗД | Орлогч дарга | Тодорхойгүй |
| 3 | Ц.Даваадорж, Цагдаагийн Газрын дарга | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |
| 4 | Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | П.Юра, Дархан сумын засаг дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Р.Тунгалаг-эрдэнэ, ИТХ-ын нарийн бичгийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 8 | Ч.Болдбаатар, ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 9 | Р.Батжаргал, ЗДТГ-ын ТЗУ, нийгмийн бодлогын хэлстийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 10 | Л.Золбоот, эрүүл мэндийн газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 11 | Д.Банзрагч, мэргэжлийн хяналтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 12 | Г.Батбаяр, Хүүхдийн төлөө төвийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 13 | Л.Банзрагч, Стандартчилал, хэмжилзүйн төвийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 14 | Ш.Лхагвасүрэн, гал түймэртэй тэмцэх хэлстийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 15 | Ш.Булган, ШШГ албаны дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 16 | Г.Энхсайхан, ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн | Гишүүн | Тодорхойгүй |
| 17 | А.Төвшинбат, “Дархан мэдээлэл” төвийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |

Хэдийгээр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн зүйл байхгүй ч Дархан–Уул аймгийн хувьд хөтөлбөрийн хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тус аймгийн Хууль зүйн хэлтсээс эрхлэн гаргаж байгаа “Сонорч” сонинд “Авилгал, ойлголт, мөн чанар”, “Авилгал

ба Монголын хууль цаазны уламжлал онцлог" зэрэг сэдвүүдээр цуврал нийтлэлүүдийг гаргасан байна. "Төрийн мэдээллийн төв" шинээр байгуулж, иргэдэд мэдээлэл байнга өгдөг болсон нь төрийн үйлчилгээг ил тод нээлттэй байлгах чиглэлд дорвитой ажил болсон байна. Дархан-Уул аймаг болон сум дундын шүүх шинээр батлагдан гарсан шүүгчдийн ёс зүйн дүрмийг хэвшүүлэн ажиллаж байгаа ба Сум дундын шүүхэд албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэрэгт холбогдон нэг албан тушаалтан шалгагдаж байгаа ажээ. Өрийн албаны салбар зөвлөлөөс "Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүний бүртгэл, хадгалах журам"-ын дагуу гарган авч ажиллаж байгаа юм байна. Харин хэдэн хүнээс хөрөнгө орлогын мэдүүлэг гаргуулан авч ажилласан тухайгаа дурдаагүй болно. Харин хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч хяналт тавин ажиллаж байгаатай танилцах шалгалт 11 байгууллагад хийснээс 6 нь хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу хөтөлж байгаа нь тогтоогдсон ажээ. 2003 онд Аймгийн засаг даргын зүгээс гаргасан зорилтын дагуу "Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй", "Соёлтой харилцаа-амжилтын үндэс" зэрэг сургалтуудыг аймгийн ажилтан албан хаагчдад зориулан хийсэн байна.

**16. Булган аймаг**

Тус аймаг Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2003 оны 133 дугаар тогтоолоор баталж үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

| Д/д | Нэрс, албан тушаал | Авилгалын ажлын хэсэг дэх үүрэг | Гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Ц.Энхбат/ Амйгийн ИТХ-ын дарга | Зөвлөлийн дарга | Тодорхойгүй |
| 2 | М.Оюунбат/ Аймгийн засаг дарга | Орлогч дарга | Тодорхойгүй |
| 3 | Д.Батчулуун/ Аймгийн ЗДТГ-ын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 4 | Б.Ширчиндорж/ Аймгийн аудитын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 5 | П.Дамба/Аймгийн мэргэжлийн хяналтын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 6 | Т.Батчулуун/ Цагдаагийн хэлтсийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 7 | Ё.Бямбацэрэн/Аймгийн шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн | Тодорхойгүй |
| 8 | Д.Дарьбазар/ Аймгийн ерөнхий прокурор | Гишүүн | Тодорхойгүй |
| 9 | Б.Ууганбаяр/ Гал түймэртэй тэмцэх газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 10 | Н.Очиржав/Аймгийн ЗДТГ-ын СЭЗХТСХ-ийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Ж.Вычеслав/ ШШБА-ны дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 12 | Х.Нямсүрэн/Тагнуулын хэлтсийн дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 13 | Л.Эгиймаа/Боловсрол соёлын газрын дарга | Гишүүн | Тодорхойгүй |
| 14 | З.Хосбаяр/ Сум дундын шүүхийн ерөнхий шүүгч | Гишүүн | Тодорхойгүй |
| 15 | П.Ууганцэцэг/ Аймгийн ЗДТГ-ын ТЗХЗХ-ийн түшмэл | Гишүүн | Тодорхойгүй |
| 16 | Ш.Дариймаа/ Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажилтан | Нарийн бичгийн дарга | Тодорхойгүй |

Тайланд төлөвлөгөөний дагуу ажлаа зохион байгуулж байгаа гэсэн боловч төлөвлөсөн ажлаа дурдаагүй болно. Аймгийн салбар зөвлөл нийт гурван удаа хуралдаж, ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн телевизээр мэдээлэл явуулах, нээлттэй утас ажиллуулах, шийдвэрийг сурталчлах, санал асуулга авах зэрэг 20 гаруй асуудлыг хэлэлцсэн байна. Энэ хүрээнд салбар зөвлөлөөс 180 хүнийг хамруулсан "Авилгал таны эргэн тойронд" сэдэв бүхий санал асуулга явуулсан ажээ. Аймгийн ерөнхий прокурор төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч зэрэг 30 гаруй албан тушаалтанд авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авилгал, хээл хахуулийн гэмт хэргийн талаар 1 цагийн сургалт ярилцлага хийжээ.

**Дүгнэлтүүд**

- Авигалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу бараг бүх яам, аймгууд авилгалтай тэмцэх зөвлөлийг байгуулсан байна.
- Эдгээр зөвлөлүүд нь үндсэндээ төрийн албаны хариуцлагатай ажилтнуудаас бүрдсэн байна. Тэдний ажлын чиг үүрэг тодорхойгүй байна.
- Төрийн бус байгууллага болон иргэний төлөөлөл эдгээр зөвлөлд байхгүй байна.
- Мөн зөвлөлүүд ямар нэг байдлаар ажлын төлөвлөгөө баталсан байна. Агуулгын шинжилгээнээс үзэхэд яам болон аймгуудын ажлын төлөвлөгөө "Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөртэй" бараг уялдаагүй байна.
- Зөвлөлүүдийн ажлын төлөвлөгөөний ихэнхи заалтууд цаг хугацаа заагаагүй, хариуцах эзэнгүй байна.
- Энэ нь төлөвлөгөөг үнэлж дүгнэх боломжийг алдагдуулж байна.
- Зарим газарт ухуулга яриа хийх, авилгалын хор уршигийн талаар теле нэвтрүүлэг хийх зэрэг ажлын эхлэл байгаа боловч энэ нь олон нийтэд хүртээл муутай, тэднийг анхаарлыг татахуйц хэмжээнд хүрээгүй байна.

- Авилгалтай тэмцэх зөвлөлүүд авилгалтай холбоотой тодорхой хэргийг бараг авч хэлэлцээгүй байна.
- “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр” ажил улс орны хэмжээнд хэлбэрийн төдий явагдаж, бодит тодорхой үр дүн гараагүй байна.
- Засгийн газрын зүгээс ч энэ асуудалд ямар нэг байдлаар анхаарал хандуулаагүй байна.

## § Бүлэг 2. АВИЛГАЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАЛ БОДОЛ, ҮНЭЛГЭЭ

### 1. Монгол дахь авилгалын талаарх хүмүүсийн ойлголт

Юуны өмнө бид Монголд авилгал хэрхэн тархсан талаар хүмүүсийн үзэл бодол, үнэлгээг тандсан бөгөөд энэ нь 1999 онд хойш буюу авилгалын талаарх явуулсан анхны санал асуулгаас хойш хэрхэн өөрчлөгдснийг харьцуулан үзвэл доорх дүр зураг гарч байна.

*Хүснэгт 1. Өнөөгийн Монголд авилгал хэр зэрэг газар авсан вэ?*
*/1999 оны санал асуулгатай харьцуулсан байдлаар/*

| | 1999 он | 2004 он |
|---|---|---|
| маш их дэлгэрсэн | 48.8 | 35.7 |
| ер нь дэлгэрсэн | 44.2 | 53.2 |
| тийм их биш ба дэлгэрээгүй | 4.4 | 4.3 |
| мэдэхгүй+хариулаагүй | 2.6 | 6.8 |

Судалгаанд оролцогчдын дийлэнхи олонхи нь /88.9 хувь/ Монголд авилгал дэлгэрсэн хэмээн хариулжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид нь нас, хүйс, боловсрол, намын харъяалал, оршин суух газар зэрэг нийгэм-хүн ам зүйн үзүүлэлтээсээ үл хамаарч нийтээрээ Монголд авилгал нийгмийн бодит үзэгдэл болж хувирсан гэж үзсэн юм. 1999 оны санал асуулгын дүнтэй харьцуулахад авилгалын тархалтын талаарх хүмүүсийн санал бодол төдийлэн өөрчлөгдөөгүй нь илт харагдаж байгаа болно. Мөн бүлгийн ярилцлагын явцад авилгал манай нийгэмд илт газар авсан түгээмэл үзэгдэл гэж олон нийт үзэж байгаа нь ч харагдаж байсан юм.

*Авилгал хот хөдөө аль ч газар байдаг зүйл, хотод их хөдөөд бага гэж ойлгож болохгүй, бүх шатанд байгаа зүйл, авилгалд автаагүй газар орон нутаг, байгууллага гэж өнөөдөр байхгүй, шат шатандаа авилгалд автсан … Дорнод аймгийн холимог бүлгийн ярилцлагаас … Авилгал өнөөдөр хавтгайрч нэлэнхүй болсон гэж боддог, хаана ч очоод ямар нэг ажил бүтээхэд нэг бол танил талаа бараадах, нэг бол гар цайлгаж, шан харамж өгөх болдог … Улаанбаатар хотын Нарантуул захын наймаачдын бүлгийн ярилцлагаас*

Авилгалыг тодорхойлохдоо нийгмээс итгэл үзүүлж олгосон эрх мэдлийг амин хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглах гэж ерөнхий томъёолсон байдаг боловч олон нийтийн дунд түүний талаар янз бүрийн ойлголттой байдаг нь басхүү санал асуулгын дүнгээс харагдаж байна. Санал асуулгын эхэнд бид судалгаанд оролцогсдын

авилгалын тухай хувийн ойлголтыг нээлттэй асуултын тусламжтайгаар тодорхойлохыг оролдож, авсан хариултыг / саналыг / 9 үндсэн категорид хувааж бүлэглэсэн юм. Энэ нээлттэй асуултын хэлбэр нь респондентуудад нэлээд төвөг учруулж, хариулаагүй буюу хариулж мэдэхгүй хүмүүсийн тоо харьцангуй их гарсан /Хүснэгт 2/.

*Хүснэгт 2. Авилгалын тухай ямар ойлголттой вэ?*

| | Хувь |
|---|---|
| Ажил хурдан бүтээдэг | 13.5% |
| Албан тушаалаа урвуулан ашиглах, хүнд суртал | 13.2% |
| Нийгэмд хортой зүйл, хууль бус үйл ажиллагаа | 11.8% |
| Хээл хахууль өгөх | 9.1% |
| Нийгэмд газар авсан | 8.8% |
| Байх л зүйл | 7.1% |
| Байх ёсгүй,тэмцэх хэрэгтэй | 4.9% |
| Хууль сул амьдарлын түвшин муудсанаас | 2.6% |
| Ухамсрын асуудал | 2.1% |
| Хэлж мэдэхгүй | 27.0% |

Хүснэгт 2-оос үзэхэд хүмүүсийн нэг хэсэг нь авилгалыг хялбарчлан өнгөцхөн ойлгож, ихэвчлэн албан тушаалаа урвуулан ашиглах, хүнд сурталтай холбоотой нийгэмд газар авсан хортой нөлөөтэй үзэгдэл гэж үзэж байна. Нөгөө талаас авилгалыг ажлыг хурдан бүтээх чухал хэрэгсэл /13.0/ болон авилгал нь нийгэмд байх зүйл /7.0/ гэж үзэгсдийг хамтад нь авч үзвэл судалгаанд оролцсон таван хүний нэг нь авилгал нэг талаас заавал муу хор үр дагавартай байх ёсгүй, нөгөө талаас тийм ч гаж үзэгдэл биш гэсэн ойлголт ч манай нийгэмд төлөвшиж тогтсоныг харуулж байна. Үүнийг бид ихээхэн аюултай үзэгдэл гэж үзэж байна.

Санал асуулгийн үр дүнд олон нийтийн дунд ерөөс авилгал хэмээх ойлголтыг тодорхойлох, ойлгох талаар дээр дурдсанчлан эерэг сөрөг янз бүрийн хандлага гарсан бол бүлгийн хэлэлцүүлэг болон сурвалжлагын үед хүмүүс басхүү дээрх үзэгдлийг хэрхэн ойлгож буйгаа илэрхийлсэн юм. Түүнээс жишээ болгон хоёр аймгийн бүлгийн ярилцлагын дүнгээс сонирхож болно.

| Ховд | Дорнод |
|---|---|
| • Хүнд юм өгөх гэсэн үг байх, ажлаа бүтээхийн тулд дарга нарт юм өгөхийг хэлдэг.<br>• Хууль бусаар орлого олох, өөртөө ашигтай зүйлийг хүнээс шаардахыг ойлгодог. /*Холимог бүлгийн ярилцлагаас*/<br>• Хүнээс шан шагнал авснаас үүсэх боловуу, гүйцэтгэх ёстой зүйлээ хийгээд цалин дээрээ мөнгө авна гэдэг бол авилгал<br>• Хуулийг ямар нэг байдлаар гажуудуулах хэлбэр юмуу даа<br>• Хуулинд заасан зүйлийг нь тэрнээс нь | • Авилга гэхээр арын хаалгыг ойлгодог, авилга гэдэг үгнээс илүү арын хаалга гэхээр ойлгогдоно<br>• Их хэмжээний мөнгө өгч байж л авилга болох байх<br>• Авилгалыг тодорхой хэлчихэж чадахгүй л байна. Түүнийг манай ард түмэн нэг сайн ойлгохгүй байгаа<br>• Арын хаалга мөнгө төгрөг өгөх авах гэдгийг авилга гэж ойлгож байгаа<br>• Хүн хэрэгцээгээ хуулиас гадуур хангах явдал байх, хүнд мөнгө болгох эрх мэдэл |

| | |
|---|---|
| эсрэгээр нь ашиглах явдал, өөрийгөө үнэд оруулж байгаа хэрэг<br>• Хүний хэрэгцээтэй холбоотой, хүний хэрэгцээ хязгааргүй, эрх мэдлээ урвуулан ашиглаж буй хэрэг<br>*/Багш нар, багийн дарга нар, захиргааны мэргэжилтэн зэргээс бүрдсэн сэхээтний бүлгийн ярилцлагаас/* | байдаг, жишээ нь эмнэлэгт хэвтүүлэх<br>• Танил талаа харахаас эхлээд, мөнгөтэй хүний талд төрийн хүмүүс чинь орж байна шүү дээ<br>*/Дорнод аймаг холимог бүлгийн ярилцлагаас/* |

Зөвхөн дээрх хоёр газрын хувьд бус авилгалын талаарх ойлголт нь бусад аймгууд хийгээд хотын бүлгүүдийн хувьд дээрхийн адил нийтлэгээр энгийн төсөөлөл байсан төдийгүй ерөнхийд нь авч үзвэл бүрхэгдүү, системтэй бус байгаа нь харагдаж байна.

Олон нийтийн хэвшмэл ойлголтоор авилгал бол ямар ч байсан хүмүүс ажлаа бүтээхийн тулд хэн нэгэнд шан харамж, шагнал өгч буй үзэгдэл бөгөөд энэ нь хэн нэгэн төрөөс өөрт олгогдсон эрх нөлөөг худалдаж хууль бусаар ямар нэг зүйлийг арын хаалгаар завших буюу хэн нэгэн шан харамж өгөх замаар өөрийн ажлыг арын хаалгаар ийнхүү бүтээх үзэгдэл болж байна.

Бид судалгааныхаа явцад авилгалын түвшинг байгууллагуудаар нь сонирхоход дараах байдал харагдаж байна / хүснэгт 3 /. Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр хамгийн их авилгалд автсан нь шүүх / 79.0% /, гааль / 78.5-79.6% /, прокурор / 76.9% / бөгөөд харин авилгалд харьцангүй бага өртсөн нь ерөнхийлөгчийн тамгын газар / 42.6% /, хувийн бизнесийн салбар, боловсрол, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд / 44.9-48.6% / байна. Энэхүү дүн 1999 оны байдлаас үндсэндээ ялгагдахгүй юм. 1999 оны санал асуулгын дүнгээс үзэхэд авилгалд хамгийн их автсан нь гаалийн байгууллага / 70.1% /, банк / 69.2% /, шүүх / 46.0% /, УИХ / 39.3% /, татварын алба / 39.0% /, харин авилгалд бага өртсөн нь ерөнхийлөгчийн тамгийн газар байлаа. Эндээс үзэхэд авилгал нь төрийн байгууллагуудад түгээмэл тархсан бөгөөд энэ таван жилийн хугацаанд авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр гарсан ч сөрөг хандлага хэвээр хадгалагдсаар байна.

*Хүснэгт 3. Байгууллагуудад дахь авилгалын байдал*

| | Ихээхэн | Дунд зэрэг | байхгүй | Дундаж |
|---|---|---|---|---|
| 44 шүүх | 79.0 | 18.9 | 2.1 | 1.23 |
| 48 гааль /нисэх / | 78.5 | 19.0 | 2.5 | 1.24 |
| 49 гааль /хил орчмын боомт / | 79.6 | 16.5 | 4.0 | 1.24 |
| 45 прокурор | 76.9 | 21.1 | 2.0 | 1.25 |
| 47 цагдаа /замынцагдаа / | 71.2 | 26.0 | 2.8 | 1.32 |
| 46 цагдаа /хэв журамын / | 70.6 | 26.0 | 3.4 | 1.33 |
| 58 татварын алба | 67.6 | 27.5 | 5.0 | 1.37 |
| 57 газрын алба | 66.8 | 28.4 | 4.9 | 1.38 |
| 43 нийслэл орон нутгийн захиргаа | 63.6 | 33.0 | 3.4 | 1.40 |
| 37 улс төрийн намууд | 63.7 | 32.0 | 4.3 | 1.41 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 42 төрийн өмчийн хороо | 59.1 | 35.8 | 5.1 | 1.46 |
| 41 яам агентлаг | 56.8 | 39.1 | 4.1 | 1.47 |
| 51 эмнэлэг улсын | 55.5 | 38.2 | 6.3 | 1.51 |
| 38 УИХ | 56.4 | 35.7 | 7.9 | 1.51 |
| 53 боловсролын байгууллага улсын | 55.3 | 37.8 | 6.9 | 1.52 |
| 39 засгийн газрын танхим | 55.8 | 34.7 | 9.5 | 1.54 |
| 59 өр барагдуулах байгууллага | 53.7 | 37.7 | 8.6 | 1.55 |
| 56 банк | 54.8 | 31.5 | 13.7 | 1.59 |
| 60 хөрөнгийн бирж | 50.9 | 33.7 | 15.3 | 1.64 |
| 52 боловсролын байгууллага хувийн | 48.0 | 37.0 | 15.0 | 1.67 |
| 55 бизнесийн байгууллага үйлдвэрлэлийн | 44.9 | 41.7 | 13.5 | 1.69 |
| 54 бизнесийн байгууллага үйлчилгээ | 45.3 | 39.6 | 15.1 | 1.70 |
| 50 эмнэлэг хувийн | 48.6 | 33.0 | 18.5 | 1.70 |
| 40 ерөнхийлөгчийн тамгын газар | 42.6 | 37.5 | 19.9 | 1.77 |

*шкалын утга 1-ихээхэн, 2- дунд зэрэг, 3—бараг байхгүй

Фактор-анализын тусламжаар авилгалын хэв загварыг тодорхойлдог дараах таван бүлэг байгууллагуудыг тодруулсан болно / Хүснэгт 4 /. *Нэгдүгээр бүлэгт* төрийн захиргаа, улс төрийн намууд, орон нутгийн захиргаа гэх мэт байгууллагууд багтаж байна. Өөрөөр хэлбэл энэ бүлэг бол цэвэр улс төрийн болон захригааны институцийн авилгалын шинж байдлыг агуулдаг юм гэж үзэж болно. *Дараагийн бүлэгт* хувийн бизнесийн байгууллагууд орсон ба энэ нь бизнесийн хүрээний авилгалын хэв загварыг илэрхийлсэн юм. *Гурав дахь бүлэг* бол цагдаа, гааль зэрэг байгууллагуудаас бүрдсэн. *Дөрөвдүгээр бүлэгт* банк, санхүү, татварын газар, газрын алба зэрэг байгууллагууд багтдаг. Сүүлийн *тав дахь бүлгийг* прокурор, шүүхийн байгууллагууд бүрэлдэж байна.

Фактор-анализын энэхүү дүнгээс үзэхэд манайд авилгал нэлээд нарийн зохион байгуулалттай болж системт шинжийг агуулдаг болсон гэж дүгнэж болно. Шинжилгээний явцад илэрсэн авилгалд автсан таван бүлэг байгууллагууд бол нийгмийн үйл ажиллагааны тодорхой салбарыг бүрдүүлж авилгалын тодорхой хэлбэр / улс төр, бизнес, цагдаагийн г.м ./ - ийг төлөөлөх болсон нь илэрхий байна.

*Хүснэгт 4. Авилгалд өртсөн байгууллагуудын фактор-анализын дүн*

| | Фактор | | | | |
|---|---|---|---|---|---|
| Rotated Factor Matrix | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 39 засгийн газрын танхим | 0.89 | | | | |
| 38 УИХ | 0.87 | | | | |
| 37 улс төрийн намууд | 0.57 | | | | |
| 42 төрийн өмчийн хороо | 0.57 | | | | |
| 40 ерөнхийлөгчийн тамгын газар | 0.55 | | | | |
| 41 яам агентлаг | 0.52 | | | | |
| 43 нийслэл орон нутгийн захиргаа | 0.42 | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 54 бизнесийн байгууллага үйлчилгээ | | 0.83 | | | |
| 55 бизнесийн байгууллага үйлдвэрлэлийн | | 0.80 | | | |
| 50 эмнэлэг хувийн | | 0.63 | | | |
| 52 боловсролын байгууллага хувийн | | 0.55 | | | |
| 60 хөрөнгийн бирж | | 0.48 | | 0.447 | |
| 46 цагдаа /хэв журамын / | | | 0.74 | | |
| 47 цагдаа /замынцагдаа / | | | 0.73 | | |
| 48 гааль /нисэх / | | | 0.50 | | |
| 49 гааль /хил орчмын боомт / | | | 0.41 | | |
| 51 эмнэлэг улсын | | 0.31 | 0.38 | | |
| 56 банк | | 0.38 | | 0.604 | |
| 59 өр барагдуулах байгууллага | | | | 0.567 | |
| 58 татварын алба | | | 0.35 | 0.531 | |
| 57 газрын алба | | | | 0.474 | |
| 53 боловсролын байгууллага улсын | | | 0.30 | 0.324 | |
| 45 прокурор | | | | | 0.90 |
| 44 шүүх | | | | | 0.73 |
| Explanatory power=49.9% | 13.9% | 11.6% | 9.7% | 8.0% | 6.6% |

Фактор анализын дээрх дүнгээс харахад таван бүлэг байгууллагууд нь тус бүрдээ авилгалын жин, хандлагыг үүсгэж чадсан бөгөөд нарийвчлан үзвэл байгууллага тус бүрдээ авилгалын хэмжээ жишгийг бий болгожээ.

Ярилцлагын судалгааны явцад бүлгийн гишүүд авилгалд өртсөн байгууллагын талаар нэлээдгүй ярьсан бөгөөд тэднээс хамгийн их давтагдаж байсан хандлагуудыг доор жагсаан бичлээ.

| Авилгалд ямар байгууллага хамгийн их өртдөг вэ ? |
|---|
| • Авилгалыг эрхтэн дархтанууд, удирдах ажилтнууд авч байна, засгийн газар, УИХ-ын гишүүд болон бусад удирдлагын хүмүүс<br>• Эмнэлэг, боловсролын зэрэг газарт авилгал илүү их гарч байна, хөдөөний хүмүүст эмнэлэгээс маягт авч хувиараа хот руу ирэхэд бүр жишиг тогтсон гэсэн, хүүхдээ сургуульд оруулна гэхэд танил тал мөнгө хэрэгтэй болно<br>• Хүмүүст тохиолдож байгаагаар бол сүүлийн үед захиргааны газрууд, татвар, боловсролын газар дээр авилгал маш их байна<br>• Хуулийнхан авилгалыг авч байгаа гол хүмүүс, шүүх, цагдаа гээд хуулийн байгууллага нь өөрөө авилгалын гол уурхай мөн шүү дээ<br>*/Аймгууд болон Улаанбаатарын бүлгийн ярилцлагаас/* |

**2. Авилгалын шалтгаануудын үнэлгээ**

Авилгалын шалтгааныг тодорхойлох нь уг нийгмийн үзэгдлийн мөн чанарыг тайлбарлан таниулах, авилгалтай тэмцэх бодит, үр нөлөөтэй бодлогыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Манай судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчид авилгалын янз бүрийн шалтгааныг 3 баллаар үнэлсэн болно. Судалгаанд оролцогсод авилгалын гол шалтгааныг ёс суртахууны доройтол буюу “хүмүүс мөнгийг хэт шүтэх болсон” / 74.5% /, шүүх засаглалын буруу үйл ажиллагаа буюу ”хууль хяналтынхан авилгалын хэргийг шудрагаар шийддэггүй” / 74.2% /, төрийн албан хаагчдын тайлагнахгүй байдал буюу ” албан тушаалтнууд эрх мэдэлтэй ч хариуцлага хүлээдэггүй” / 73.8% / хуулийн хэрэгжилт хангалтгүй / 70.4% / зэрэг зүйлүүдтэй голчлон холбон үзэж байгаа юм /Хүснэгт 4/.

Монголд авилгалд нөлөөлөх хүчин зүйлс, тэдгээрийн талаар олон нийтийн үнэлгээ нь 1999 оноос хойш бараг өөрчлөгдөөгүй байгааг анхаарах нь чухал юм. 1999 оны санал асуулгын дүнгээс үзэхэд авилгалд нөлөөлөх хүчин зүйлсийн эрэмбийн дагуу албан тушаалтнууд бага хариуцлага хүлээдэг / 53.5% /, өмч хувьчлал шудрага бус / 49.9% /, хуулийнхан шудрага бус ханддаг / 40.6% /, ёс суртахууны доройтол / 40.4% / зэрэг зүйлүүд дээгүүр үнэлгээ авсан юм.

*Хүснэгт 4. Авилгалын шалтгааны үнэлгээ*

| | их нөлөөтэй | дундаж нөлөөтэй | бараг нөлөөгүй | Дундаж |
|---|---|---|---|---|
| 22 хүмүүс мөнгийг хэт шүтэх болсон | 74.5 | 19.9 | 5.6 | 1.31 |
| 21 хууль хяналтынхан авилгалын хэргийг шудрагаар шийддэггүй | 74.2 | 20.1 | 5.8 | 1.32 |
| 19 албан тушаалтнууд эрх мэдэлтэй ч хариуцлага хүлээдэггүй | 73.8 | 17.0 | 9.2 | 1.35 |
| 15 авилгалын эсрэг хууль байгаа ч тэр нь хэрэгжилт муу байна | 70.4 | 19.3 | 10.3 | 1.40 |
| 14 авилгалын эсрэг хууль тогтоомж боловсронгуй биш байна | 68.0 | 23.6 | 8.4 | 1.40 |
| 9 эрх мэдэл үүрэг хариуцалгын холбоо сул | 63.7 | 26.8 | 9.5 | 1.46 |
| 18 гадаадын зээл тусламжийг зориулалтын бусар ашигладаг | 62.9 | 27.2 | 9.8 | 1.47 |
| 12 хүмүүс ердийн мэт хүлээж авдаг болсон | 61.7 | 29.2 | 9.1 | 1.47 |
| 16 төрийн албан хаагчийн орлого бага | 63.0 | 26.1 | 10.9 | 1.48 |
| 8 зах зээлийн тогтолцоонд шилжсэн | 57.8 | 31.8 | 10.4 | 1.53 |
| 11 өмч хувьчлал шудрага биш явагдаж байгаа | 57.7 | 31.2 | 11.1 | 1.53 |
| 17 ерөөсөө хүмүүсийн ёс суртахуун унаж эх захаа алдсан | 53.6 | 31.6 | 14.8 | 1.61 |
| 10 хүмүүсийн амжиргаа дорой болсон | 51.8 | 28.5 | 19.7 | 1.68 |
| 13 гадаадын орнуудын нөлөөнд автсан | 46.6 | 25.9 | 27.5 | 1.81 |
| 20 манай уламжлал ёс заншлаас улбаатай | 29.1 | 17.4 | 53.5 | 2.24 |

*шкалын утга 1-их нөлөөтэй, 2- дунд нөлөөтэй, 3—бараг нөлөөгүй

Цаашид авилгалын гарч буй шалтгаануудыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор бид фактор-анализын аргаар дөрвөн бүлгийг тодруулан гаргасан /Хүснэгт 5/.

*Хүснэгт 5. Авилгалын шалтгааны фактор-анализын дүн*

| Шалтгаан | Фактор | | | |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 17 ерөөсөө хүмүүсийн ёс суртахуун унасан | 0.58 | | | |
| 10 хүмүүсийн амжиргаа дорой болсон | 0.44 | | | |
| 16 төрийн албан хаагчийн орлого муу байгаа | 0.40 | | | |
| 18 гадаадын зээл тусламжийг зориулалтын бусар ашигладаг | 0.39 | | | |
| 11 өмч хувьчлал шудрага биш явагдаж байгаа | 0.38 | | | |
| 12 хүмүүс ердийн мэт хүлээж авдаг болсон | 0.36 | | | |
| 15 авилгалын эсрэг хуулийн хэрэгжилт муу байна | | 0.65 | | |
| 14 авилгалын эсрэг хууль тогтоомж боловсронгуй биш | | 0.61 | | |
| 21 хууль хяналтынхан авилгалын хэргийг шудрагаар шийддэггүй | | 0.52 | | |
| 13 гадаадын орнуудын нөлөөнд автсан | | | 0.65 | |
| 8 зах зээлийн тогтолцоонд шилжсэн | | | 0.54 | |
| 22 хүмүүс мөнгийг хэт шүтэх болсон | | | 0.47 | |
| 19 албан тушаалтнууд эрх мэдэлтэй ч хариуцлага хүлээдэггүй | | | | 0.69 |
| 20 манай уламжлал ёс заншлаас улбаатай | | | 0.30 | -0.54 |
| 9 эрх мэдэл үрэг хариуцлагын холбоо сул | | | | |
| Explanatory power=32.9% | 16.8% | 8.6% | 4.4% | 3.2% |

Бидний гаргасан хүчин зүйлсийн моделийн тайлбарлах чадал харьцангуй өндөр буюу 32.9% байна. *Нэгдүгээр бүлэг* шалтгааныг респондентууд нь амжиргааны түвшин буурсантай холбож авч үзэж байна. *Хоёрдугаар бүлэг* шалтгааныг албан тушаалтнуудын тайлагнах, хариуцлага хүлээх сул байдалтай холбож авч үзэж болно. *Гурав дахь бүлэг* шалтгааныг авилгалтай тэмцэх хуулийн боловсронгуй бус байдал, түүний хангалтгүй хэрэгжилтэй холбоотой юм. Эцэст *дөрөв дахь бүлэ*г шалтгааныг зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нэгдэн орсонтой холбож авч үзэж болно.

Шилжилтийн гэгдэх энэ үеүдэд манай орны хүн амын амжиргааны түвшин нэлээд уналтанд орж олонхи өрх гэрүүдэд санхүүгийн хүндхэн ачаа ноогдсон юм. Судалгаанд оролцогчид ерөөсөө манай нийгэмд ядуурал, амжиргааны уналт нүүрлэсэн нөгөө талаас шударгаар хөдөлмөрлөж баялгийг бүтээх зах зээлийн ухамсар сайн төлөвшиж амжаагүйгээс нийт хүмүүсийн сэтгэлгээнд амар хялбараар мөнгө олох, гэнэт баяжих гэсэн хандлага байдагтай авилгалын шалтгааныг холбон үзжээ. Мөн төрийн албан хаагчид ч өөрт өгөгдсөн албан ёсны боломжыг орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон хувиргаж байгаа нь мөн л тэдний амжиргаа, хэрэгцээгээ хангах чадвар дорой /0.40/ байгаатай холбоотой гэжээ.

Төсвийнхөн ялгаагүй өөрсдийнх нь амьдрал хэцүү ш дээ, Жишээ нь манай багийн дарга хүмүүсийг өөр дээрээ саатуулах замаар л мөнгө олдог. Манай нэг найзын охин их сургуульд сурдаг, тэр хоёр жилийн өмнө явах болсон, тэгээд ядуу амьдралтай хүүхдийн төлбөрийг төрөөс даадаг гэдгийг дуулаад хороонызоо засаг даргад 50000 төгрөг бас дээр нь нэг хонины мах өгч байж нэн ядуу гэсэн тодорхойлолтыг цохуулж авсан, энэ бол зөвхөн манай найз биш өөр хүмүүс ч өгсөн, иймэрхүү байдлаар гар харж асуудлыг удааж хүндрүүлдэг.

*С тэй хийсэн ярилцлага*

Судалгаанд оролцогчид авилгалын нэг бүлэг шалтгааныг төрийн албан хаагчдын эрх мэдэл, үүрэг хариуцлагын уялдаа холбоо сул, эрх мэдэл эзэмшихийн хэмжээгээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарлах явдал тааруу байгаатай холбож үзсэн. Албан тушаалтнууд эрх мэдэлтэй ч үүрэг хариуцлага хүлээдэггүй, нийгмийн өмнө ажил үүргээ тайлагнахгүй, наад зах нь орлогоо шударгаар мэдээлдэггүй байдал нь авилгалыг даамжруулж байна гэж тэд үзсэн болно.

Авилгалтай тэмцэх эрхзүйн таатай орчин үгүй, авилгалын эсрэг хуулийн боловсронгуй бус байдал нь энэхүү үзэгдэл цэцэглэн бий болох бас нэг томоохон шалтгаан болох нь харагдаж байна. Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үеэр авилгалтай тэмцэх эрхзүйн орчин хангалтгүй байгаа нь энэхүү гэмт хэрэг илрэхгүйгээр далдуур нийгэмд тархах үндэс болж, түүнчлэн нэгэнт илэрсэн авилгалын гэмт хэрэг хуулийн дагуу шийдвэрлэгдэх явцад саад учруулах болсон тухай судалгаанд оролцогчид ярьж байв.

Судалгааны явцад гарч ирсэн авилгалын үндсэн нэг бүлэг шалтгаан нь улс орон зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд элсэн орсонтой холбоотой гэжээ. Анкет судалгаанд оролцогчдоос улс орон зах зээлд орсноос, хүмүүс мөнгийг хэт шүтэх болсноос манайд авилгал дэлгэрч буй талаар хариулсан бол бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын явцад ерөөс авилгал өгч авалцах нь манай нийгэмд тогтсон нэг хэм хэмжээ, жишиг болсон бөгөөд харин үүнд хүмүүс хүмүүс бүхнээс нэгдүгээрт мөнгө, эдийн ашиг сонирхлоо тавьж байгааг онцолж байлаа.

Ярилцлагын явцад хүмүүсээс хүнд суртлыг авилгалын нэг томоохон шалтгаан мөн гэж үзэн, байгууллагууд дахь шат дамжлаг, зөвшөөрлийн олон эрх мэдлийн шатлал нь хүнд суртлыг улам гааруулж, тэр хэрээр эрх мэдлээ ашиглан хүиүүст саад учруулах, эдийн засгийн хавчилтад оруулах нь элбэг болсон гэж тэд ярьж байв.

Авилгал авч өгөлцөх шалтгаан нь хүнд суртал гэж бодож байна. Хүний өдөр тутмын амьдралд тохиолддог захиргаа, эмнэлэг, сургууль, газрын, татварын, лицензний гээд хаа нэг газар руу ороход үүдний жижүүрээсээ эхлээд угтдаг түгээмэл харьцаа бол хүнд суртал шүү дээ. Хүнд шууд л хаан дээр ороод ирэв үү гэсэн сэтгэгдэл төрнө. Тэгээд л үүдний хүнд таарсан авилгалын хамгийн бага хэлбэрээс эхлээд өгөөд ажлаа ахиулж гарна даа. Би өөрийн жишээ хэлье, манай авгай төрөх гээд арай дээр болов уу гээд 1-р эмнэлэгт бүртгүүлэх гэтэл манайх ямар ч бололцоогүй, харъяалал руугаа яв гээд байснаа юм гаргаад өгөнгүүт бүртгээд л авч байгаа юм. Дараа нь яг төрөх гээд очсон байхад дуудлагын асрагч нь бас хөдөлж өгөхгүй, ааш гаргаад байхаар нь эхнэрээ бодоод чихрийн набор өгсөн чинь хөл нь хөнгөрөөд л явчихсан, хүн болгон өөр өөрийнхөө хүрээнд хүнд суртал гаргана. Энэ нь өөр өөрийнхөө авилгалын жишгийг бий болгож буй хэрэг

*/Улаанбаатар хот бүлгийн ярилцлагад оролцогчийн хувийн туршлага/*

### 3. Авилгалын үр дагаврын талаарх хүмүүсийн үнэлгээ

Авилгалын нийгмийн үр дагаврын талаарх олон нийтийн санал бодол, байр суурийг судлахад сонирхолтой дүн ажиглагдаж байна. Олон нийт үзэж байгаагаар авилгал нь нийгмийн үр дагавраар нийгмийн тогтворгүй байдал /гэмт хэргийн өсөлт, баян хоосны ялгаа ихсэх / болон нийгмийн шудрага бус байдал бий болоход сөрөг нөлөөлөл үзүүлдэг юм / Хүснэгт 6 /.

Харин авилгалын сөрөг нөлөөг онцлохын зэрэгцээ респондентуудын үлэмжхэн хэсэг нь түүний эерэг үр дагаврыг дурьдаж байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Тухайлбал, авилгал нь ажил хэргийг хурдан бүтээхэд тустай гэсэн зүйлийг хариулагсдын 71.7 хувь, мөн хохирох хүнгүй / 35.4% /, хүнд суртлыг багасгахад ачтай / 34.8% / буюу гурван хүний нэг нь үзэж байгаа нь сэтгэл түгшээж байна. Энэ нь манай нийгэмд авилгалыг зөвтгөх явдал нь бодит болж, цаашид нийгэм бүхэлдээ авилгалын учруулж буй хор уршиг, сөрөөг нөлөөллийн талаар сурталчилгаа хүмүүжлийн ажил өрнүүлэхэд шийдвэртэй алхам хийх шаардлагыг тод гэрчилж байна.

*Хүснэгт 6. Авилгалын үр дагаврын хүмүүсийн үнэлгээ*

| Үр д а г а в а р | Тийм | яаж ч магадгүй | үгүй | Дундаж* |
|---|---|---|---|---|
| 32 гэмт хэрэг өсөх хөрс суурь болно | 76.3 | 19.2 | 4.5 | 1.28 |
| 26 хүний эрх зөрчигдөнө | 77.0 | 17.8 | 5.2 | 1.28 |
| 31 баян хоосны ялгаа даамжирч нийгмийн байдал тогтворгүйтнэ | 77.7 | 16.2 | 6.2 | 1.29 |
| 28 өмч хувьчлал шудрага бус явагдах магадлалтай | 73.2 | 23.0 | 3.8 | 1.31 |
| 33 шудрага энэрэнгүй байдалд харшилна | 75.8 | 16.3 | 7.9 | 1.32 |
| 24 ажил хэрэг хурдан бүтнэ | 71.7 | 20.7 | 7.5 | 1.36 |
| 35 гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл алдарна | 70.7 | 21.9 | 7.4 | 1.37 |
| 25 иргэн хүнд материаллаг хохирол учирна | 69.2 | 22.2 | 8.7 | 1.40 |
| 23 үндсэний аюулгүй байдалд хохирол учируулна | 62.5 | 34.4 | 3.1 | 1.41 |
| 29 төр засаг хууль ёс ихээр хохирно | 64.7 | 23.3 | 11.9 | 1.47 |
| 27 байууллагад материаллаг хохирол учируулна | 52.1 | 33.5 | 14.4 | 1.62 |
| 34 хохирох хүн байхгүй аль аль нь хожно | 35.4 | 24.6 | 39.9 | 2.04 |
| 30 хүнд сурталыг багасгана | 34.8 | 18.1 | 47.0 | 2.12 |

/ шкалын утга 1- тийм, 2- яаж ч магадгүй, 3- үгүй /

Авилгал нь нийгэмд баян хоосны ялгааг даамжруулж, тодорхой бүлэг хүмүүсийн амжиргаанд хүндээр тусч байгаа талаар судалгааны явцад ярьсан юм. Бүхий л үйлчилгээг авахын тулд мөнгө хэрэгтэй болдог нь ядуу, амжиргааны дорой хүмүүсийг улам бүр доош нь түлхэж ядуурал гаарах нөхцөл мөн гэж үзсэн.

Авилгалын хор хөнөөл их, хүмүүсийг ядууруулахад их нөлөөтэй. Жишээ нь банкны зээлэн дээрээс харж болно. Хүүтэй мөнгөн дээрээ авилгал өгнө гэдэг ядуу хүнд илүү дарамт болно. 200000 мянгын зээл аваад тэндээсээ авилга өгвөл тэр нь багасна, одоо нөгөө бизнесээ яаж хийх вэ? Ганцхан энэ биш өөр олон байдлаар ядууруулж байна.
Ховд аймаг бүлгийн ярилцлагаас

Анкет судалгааны үед авилгал нь нийгмийн шударга ёсыг алдагдуулж, нийгмийн тогтворгүй байдлыг үүсгэдэг гэсэн хариулт нэлээд өндөр байсан. Тэгвэл нийгмийн шударга ёсны нэг хэсэг болсон хууль ёсыг авилгал нь хэрхэн алдагдуулж, тэр хэрээр хүний эрхийг зөрчих болсныг ярилцлагын дүнгээс харж болно.

| |
|---|
| Авилгал бол хуулийн хүрээнд ажил явагдахаа болиход хүргэдэг. Аливаа ажил дандаа хуулиас гадуур явагддаг. Манай байгууллагад гэхэд хоёр хүнийг ажилд авах гэтэл өмнө нь ирсэн мэдлэг боловсролтой хүнийг авчих ёстой байтал дараа нь ирсэн авилгал өгсөн мэдлэггүй хүнийг нь авах жишээтэй. Хуулийн хувьд албан тушаалд тэнцэх чавартай, шаардлага хангасан хүнийг шударгаар уралдуулаад авах ёстой шүүдээ, нөгөө чадвартай хүн, бас ажлын байр хохироод үлдэж байгаа юм.<br>Ховд аймаг бүлгийн ярилцлагаас |

Авилгалын үр дагаврын талаарх олон нийтийн ойлголтод тэр нь ажил хурдан бүтээдэг гэсэн хандлага байгаа бөгөөд өнөөдөр авилгал өгөх нь аливаа хүн ажил төрлөө бүтээх нэг зайлшгүй гүйцэлдүүлэх ёстой үйлдэл болжээ.

**4. Монгол дахь авилгалын илрэх хэлбэрүүд: тархалт ба хувийн туршлага**

Манай иргэдийн доорх үнэлгээнээс үзэхэд Монголд авилгал нь нийгмийн бүх салбарт түгээмэл болж төрийн дээд доод шатандаа нарийн зохион байгуулалттай болсон байна. Хуучин захиргаадалтын үед дэлгэрсэн албан тушаалтныг хоолонд урьж гар цайлгах, хамаатан садан, танил талаа өөд татах, албан тушаалаа хувьдаа ашиглах зэрэг хэлбэрүүд хавтгайрч нийгмийн амьдралын ердийн практик болсон гэж судалгаанд оролцогсдын талаас илүү хувь үзсэн байна.

*Монголын нийгэмд авилгалын дараах хэлбэрийн тархалтын үнэлгээ*

| | Тун их түгээмэл /1/ | Нийтлэг зүйл/2/ | Цөөн /3/ | Огт үгүй /4/ | Дундаж |
|---|---|---|---|---|---|
| албан тушаалтныг хоолонд урьж бяцхан гар цайлгах | 56.9 | 37.1 | 5.6 | 0.4 | 1.50 |
| албан тушаалтан ах дүү хамаатан садангаа татах | 58.7 | 33.3 | 6.7 | 1.3 | 1.51 |
| албан тушаалтан ажил үүргээ ашиглаж өөрт таатай нөхцөлийн буй болгох | 53.4 | 38.3 | 7.4 | 1.0 | 1.56 |
| албан тушаалтанд томоохон д зүйлс өгөх | 29.9 | 45.9 | 23.1 | 1.1 | 1.95 |
| их хэмжээний мөнгө өгөх | 32.1 | 37.0 | 29.2 | 1.8 | 2.01 |
| төрийн албан тушаалтан гэмт хэрэгтнүүд хамсах | 25.1 | 28.7 | 40.6 | 5.6 | 2.27 |

Манай нэг дүү өнгөрсөн жил хагалгаанд орох болсон юм. Тэгээд хэвтэх гэсэн чинь ор байхгүй гээд өөр эмнэлэгт оч гэсэн юм. Тэгэхээр нь хэдэн бор юм цуглуулж байгаад эмчид нь өгсөн. 40000 төгрөг өгсөн юм байна. Энэ бүхний эцэст сая нэг юм хагалгаанд орох болсон доо, Тэгээд бас ингээд зогсоогүй хагалгааны мөнгөнөөс гадна бас хагалгаанд орсон эмч сувилагч нарт бүгдэд нь тодорхой хэмжээгээр юм өгсөн.

Би биллярдны газар нээх санаатай зөвшөөрлийн бичиг хөөцөлдсөн боловч маш их зардал чирэгдэл болж байж бүтсэн. Өргөдлөө өгөөд дүүргээс комисс ирж байр шалгасан юм. Тэгэхэд нэг эрүүл ахуйн хүүхэн, нэг залуу цуг ирсэн байсан. Тэр хоёр байрыг маань агааржуулалт муу байна гээд зөвшөөрөл өгөхгүй гэсэн, би сайн гуйсан боловч огт халгаагаагүй, харин тэр залуу надад “100000 төгрөг өгчих би зөвшөөрлийн бичиг хийлгээд тамга дараад 7 хоногийн дараа жин тан болгоё” гэж хэлсэн би эндээс тэрийг нь өгөөд бичгээ авсан даа

Би МУИС-д хүүгээ оруулахын тулд танилаараа дамжуулж 300000 мянган төгрөг өгсөн. Хүү маань конкурсдээд унасан юм. Би улсын сургуульд оруулсан болохоор тэр мөнгө ч яахав, бас улсын сургуульд орчихоор янз бүрийн хөнгөлөлт юманд хамрагдах боломжтой.

Авилгалын тархалтын хэмжээг тодорхойлох анхдагч нөхцөл нь авилгал, хээл хахуультай тохиолдсон иргэдийн өөрсдийн хувийн туршлага юм. Бидний санал асуулгад сүүлийн 2 жилд судалгаанд оролцогсод болоон тэдгээрийн ойр дотны хүрээний хүмүүс хэн нэгэн албан тушаалтанд бэлэг эсвэл мөнгө өгөх явдлыг судлаж үзлээ.

**Авилгалтай тохиолдсон хувийн туршлага**



| | гэр бїлийн | хамаат ан | хєрш | найз нар | хамтран | би | бусад | їгїй |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| бэлэг | 8.9% | 12.5% | 4.2% | 16.4% | 11.8% | 11.8% | 5.8% | 32.7% |
| мєнгє | 10.3% | 13.5% | 5.1% | 19.1% | 10.2% | 11.3% | 4.4% | 35.5% |

Санал асуулгын дүнгээс үзэхэд, судалгаанд оролцогсод болон тэдгээрийн ойр дотны танилын хүрээний дийлэнх буюу гуравны хоёр нь ямар нэг хэлбэрээр ажил бүтээхийн тулд хэн нэгэн албан тушаалтанд бэлэг эсвэл мөнгө өгч байсан гэжээ/График/.

Энэхүү үзүүлэлт бол манай нийгэмд авилгал нь хяналтаас гарч хавтгайрч байгаагийн ил тод жишээ гарцаагүй мөн. Бэлэг эсвэл мөнгө өгч байгаагүй гэж хариулсан хүмүүсийн тодорхой хэсэг ч бас энэ авилгалын харилцаанд орж байсныг үгүйсгэх аргагүй юм.

Өдөр тутмын амьдралд ямар ажил мэргэжлийн хүмүүст илүүтэйгээр гар цайлгах, шан харамж өгөх тохиолдол ямар түвшинд байгааг илрүүлэх нь манай мониторингийн судалгааны нэг зорилт байсан юм. Судалгаанд оролцогчдын доорх хариултаас үзэхэд манайд авилгалын хэлбэр болох гар цайлгах, шан харамж өгөх нь бусад тохиолдлуудаас илүү түгээмэл болжээ. Мэргэжлийн бүлгээр авч үзэхэд багш, эмч, цагдаа, шүүгч, татварын байцаагч нар гэсэн мэргэжлийн хүмүүс авилгалын солилцоонд хамгийн ихээр ордог байна /Хүснэгт/. Энэ нь манайд авилгал хүмүүсийн амьдралтай салшгүй холбоотой хурцадмал зүйл болсныг нотлож байгаа юм.

*Хүснэгт Авилгалд өртсөн мэргэжлийн бүлэг, түүний хэлбэр /тохиолдлын тоогоор/*

| | жижиг бэлгээр гар цайлгах | Үнэтэй бэлэг | их мөнгө өгөх | Бусад тохиолдол | *нийт тохиолдлын тоо* |
|---|---|---|---|---|---|
| Багш | 321 | 52 | 60 | 48 | *481* |
| Эмч | 220 | 61 | 71 | 77 | *429* |
| Цагдаа | 112 | 61 | 118 | 65 | *356* |
| Шүүгч | 78 | 68 | 106 | 66 | *318* |
| Татварын байцаагч | 93 | 48 | 79 | 66 | *286* |
| Баг хороон засаг дарга | 109 | 41 | 38 | 91 | *279* |
| Лицензийн ажилтан | 85 | 43 | 66 | 80 | *274* |
| Эрүүл ахуйч | 98 | 57 | 37 | 78 | *270* |
| Цэргийн комисс | 81 | 46 | 52 | 82 | *261* |
| Байгаль орчны байцаагч | 77 | 51 | 47 | 73 | *248* |
| Бизнесмэнүүд | 79 | 33 | 57 | 78 | *247* |
| Халамж даатгалын ажилтан | 87 | 51 | 38 | 66 | *242* |
| Төслийн ажилтан | 81 | 38 | 48 | 74 | *241* |
| Намын хүмүүс | 68 | 29 | 33 | 88 | *218* |
| Сэтгүүлч сурвалжлагч | 68 | 19 | 26 | 102 | *215* |
| *Нийт тохиолдлын тоо* | *1657* | | *876* | *1134* | *4365* |

Авилгалд өртсөн хувийн туршлагатай хүмүүсийн хариултаас үзэхэд манай томоохон мэргэжлийн бүлгүүдийн төлөөлөгчид ардчилал, зах зээлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулахаасаа илүүтэй албан тушаалаа хувийн ашиг хонжоонд хэрэглэх явдал газар авч, энэ нь зохицуулах хяналтгүй болсон нь харагдаж байна. Судалгаанд оролцогсдын дийлэнх олонхи буюу 72.4 хувь нь ажлын байр бол авилгал, хээл хахуульд өртөх үндэс болдог гэж үзжээ / График /.




Авилгалд хамгийн их өртөмтгий байгууллагыг нээлттэй асуултын тусламжтайгаар тодруулахад шүүх, хууль, цагдаа, гааль, боловсрол, эмнэлэг зэрэг байгууллагууд тэргүүлж байна / Хүснэгт /. Энэ нь өмнө гарсан дүнгүүдийг дахин батлах нотолгоо гэж үзэж болно.

*Хүснэгт . Авилгал, хээл хахуульд өртөмтгий байгууллагууд*

| Ранг | | Давхардсан тоогоор |
|---|---|---|
| 1 | Шүүх,хуулийн байгууллага | 34.6% |
| 2 | Цагдаа | 23.8% |
| 3 | Гааль | 22.5% |
| 4 | Боловсролын байгууллага | 21.5% |
| 5 | Эмнэлгийн байгууллага | 16.4% |
| 6 | Төрийн захиргааа | 8.2% |
| 7 | Татварын алба | 7.6% |
| 8 | УИХ, улс төрч | 4.4% |
| 9 | Прокурор | 3.7% |
| 10 | Банк | 3.6% |
| 11 | Засгийн газар | 2.4% |
| 12 | Хилийн алба | 1.6% |
| 13 | Газрын алба | 1.3% |

***Авилгалын төрөл, хэлбэр***

Авилгалд өртөмтгий байгууллага, мэргэжлийн бүлгийг тодорхойлохын зэрэгцээгээр авилгал, хээл хахууль үүсгэх орчин болон амьдралын янз бүрийн нөхцөл байдлыг тодорхойлж хэв загварчлах нь авилгалаас урдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм. 1999 оны санал асуулгаар бид экспертын аргаар авилгалын нийгмийн байр сууриа бэхжүүлэх (social status pursuit corruption), “их гарын”, гэмт хэргийн буюу луйврын (syndicated corruption), улс төрийн лобби, уламжлалт шинжийн зэрэг үндсэн 5 төрөл хэлбэрийг тодорхойлсон.

Энэ удаагийн судалгаанд бид авилгалын хэлбэр, хэв загварчлалыг нийт судалгаанд оролцогсдын үнэлгээнд үндэслэн дараах дүр зургийг гаргасан /Хүснэгт /.

Бидний зохиосон модель нь нийт хэв шинжийн вариацийг 49.8 хувиар тайлбарладаг буюу өндөр магадлалтай болсон гэж үзэж болно. Үүнд:

1. Хамгийн түгээмэл авилгалын хэв маягт /хэв шинжийн 36.0 хувийг тайлбарлах чадалтай/ тусгай зөвшөөрөл лиценз авах, УИХ засгийн газраар тогтоол гаргуулах, тендэр шалгаруулалтанд нөлөөлөх, хувийн компани засгийн газрын захиалга авч ажил гүйцэтгэх зэрэг хэлбэрүүд бүрдүүлдэг бөгөөд ил, далд хэлбэрээр шийдвэрт шахалт үзүүлэх улс төрийн лоббитой холбон авч үзэж болно.
2. Хоёр дахь хэв маягийн авилгалыг “бизнесийнх” гэж нэрлэж болох бөгөөд газрын зөвшөөрөл олгох, хувьчлалд давуу нөхцөл олж авах, банкны хууль тогтоомжоос гадуур зээл олгох, ах дүү танил талаа албан тушаалд томилох дэвшүүлэх зэрэг хэлбэрүүд энэхүү хэв маягийг бүрдүүлдэг юм.
3. Авилгалын гурав дахь хэв маягт хилээр их хэмжээний бараа оруулах гаргах, хилээр машины наймаа хийх, спирт тамхи оруулах хэмээх гэмт хэрэг, луйврын шинжтэй төрлүүд ордог.
4. Тав дахь хэв маягт сургууль курс явуулах эрх олгох, хүүхэд сургуульд элсүүлэх, цэргийн албанаас чөлөөлөх гэх мэт төрлүүд ордог. Өөрөөр хэлбэл, энэ хэв маягийг нийгэмд байр суурь, статусаа бэхжүүлэхэд чиглэсэн авилгал гэж нэрлэж болно.
5. Эцэст нь УИХ-ын суудлын мөнгө, нам болон сонгуулийн ажиллагааг санхүүжүүлэх зэрэг хэлбэрүүд сонгуулийн авилгалын хэв маягийг бүрдүүлдэг байж болохоор байгаа юм.

Энэхүү типологийг өмнөх 1999 оныхтой харьцуулахад манай орны авилгалын тогтолцоо нь ерөнхийдөө бүрэлдэн тогтож хэвшсэн гэж үзэж болно. Уламжлалт шинжийн авилгалын хэлбэрийн оронд сонгуулийн авилгал тодорсон явдал үүнийг дахин нотлож байна.

*Хүснэгт . Авилгалын төрлийн хэв маягчлал /типологи/*

| Factor | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| Тусгай зөвшөөрөл лиценз авах | 0.79 | | | | |
| УИХ засгийн газраар тогтоол гаргуулах | 0.64 | | | | |
| Тендэр шалгаруулалтанд нөлөөлөх | 0.57 | | | | |
| Татвараас хөнгөлөх чөлөөлөх | 0.56 | | | | |
| Эмнэлэгийн үйлчилгээнд давуу эрх эдлэх | 0.52 | | | -0.31 | |
| Гаалийн байцаагчидад шалгуулах | 0.32 | | | | |
| Газрын зөвшөөрөл олгох | | 0.74 | | | |
| Гаалийн татвараас хөнгөлөх | | 0.59 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| чөлөөлөх | | | | | |
| ах дүү танил талаа албан тушаалд томилох дэвшүүлэх | | 0.52 | | | |
| хувьчлалд давуу нөхцөл олж авах | | 0.45 | | | |
| банкны хууль тогтоомжоос гадуур эээль олгох | | 0.45 | | | |
| хилээр их хэмжээний бараа оруулах гаргах | | | -0.76 | | |
| хилээр машины наймаа хйих | | | -0.64 | | |
| Спирт тамхи оруулах | | | -0.49 | | |
| архины үйлдвэр эрхлэх зөвшөөрөл олгох | | | -0.44 | | |
| цэргийн албанаас чөлөөлөх | | | | -0.69 | |
| сургууль курс явуулах эрх олгох | | | | -0.58 | |
| авто техникийн үзлэг жолооны үнэмлэх | 0.31 | | | -0.47 | |
| хүүхэд сургуульд элсэх | | 0.33 | | -0.35 | |
| виз авах | | | | | -0.59 |
| УИХ ын суудлын мөнгө | | | | | -0.55 |
| нам болон сонгуулийн ажиллагааг санхүүжүүлэх | | | | | -0.44 |
| хувийн компани засгийн газрын захиалга авч ажил гүйцэтгэх | 0.39 | | | | -0.43 |
| үл хөдлөх хөрөнгийн мөнгө | | | | | -0.38 |
| explanatory power=49.8% | 36.0% | 4.8% | 4.0% | 2.7% | 2.4% |
| Extraction Method: Maximum Likelihood. Rotation Method: Oblimin with Kaiser Normalization. | | | | | |

***Авилгалын түвшингийн индекс***

Бидний санал асуулгаас олж авсан дүнгийг нэгтгэж Монголд байгаа авилгалын хэм хэмжээг дараах томъёоны дагуу тодорхойлоход оролдсон. 8 асуудлын авилгалын түвшинг илэрхийлэх позициудыг сонгож дундаж үнэлгээ гаргасан. Дараах томъёог хэрэглэсэн болно.

*Томъёо: (Асуулт 61+ асуулт 37-60-ын дундаж утга+ асуулт 73а+ асуулт 73б+ асуулт 75+ асуулт 90+ асуулт 92+ асуулт 94) /10*

Авилгалын индексийн дээд утга нь 10, доод утга нь 1 юм.
Хүснэгт Авилгалын индекс

| Асуултын дугаар | А с у у л т | Позици | х у в ь |
|---|---|---|---|
| 75 | Авилгалын хэргийн илэрүүлэлтийн түвшин | хангалтгүй | 66,1 |
| 61 | хөтөлбөрийн хэрэгжилт | хангалтгүй+хэрэгжээгүй | 62,7 |
| 90 | Авилгалын хандлага | өснө+хэвээрээ | 95,0 |
| 92 | Авилгалын тархалт | маш ба дэлгэрсэн | 95.4 |
| 37-60 | Авилгалд өртөгдсөн байгууллагуудын дундаж хувь | Их | 60,2 |
| 73а | Хахууль өгөх хувийн туршлага | Тийм | 77.3 |
| 73б | Бэлэг өгөх хувийн туршлага | Тийм | 66,5 |
| 94 | Авилгалтай тэмцэх хүсэл эрмэлзэл | мэдүүлэхгүй ба яриад өнгөрнө | 68,8 |
| Дундаж | | | 69,9 |
| А в и л г а л ы н и н д е к с ы н у т г а | | | 74.0 |

Авилгалтай эрчимтэй тэмцэл хийж буй улс орнуудад авилгалын тархалт, өсөлтийг харуулах зорилгоор индекс бодож 100 хүртлэх хувиар тооцож үзлээ. Хэрэв тухайн индекс 100-д ойр байвал авилгалын индекс өндөр бөгөөд энэ талаар эрчимтэй тэмцэл хийх хэрэгтэй гэдгийг харуулдаг.

Авилгалын индексийг гаргахдаа судалгааны хэд хэдэн асуултуудын хариултыг нэгтгэн дүгнэж дундажлан үзэхэд 74.0 ( энэ нь үнэмлэхүй өндөр тоо ) байгаа болно.

## § Бүлэг 3. АВИЛГАЛТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ОЛОН НИЙТИЙН ЗҮГЭЭС ӨГЧ БУЙ ҮНЭЛГЭЭ

### А. Авилгалын хэргийн илрүүлэлт

Авилгалын хэргийг илрүүлэх түвшин, түүний талаарх хүмүүсийн үнэлгээ нь авилгалтай тэмцэж буй үйл ажиллагааны чухал шалгуурын нэг юм. Албан ёсны статистикаас үзэхэд Монгол улс авилгалын хэргийн илрүүлэлтийн хувьд нийт дүнгээрээ ч, жилийн давтамжийн хувьд ч хуруу дарам цөөхөн юм.

… Хаана, хэн байгааг хэлчих гэхээр тийм эзэн алга байна. Энэ талаар мэдээлэл өгөх хандах хүн байхгүй, хэрэв хэлдэг юмаа гэхэд тэр хүн хохироод үлдэнэ.
… Мөн гол нь улс төрчид эрх мэдэлтэй хүмүүс өөрсдөө авдаг учраас дээрээс нь тэмцэхгүй бол яагаад ч үүнийг зогсоох аргагүй.
Иргэдтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгээс. Улаанбаатар хот

Манай улсад авилгалын хэргийг илрүүлэх арга ажиллагаа хэдийгээр дутмаг байгаа ч гэсэн энэ төрлийн хэргүүд тухайлбал, албан тушаалын хэргүүд мэдэгдэхүйц өсч байгаа нь олон нийтийн сэтгэлийг түгшээж байдгийг дараах графикаас үзэж болно.




Санал асуулгад хамрагсдын дийлэнх олонхи буюу 66.1 хувь нь авилгалын илрүүлэх асуудал манай улсад хангалтгүй байна гэж үзсэн байна. 1999 оны санал асуулгын дүнтэй харьцуулахад олон нийтийн санал бодол тархалтын хэлбэрийн хувьд төдийлөн өөрчлөгдөөгүй боловч хувийн жингийн хувьд “хангалтгүй” гэсэн үнэлгээ мэдэгдэхүйц өссөн байгааг энд анхаарвал зохино.

Манай улсад авилгалын хэргийн илрүүлэлт доогуур байгаа гол шалтгааныг олон нийт эрх мэдэлтнүүдийн оролцоотой холбож үздэг юм /Хүснэгт 7/. Энэ нь 1999 оны байдлаас 9 пунктээр өссөнийг үзэхэд эрх мэдэлтнүүд авилгалд өртөгч, авилгалыг өдөөгч зонхилох хэсэг байсаар байгааг батлана. Юутай ч дээрх үр дүн нь төрийн өндөр албан тушаалтнуудын хариуцлага хүлээдэггүй, төрийн албаны ёс зүйгээ сахидаггүй, ажлаа үнэн зөв тайлагнах ба шударгаар асуудалд ханддаггүй зэрэг сул талыг харуулж байгаа бөгөөд үүнээс хамааран иргэдийн төрд үл итгэх байдал, хүнд суртал бүхий төрийн үйлчилгээнээс залхах, хүнийсэх байдал ажиглагдсаар байгаа юм.

… Өнөөгийн эрх баригчдын хяналтгүй төр, хэтэрхий хүнд суртлын үед авилга бүр гаарч байна. Ерөнхий сайд нь хүртэл өрөөндөө авилга авч өгдөг хүнийг оруулаад ярьж байснаа ил цагаанаар хэлээд байхаар арга ч үгүй юм даа.
Иргэдтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгээс. Улаанбаатар хот

Хүснэгт 7. Авилгалын хэрэг илрэхгүй шалтгаан \1999, 2004 оныг харьцуулан үзэхэд\
/ давхардсан тоогоор,% /

| Шалтгаан | 1999 он | 2004 он |
|---|---|---|
| эрх мэдэлтнүүд оролцдог | 64.7 | 73.8 |
| Хавтгайрч ердийн үзэгдэл | 40.2 | 63.9 |
| Хууль хяналтын байгууллагынхан анхаардаггүй | 31.2 | 45.6 |
| Нарийн зохион байгуулалт | 33.5 | 40.4 |
| эрх зүйн орчин бүрдээгүй | - | 31.3 |
| Авилгалын талархи мэдээллийг мөнгөөр үнэлдэггүй | 12.1 | 20.0 |

**Б. Байгууллагуудын үнэлгээ**

Авилгалтай тэмцэж буй үнэлгээг байгууллагуудаар авч үзэхэд манайд авилгалтай тэмцэх байдал туйлын хангалтгүй түвшинд байгаа дүр зураг тодорч байна / Хүснэгт 7/. Байгууллагуудыг үнэлсэн олон нийтийн үнэлгээнээс харахад “хангалттай” гэсэн үнэлгээнээс “хангалтгүй” нь илт давсан бөгөөд дундаж утгаараа 2.12 - 2.59 хооронд, дунд үнэлгээнээс доош гарсан юм.

Хүснэгт 7. Авилгалтай хийж буй тэмцлийн үнэлгээ байгууллагуудаар /%/

| Б а й г у у л л а г а | Хангалттай | Дунд зэрэг | хангалтгүй | Д у н д а ж * |
|---|---|---|---|---|
| 63 ерөнхийлөгч | 24.9 | 38.4 | 36.7 | 2.12 |
| 70 хэвлэл мэдээлэл | 24.4 | 37.9 | 37.7 | 2.13 |
| 62 УИХ | 16.4 | 38.5 | 45.0 | 2.29 |
| 64 засгийн газар | 15.2 | 34.7 | 50.0 | 2.35 |
| 66 төрийн хянан шалгах хороо | 11.7 | 39.1 | 49.2 | 2.38 |
| 69 төрийн бус байгууллага | 12.8 | 33.7 | 53.5 | 2.41 |
| 71 нийт иргэдийн зүгээс | 12.9 | 29.9 | 57.2 | 2.44 |
| 68 цагдаагийн байгууллага | 7.6 | 30.6 | 61.8 | 2.54 |
| 67 прокурор | 6.5 | 29.6 | 63.9 | 2.57 |
| 65 шүүх | 7.7 | 25.5 | 66.8 | 2.59 |

*шкалын утга 1-хангалттай, 2- дунд зэрэг, 3—хангалтгүй

Хамгийн дээгүүр үнэлгээг Ерөнхийлөгч авсан нь энэ талаар хангалттай ажил хийснийг илэрхийлэхгүй, харин төрийн томоохон институци болох хувьд нь энэ талаар иргэдийн зүгээс итгэл хүлээлгэж буй хэрэг юм. Нөгөөтэйгүүр, авилгалтай тэмцэх мэргэжлийн гэх байгууллагууд /шүүх, прокурор, цагдаагийн байгууллага/ хамгийн дор үнэлгээ авсан нь нэг талаас нь манай Авилгалын эсрэг хуулийн боловсруулалт, түүний хэрэгжилт, манай нөхцөл байдалд тохирох эсэх, нөгөө талаас тухайн байгууллагуудын авилгалын илрэлд хайнга хандах хандлагаас шалтгаалсан байж болох юм. Иргэний нийгмийг төлөөлдөг хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад иргэд, төрийн бус байгууллагуудын авилгалтай тэмцэх оролцоо нь мөн доогуур үнэлэгдсэн ба цаашид эдгээрийг идэвхтэй татан оролцуулах талаар хойлшлуулашгүй алхмуудыг төлөвлөх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэе.

### *5. Авилгалтай тэмцэх эрх зүйн орчны үнэлгээ*

1996 онд Авилгалын эсрэг хууль, мөн 2002 онд авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрөө батлан гарсан явдал нь авилгалын эсрэг тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичгүүд болсон юм. Энэхүү хууль болон үндэсний хөтөлбөр батлагдаад нэлээд хугацаа өнгөрсөн ч өнөөг хүртэл түүний хэрэгжилт нь нийгэмд тодорхой бус, хангалтгүй, нааштай үр дүнд хүрч чадаагүй гэдгийг судалгааны дүн нотолж байна.




Жич: 2004 оны судалгаанд 5 баллын шкал хэрэглэсэн учраас харьцуулалтын зориултаар 3 баллын шкал руу хөрвүүлсэн болно.

Ингээд нийт респондентуудын зөвхөн 8.6 хувь нь Авилгалын эсрэг хууль болон Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэсэн байхад талаас илүү буюу

58.9 хувь тэдгээрийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл, хэдийгээр 1999 онтой харьцуулбал хууль болон хөтөлбөрийн хэрэгжилтийг эерэгээр үнэлсэн хүмүүсийн хувийн жин нь ялимгүй өссөн ч нийт сөрөг хандлага нь хэвээр хадгалагдсаар байна. Нас, хүйс, боловсрол, намын харъяалал, оршин суух газар зэрэг хүчин зүйлүүд уг хандлагад нөлөөлөхгүй гэдгийг статистикийн тооцоо дүн гэрчилнэ.

*Авилгалд оролцогчдыг олон нийтийн зүгээс буруушаах нь*

Авилгалын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд авилгалыг авч өгөхөд оролцсон буруутанг тодорхойлох явдал нь чухал үүрэгтэй.

Авилгалын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар “шан харамж буюу хөнгөлөлт, давуу тал хууль бусаар өгсөн, олгосон албан тушаалтан болон иргэн, хуулийн этгээд нэгэн адил хариуцлага хүлээдэг”. Тус зүйл заалтыг олон нийтийн зүгээс сайшаан дэмждэг нь судалгааны үр дүнгээс харагдсан болно.




Дээрх графикаас үзэхэд респондентуудын 51.2 хувь нь авилгалыг авч өгөх үйлдэлд оролцсон бүх этгээдүүдийг буруутан гэж үзэж байгаа юм. Энэхүү үзүүлэлт нь 1999 оны ТЗУХИ-ээс явуулсан судалгааны дүнтэй харьцуулахад 10 гаруй хувиар буурчээ. Энэ нь манай олон нийт авилгалд хэт дассаныг харуулж байна. Харин авилгал авсан, өгсөн, зуучилсныг буруутгах талаар респондентуудын үзэл бодолд онцлон хэлэх өөрчлөлт гараагүй болно.

***7. Авилгалтай тэмцэх байгууллагын талаарх олон нийтийн ойлголт***

Гадаадын туршлагаас үзэхэд Гонг Конг, Сингапур зэрэг орнуудад авилгалтай тэмцэх бие даасан хараат бус агентлаг, комисс байгуулж авилгалын эсрэг тэмцэх тэмцэлд чамлалтгүй амжилтад хүрсэн. Гэхдээ эдгээр орнуудын загварыг хуулбарлах гэсэн

оролдлого ихэнхдээ бүтэлгүйтсэн нь авилгалтай тэмцэх байгууллагыг улс орны улс төр, эдийн засаг, түүх соёлын өвөрмөц нөхцөл байдлыг харгалзаагүйтэй шууд холбоотой юм.

1999 онд явуулсан судалгаанд респондентуудын дийлэнх олонхи /80.0%/ нь авилгалын эсрэг тэмцэх байгууллага Монголд шаардлагатай гэж хариулжээ.

Иймээс энэ судалгааны бас нэг чухал зорилт нь Монголд авилгалын эсрэг тэмцэх байгууллагын эрх зүйн байдал, гүйцэтгэж буй үүргийн талаарх олон нийтийн санал бодол, байр суурийг тодорхойлоход чиглэсэн.

Судалгаанд хамрагсдын дийлэнх буюу 54.4 хувь нь Монголд авилгалын эсрэг тэмцдэг байгууллага нь тусгай эрх мэдэлтэй бие даасан байгууллагын эрх зүйн статустай байх ёстой гэж үзсэн.




Үүнийг фокус бүлгийн хэлэлцүүлэгт орсон хүмүүс ч онцлон ярьж байсан.

> Засгийн газар, төрийн байгууллагууд авилгалтай тэмцдэг. Тэр нь ямар ч үр дүн өгдөггүй. Тиймээс тусгай байгууллага байх нь зөвч юм шиг. Тэгэхдээ шүүх цагдаагаас хараат бус байх нь зүгээр юм шиг санагддаг.
> Фокус бүлгийн хэлэлцүүлгээс. Улаанбаатар хот

Харин тухайн байгууллага харъяаллын хувьд төрийн захиргааны эсвэл төрийн бус байгууллага байх эсэх талаар судалгаанд хамрагсад харьцангуй жигд саналтай байгаа юм. /21.7% ба 20.2% тус бүр/. Эндээс үзэхэд, олон нийтийн дийлэнх хэсэг нь авилгалтай тэмцэх байгуллага нь төрийн захиргааны байгууллага болон олон нийтийн байгууллага биш, харин Гонг Конг, Сингапурын жишгээр тусгай эрх мэдэлтэй цагдаагийн шинжийг агуулсан байгууллагатай байх нь зүйтэй гэсэн санал бодлыг дэмждэг гэсэн дүгнэлт хийж болно.

Авилгалтай тэмцэх байгууллага ямар үүрэгтэй байх ёстой вэ гэсэн асуултад иргэд олон нийтийг авилгалтай тэмцэх тэмцэлд татан оруулах / 59.2% /, төрийн албан хаагчдын авилгал өртсөн байдалд хяналт тавих / 54.4% / болон авилгалын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах / 46.0% / зэрэг хэд хэдэн зүйлийг чухалчилж үзсэн юм.

**Авилгалтай тэмцэхэд байгууллагын үүрэг**

/давхардсан тоогоор/

| | |
|---|---|
| Иргэд олон нийтийг татан оруулах | 59.2 |
| авилгалд өртсөнд хяналт | 54.4 |
| сургалт сурталчилгаа | 46.0 |
| Холбогдох байгууллагаас шаардагдах | 40.0 |
| Авилгалтай тэмцэхэд туслах | 31.2 |
| Холбогдох байгуулагуудадад мэдээлэх | 25.6 |
| Гадаадын ТББ- тай хамтран ажиллах | 15.2 |
| Бусад | 2.5 |

***8. Авилгалын талаарх олон нийтийн хүлээлт***

Авилгалын тархалтын талаарх олон нийтийн мэдрэмж, авилгалтай тэмцэх тэмцэлд олон нийтийн хүлээлт онцгой байр эзлэж байгаа бөгөөд манай судалгаанд хамрагсдын ердөө л 3.8 хувь нь ойрын нэг хоёр жилд багасна, 33.9 хувь нь энэ хэвээрээ байна, харин 38.1 хувь нь нэмэгдэнэ, 24.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 1999 оны судалгааны дүнтэй харьцуулахад олон нийтийн авилгал багасна гэсэн хүлээлт нэлээд буурч гутранги хандлагатай болсон нь эмзэг зүйл бөгөөд авилгал хэт даамжирсаныг харуулж буй хэрэг мөн.




Нас, хүйс, боловсрол, оршин суух газар хэмээх нийгэм- хүн амзүйн үзүүлэлтүүдийг үүнд анхаарч үзэх хэрэгтэй боловч иргэдийн улс төрийн үзэл бодол, намын дэмжлэг, харьъяалал нь авилгалын цаашдын төлөв байдлын талаарх дүр зураглалыг харуулж өгч

байна. Сөрөг хүчний намуудын дэмжигчид МАХН-ыг дэмжигчдийг бодвол авилгал ойрын нэг хоёр жил нэмэгдэнэ гэсэн илүү шүүмжлэлт байр суурьтай байна. /Хүснэгт үз /.

*Хүснэгт . Авилгал ойрын нэг хоёр жилд ямар болох вэ?*
*/ улс төрийн намын дэмжлэгээр/*

| | МАХН | Сөрөг хүчин |
|---|---|---|
| Нэмэгдэнэ | 46.0 | 55.0 |
| Энэ л хэвээрээ байна | 46.7 | 42.2 |
| Багасна | 7.4 | 2.9 |
| Нийт | 100 | 100 |

Авилгал ойрын нэг хоёр жил нэмэгдэх болон хэвээрээ байх гол шалтгааныг заахдаа респондентуудын 25 хувь нь авилгал хэвийн үзэгдэл болсон, 20 хувь нь хууль хэрэгжихгүй байгаа, 15.1 хувь нь ядуурал байгаа учир гэж тус тус хариулсан. Эндээс үзэхэд авилгал нь шууд\хуулийн хэрэгжилт\ ба дам\ядуурал\ хүчин зүйлсээс хамаарч нэмэгдсээр байна.

*Хүснэгт . Авилгал ойрын нэг хоёр жил нэмэгдэх эсвэл хэвээрээ байх гол шалтгаан*

| | | |
|---|---|---|
| хэвийн үзэгдэл | 179 | 25% |
| хууль хэргэждэггүй, тэмцэлгүй | 147 | 20% |
| ядуурлыг арилгавал багасна | 110 | 15% |
| өсөх хандлагатай байна | 63 | 9% |
| ажил бүтэхгүй | 54 | 7% |
| эрх мэдэлтнүүд гар хардаг | 53 | 7% |
| нийгмийн сэтгэл зүйд тогтсон | 39 | 5% |
| нийгэм яаж өөрчлөгдөхийг мэдэхгүй | 24 | 3% |
| сургалт сурталчилгаа явуулах хэрэгтэй | 22 | 3% |
| ажлаа бүтээх гол хэрэгсэл болсон | 22 | 3% |
| Сонгуулиар авилгал ихэсдэг | 16 | 2% |
| | 729 | 100% |

## § Бүлэг 4. ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛИЙН МАТЕРИАЛД КОНТЕНТ АНАЛИЗЫН АРГААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮН

Судалгаанд нийтдээ өдөр тутмын 4 сониныг сонгон авч авилгалын талаар гарсан материалуудад контент анализын аргаар тоон шинжилгээ хийлээ.

Баримт материалуудыг тоон утганд оруулан шинжилгээ хийхдээ дараах 5 зүйлийг анхаарсан. Үүнд Нэгдүгээрт тухайн мэдээллийн зохиогч, гарчиг, талбайн хэмжээ, зэрэг паспортын шинжтэй үзүүлэлтүүд, хоёрдугаарт авилгалын талаархи мэдээллийн хэлбэр агуулга, шинж чанар зэргийг судлан үзсэн. Гуравдугаарт Тухайн мэдээлэлд гарч байгаа авилгалын хэлбэр, төвшин зэргийн талаар ангилан судаллаа. Дөрөвдүгээрт авилгалын хэмжээ, холбогдсон хүний тоо, тухайн мэдээлэлд төсвийн байгууллагын ямар албан тушаалтан холбогдож байгаа эсэх, мөн авилгалтай холбоотой хүмүүсийн ажил эрхлэлт, авилгалтай түгээмэл холбогдож байгаа албан тушаал, мэргэжил, тавдугаарт иргэдийн авилгалд хандах хандлага зэрэг асуудлуудыг багцлан судаллаа.

### Нэг. Судалгааны түүвэр, мэдээллийн хэмжээний талаар

Судалгаанд нийтдээ өдөр тутмын 4 сонин тухайлбал өнөөдөр, өдрийн сонин, Зууны мэдээ Монголын мэдээ зэрэг сонинд 2002 ба 2003 онуудад авилгалын талаар гарсан материалуудад контент анализын аргаар тоон шинжилгээ хийлээ. Ингэхдээ эдгээр сонинууд нь нэгдүгээрт харьцангүй бодитой зүйл нийтэлдэг, хоёрдугаарт нь төлөөллийн хувьд янз бүрийн улс төрийн хүчин, субьектуудын эрх ашгийг илэрхийлж байдаг зэргийг харгалзан үзсэн болно.

2002-2003 оны байдлаар тоон шинжилгээ хийсэн нийт сонинуудад авилгалын талаар 110007.35 $см^2$ талбай бүхий 192 материал хэвлэгдэн гарчээ. Эдгээр сонин тус бүрээр авч үзвэл:

| | Өнөөдөр | Өдрийн сонин | Зууны мэдээ | Монголын мэдээ |
|---|---|---|---|---|
| Нийт талбайн хэмжээ | 50837.5 $см^2$ | 25722.1 $см^2$ | 16300.4 $см^2$ | 17147.35 $см^2$ |
| Нийт материалын тоо | 59 | 55 | 45 | 33 |

Дээрх тоон дүнгээс авилгалын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд, ялангуяа сонин хэвлэлд нэлээд түгээмэл авч үздэг болохыг харж болно. Мэдээллийн хэмжээний зэрэгцээ, мэдээллийн төрөл хэлбэр, шинж чанар, хандлага, ач холбогдлын талаар нарийвчлан авч үзсэнээр бидний баримт бичгийн судалгааны зорилго хангагдана.

### Хоёр. Авилгалын талаархи материалын нийтлэгдсэн хэлбэр, агуулга, шинж чанар

Контент анализын судалгаанаас үзвэл өдөр тутмын сонин хэвлэлүүдэд нийтлэгдсэн материалын 34,2 хувь нь мэдэгдэл байдлаар, 20 орчим хувь нь ярилцлага байдлаар, 15 хувь нь сурвалжлага байдлаар, 2,6 хувь нь захидал байдлаар, 7,8 хувь нь тодорхой зохиогчийн үзэл бодол байдлаар нийтлэгдсэн байна. Үүнийг дараах графикаар харуулж болно.

**Мэдээллийн хэлбэр.**




Авилгалын талаар гарсан нийт мэдээллийн 61 орчим хувь нь асуудлыг бүрхэгдүүлсэн, ерөнхийлсэн, дүгнэсэн шинжтэй байгаа бол 39 орчим хувь нь тодорхой байдлаар хөндсөн байна.




*Авилгалын талаарх олон нийтийн ойлголт нь ерөнхий бөгөөд бүрхэг, олон үзүүртэй, зөрчилт шинжтэй байна. Иймээс нийгмийн ухамсрын түвшинд авилгал гэж юу болох, тэр нь ямар хэлбэр, түвшингээр хэрхэн илэрч болох талаар мэдлэг хандлага маш сул төлөвшсөн байгааг ХМХ-ийн зүгээс иргэдэд өгч буй ерөнхий мэдээлэлтэй холбон шүүмжилж болно.*

Өдөр тутмын сонин хэвлэлд судлан байгаа асуудлыг хөндсөн материалыг шинж чанарын хувьд бүлэглэн үзвэл 30,5 хувь нь авилгалын эсрэг тэмцэхийг бусдад уриалсан байгаа бол, 25,3 хувь нь авилгалыг эсэргүүцсэн, 27,6 хувь нь авилгалын талаар бодол эргэцүүлэл хийсэн байдалтай байна.

**Мэдээллийн шинж чанар.**




Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн давуу тал болох олон нийтийн санал бодолд нөлөөлөх чадварыг ашиглан, шинж чанарын хувьд авилгалыг үл тэвчих нийтлэлийн янз бүрийн хэлбэрүүдийг ашиглан нийтийн ухамсарт авилгал авах болон өгөхгүй байх үзэл санаа, ёс суртахууныг төлөвшүүлэх нь мэдээлэл 4 дэх засаглал болсон өнөө үед ихээхэн чухал гэдэг нь тодорхой билээ.

**Гурав. Авилгалын хэлбэр, төвшин,**

Судалгаанаас үзвэл авилгалд холбогдож байгаа байгууллагуудын хувьд 38,5 хувь нь төрийн байгууллагын талаар, 19,5 хувь нь улсын байгууллагын талаар, 6,3 хувь нь бизнесийн байгууллагын талаар, 3,4 хувь нь хувийн байгууллагуудыг тус тус дурдсан байна.

**Авилгалын илэрч буй хэлбэрүүд./байгууллагаар/**




Энэ нь зөвхөн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн онцлогтой холбоотой гэж үзэж болно. Санал асуулгын дүнгээс харахад судалгаанд оролцогчдын үнэлгээгээр хамгийн их авилгалд автсан нь шүүх / 79.0% /, гааль / 78.5-79.6% /, прокурор / 76.9% / бөгөөд харин авилгалд харьцангуй бага өртсөн нь ерөнхийлөгчийн тамгын газар / 42.6% /, хувийн бизнесийн салбар, боловсрол, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд / 44.9-48.6% / тус тус

байдаг нь тогтоогдсон. Хэдийгээр баримт бичгийн судалгаанд төрийн байгууллагын аль түвшинд авилгал их байгааг нарийвчлан өгүүлээгүй боловч, авилгалын эсрэг тууштай тэмцэх талаар уриалсан/30.5/ буюу авилгалыг нийгмийн сөрөг үзэгдэл болох хувьд нь эсэргүүцсэн /25.3/ нь сайшаалтай.

Баримт бичгийн судалгаанд дурдагдсан авилгалын талаархи мэдээллүүд нь төвшний хувьд 32,2 хувь нь улсын хэмжээний, 2,8 хувь нь орон нутгийн хэмжээний, 18,1 хувь нь тодорхой нэг байгууллагын хэмжээний, 10,2 хувь нь хувь хүний төвшинд гарсан байна.

Авилгал авах хэлбэрийг судлан үзэхэд дараах дүн гарч байна. Нийт мэдээллийн бараг гуравны нэг нь буюу 34,9 хувь нь авилгалын илрэх хэлбэр нь албан тушаалаа ашиглах гэсэн дүн гарчээ. Мөн 4,6 хувь нь харилцан ашигтай байдлаар тохирох гэж эрэгээр дүгнэсэн байхад 2,3 хувь нь танил тал харж ажил бүтээх нь авилгал гэж үзжээ. Харин бусад хэлбэр жишээлбэл бэлэг өгөх, хахууль, хуурч мэхлэх, мөнгө өгөх, тусламж дэмжлэг үзүүлэх хэлбэрүүдийг сонины материалд тавьдаггүй нь судалгаагаар батлагдсан юм.

**Дөрөв. Авилгалын хэмжээ, холбогдсон хүний тоо, албан тушаалтнууд**

Шинжилгээ хийсэн нийт материалын 25 орчим хувьд нь авилгалын талаар тодорхой тоо дурдагдсан байна. Тухайлан өгүүлэхэд 5 мянгаас 500 сая хүртэл төгрөг өгч авалцах буюу өгсөн, зээл авахад албан тушаалаа ашиглан зуучилсан хэргүүд энд дурдагджээ.

Авилгалын талаархи мэдээлэлд хийсэн шинжилгээнээс үзвэл нийт материалын 34 орчим хувь нь авилгал нь төрийн ямар нэгэн албан тушаалтай холбоотойг заасан байна. Үүнд 6,8 хувь нь гаалийн байгууллагын ажилтантай, 4 орчим хувь нь ерөнхий сайдтай холбоотой 3,4 хувь нь УИХ-гишүүнтэй, 2,3 хувь нь Засгийн газрын гишүүнтэй, 2,3 хувь нь шүүгч нартай, 5,1 хувь нь прокурортой, 2,3 хувь нь цагдаатай, 1,1 хувь нь эмч багш нар тус тус дурьдагдсан байна.

Мөн ямар хүмүүс авилгалд хамгийн өртөмхий байдгийг нарийвчлан судлахад 10,3 хувь нь төрийн түшээд, 7,4 хувь нь бизнесменүүд, 6,9 хувь нь гаалийн ажилтнуудыг, 3,4 хувь нь шүүгч нар гэснээр дээрх дүн давхар нотлогдож байгаа юм.

Авилгалтай холбогдсон хүмүүсийн 25,9 хувь нь төрийн байгууллагын ажилтнууд, 5,7 хувь нь хувийн байгууллагын хүмүүс, 4,6 хувь нь улсын үйлдвэрийн ажилчид, 4,6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг авилгалтай холбогддог гэсэн дүн гарчээ.

**Тав. Авилгалд хандах хандлага**

Сонин хэвлэлээр авилгалыг эерэг зүйл болох тухай бичиж хүмүүст хүргэх нь ихээхэн сөрөг үр дагавартай болно. Ялангуяа олон нийтийн зүгээс авилгал бол ажил хэрэг бүтээдэг эерэг зүйл гэсэн төсөөлөл иргэдийн дунд цөөнгүй байгааг анкетын судалгааны үр дүнгүүд ч баталсаар байгаа юм. Үүний хамгийн хортой тал нь тухайн үзэгдлийг байх ёстой

мэт хүлээн зөвшөөрч, хүн бүрийн үйлддэг зүйл гэсэн төсөөлөл нийгэмд лавширахад хүргэдэг байна.

Судалгаандаа бид авилгалын талаархи мэдээллийг эерэг талаас нь авч үзсэн, сөрөг талаас тайлбарласан, мөн төвийг сахисан гэж хуваан үзсэн юм. Үүнд нийт мэдээлийн 92 хувийг дээрх шинж чанараар хуваан үзсэн юм. Ингэхэд 12 хувь нь авилгалд эерэг байдлаар, 31,4 хувь нь авилгал бол сөрөг үзэгдэл юм гэдэг хандлагаар бичигдсэн бол 47,1 хувь нь уг асуудлаар төвийг сахисан байр суурийг баримталжээ. Энэ нь өдөр тутмын сонин хэвлэлийн зүгээс нийтлэлийн бодлогодоо цаашид анхаарвал зохих зүйл мөн.

***Баримт бичгийн судалгаанаас хийх дүгнэлтүүд***

- Сонины материалд хийсэн бичиг баримтын судалгааны дүнд түшиглэн дараах дүгнэлтүүдийг хийж болох юм. Юуны түрүүнд авилгал нь төрийн бага дунд албан тушаалтан төдийгүй засгийн газар толгойлж буй ерөнхий сайдыг ч тойроогүй даамжирсан нэн хурц нийгмийн өвчин болсон байна.
- Иймээс ч хүмүүсийн үзэл бодлыг олон нийтэд, үүгээрээ олон нийтийн ухамсарыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй сэтгүүлчдийн хувьд ч авилгалын асуудлаар санаа зовнин хэрхэн яаж тэмцэх талаар тодорхой саналуудыг гаргасан байна. Гэвч зарим сэтгүүлчдийн авилгалтай холбоотой мэдээллийг гарган тавихаас айх, эсвэл хэт нэг талыг барих гэх мэт үйлдлээс хамааран баримт бичгийн судалгааны үр дүнг зарим талаар бууруулж болно.
- Олон нийтийн байнгын анхаарлын төвд байдаг болоод ч тэр үү, тогтмол хэвлэлд хийсэн баримт бичгийн судалгаагаар авилгал авсан, өгсөн гэх мэт уг асуудлыг тойрсон эргэцүүлэл, баримт, санал бодлууд ялангуяа төрийн байгууллагатай, улс төрийн албан тушаалтай ихэвчлэн холбогдсон байгаа нь анхаарал татаж байна.
- Авилгалын илрэх хэлбэрийг сонин хэвлэлд албан тушаалаа урвуулан ашиглах явдлаас үүдэлтэй гэж нийтлэг бичсэн байгаа болно.
- Баримтаас үзэхэд авилгалын хэрэгт холбогдсон ихэнх хүмүүс нь төрийн байгууллагын томоохон албан тушаалтнууд байгаа нь авилгалын эсрэг тэмцэхэд төрийн байгууллагын хүнд суртлыг арилгах нь ихээхэн ач холбогдолтой гэдгийг харуулж буй хэрэг юм.

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ДҮГНЭЛТҮҮД, САНАЛ ЗӨВЛӨМЖ

*а. Баримтын судалгаанаас дүгнэлт хийхэд*

- Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө баталсан боловч биелэлт хангалтгүй буюу тодорхойгүй аймаг, яамд олон байна. Ихэнх яам авилгалтай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гаргасан атлаа хариуцах эзэн ( хэн биелүүлэх вэ? ), хэрхэн биелүүлэх нь тодорхойгүй байгаа болно. Түүнчлэн хөтөлбөртэй огт уялдаагүй зүйлсийг үйл ажиллагаандаа оруулсан тохиолдол ч материалтай танилцах явцад гарч байв. \Энэ тухай хураангуйг ХАВСРАЛТ-аас үзнэ үү.\
- АТҮХ-ийн хүрээнд нийслэл аймагт зохиогдсон ажлууд, төлөвлөсөн зүйлсээс зарим нэг чухал санаанууд дурдагдсан байна. Үүнд аймгийн цагдаагийн газар авилгалын асуудлаар нууц мэдээлэл хүлээн авах журам тогтоож хэрэгжүүлэх, авилгалын талаарх мэдээллийг үнэлж авах, г.м заалтууд зүй ёсоор багтана. Мэдээж эдгээр саналууд дараа дараагийн хөтөлбөрт орж хэрэгжих нь тодорхой юм. Бид дараахь үндсэн 6 зүйл дээр үнэлгээ-мониторинг хийлээ. Үүнд:
- Аймгуудад АТҮХ-ийн үйл ажиллагааг жигд бөгөөд хүртээмжтэй явуулах эхлэл тавигдсан байна. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болох яамд, аймаг нийслэлийн захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд дээр комиссууд бүрэн байгуулагдсан байна. Гэвч эдгээр нь тайлан ирүүлсэн 16 аймаг, 9 яамдад хамаатай гэдгийг цохон тэмдэглэе.
- Комиссын бүрэлдэхүүнийг мониторингийн хүрээнд онцлон авч үзсэн. Нийт 9 яамны комиссын бүрэлдэхүүнийг авч үзэхэд иргэний төлөөлөл ихээхэн бага байна. Тухайлбал, комиссын бүрэлдэхүүнд орсон 71 хүний 2 нь иргэний төлөөлөл, үлдсэн 69 нь төрийн албан хаагчдаас бүрдэл болсон нь ихээхэн анхаарал татаж байна. Тус комиссын бүрэлдэхүүнд орсон 2 хүн нь ҮХЯ-ны салбар бүрэлдэхүүнд байдаг байна. Үүнийг аймгууд дээр авч үзэхэд харьцангуй их, нийт комиссын бүрэлдэхүүнд орсон 226 хүнээс 16 нь иргэний нийгмийн төлөөллөөс байгаа нь уг бүрэлдэхүүний 7 хувь болох юм. Иймд цаашид иргэний төлөөллийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах хэрэгтэй байна.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байх хамгийн гол шалгуур үзүүлэлт бол түүний “ил тод байх” чанар юм. Энэ талаар төрийн бодлого төвшин бол түмэн олон амгалан гэсэн хэлц үг ч байдаг. АТҮХ-ийг хэрэгжүүлэхээр зохиосон хөтөлбөр, төлөвлөгөөг мониторинг-үнэлгээнд хамрагдсан яамд хийсэн ба аймгуудаас Баян-өлгий, Завхан аймгууд хийгээгүй буюу тайланд тусгаагүй болно. Энд бидний зүгээс ихээхэн шүүмжлэх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, аймгийн төр захиргааны байгууллагуудаас

анхаарлаа хандуулах гол асуудал нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний заалт, хугацаа, хариуцах эзэн ихээхэн тодорхойгүй байсан явдал юм.

- Юуны өмнө АТҮХ-ийн хүрээнд аймаг, яамдаас олон тооны арга хэмжээ, үйл ажиллагаа хийснийг онцлон тэмдэглэе. АТҮХ-ийн хүрээнд бүх яамдад албан ёсоор ТАХ-ийн хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч хэвшсэн, авлигалд өртөж болзошгүй албан тушаалын жагсаалтыг гаргасан, түүнчлэн нийтийг хамарсан ажлууд болох хэвлэлийн бага хурал, сургалт, семинар, ухуулга сурталчилгаа, мэдээ таниулга зэргийг хийж гүйцэтгэжээ. Мөн НИТХ-аас энэ хөтөлбөрийн хүрээнд 500 иргэдийг хамруулан Авилгалын асуудлаар судалгаа хийсэн байна.
- Аймгуудад АТҮХ-ийн хүрээнд хийсэн ажлууд далайц хүртээмжээрээ ихээхэн үр дүнд хүрсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд дээрх аймгууд гарын авлага тараах, хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийх, тэмцээн зохион байгуулах, ТАХ-ийн ёс зүйн дүрмийг батлан хэрэгжүүлэх, мэдээлэл авах утас ажиллуулах, мэдээллийн төв ажиллуулах зэрэг олон арван ажлуудыг хийжээ. Энд Орхон аймагт гэхэд МУИС-ийн социологийн тэнхимтэй хамтран 5000 иргэдийн дунд “Авилгалын асуудлаар” социологийн судалгаа хийсэн, Хөвсгөл аймагт 530 өрхийн 5123 хүнд яриа хийж, санал хүсэлтийг нь авсан, Сүхбаатар аймагт 4480 хүнд яриа таниулга хийсэн зэргийг дурдаж болно.
- Яамд болон аймгуудад харилцан адилгүй, өөрсдийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан төлөвлөгөө гаргасан. Гэхдээ энд өгүүлэхэд төлөвлөгөө ба хөтөлбөрийн хоорондын уялдааны асуудал ихээхэн хүндрэлтэй зүйлийн нэг болоод байна. Нийт аймаг, яамдаас гаргасан төлөвлөгөөг уялдсан, уялдаагүй, холбоотой гэсэн гурван үндсэн хэсгээр авч үзсэн. Хөтөлбөртэй уялдсан байдлыг яамдад авч үзэхэд нийт 108 зүйл заалтаас 42 буюу 38,9 хувь нь уялдсан бол, 59,2 хувь нь ямар нэг хэмжээгээр холбоотой, үлдэх 2 орчим хувь нь уялдаагүй байна. Харин аймгууд нийт 135 заалтыг төлөвлөгөөндөө тусгаснаас 62,2 % буюу 84 заалт үндсэндээ уялдсан бол, холбоотой заалтууд 37 %-ийг, үлдсэн 1 хүрэхгүй хувь нь хөтөлбөртэй уялдаагүй байгаа болно.
- Төлөвлөгөөний биелэлт нь төлөвлөгөөг хэр зэрэг нарийвчлан хийсэн, хэрэгжилтийн явцыг тайланд хэрхэн тусгаснаар тодорхойлогдоно. Хөтөлбөрийн биелэлтийг тайланд өгүүлсэнээс үндэслэн дүгнэлт хийхэд яамдаас дэвшүүлсэн хөтөлбөрийн 22,2% нь биелсэн ( тайланд тусгаснаар ) бол, 4,6 % нь огт биелээгүй, харин тодорхойгүй үлдсэн заалтууд хамгийн их буюу 73,2 %-ийг эзэлж байна. Аймгуудад төлөвлөгөөний биелэлт харьцангуй өндөр ( яамдуудтай харьцуулахад ) 32,6 %-тай байгаа ба энэ нь нийт 44 зүйл

заалт юм. Мөн тодорхойгүй үлдсэн заалтуудыг аймагт авч үзэхэд 88 буюу биелсэн заалтаас даруй 2 дахин их байгааг харж болно. Харин биелээгүй заалт 2,2 %-тай байгаа нь нэлээд бага үзүүлэлт гэж хэлж болохоор байна.

*б. Санал асуулгын судалгаанаас дүгнэлт хийхэд*

- Судалгааны дүнгээс үзэхэд авилгал нь өнөөгийн Монголын нийгэмд өргөн тархсан, нэн түгээмэл үзэгдэл болох нь харагдаж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнхи олонхи нь / 88.9 хувь / Монголд авилгал дэлгэрсэн хэмээн хариулжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид нь нас, хүйс, боловсрол, намын харъяалал, оршин суух газар зэрэг нийгэм-хүн ам зүйн үзүүлэлтээсээ үл хамаарч нийтээрээ Монголд авилгал нийгмийн бодит үзэгдэл болж хувирсан гэж үзсэн юм.
- Санал асуулгад оролцогчдын дийлэнхи олонхи нь авилгал өргөн тархсан гэж үзсэн бол чанарын судалгаанд оролцогчид тэрээр нийгэмд ердийн зүйл бөгөөд хүмүүсийн харилцааны энгийн жишиг хэм хэмжээ болсныг онцолж байлаа. Хүмүүс энэ жишигт суралцахгүйгээр аж төрөх, аль нэг үйл ажил эрхлэхэд маш хүндрэлтэй болжээ.
- Судалгаанд оролцсон таван хүний нэг нь авилгал нэг талаас заавал муу хор үр дагавартай байх ёсгүй, нөгөө талаас тийм ч гаж үзэгдэл биш гэсэн ойлголт ч манай нийгэмд төлөвшиж тогтсоныг харуулж байна. Үүнийг бид ихээхэн аюултай үзэгдэл гэж үзэж байна.
- Авилгалын талаарх олон нийтийн ойлголт нь олон үзүүртэй, зөрчилт шинжтэй байна. Нийгмийн ухамсрын түвшинд авилгал гэж юу болох, тэр нь ямар хэлбэр, түвшингээр хэрхэн илэрч болох талаар мэдлэг хандлага маш сул төлөвшсөн байна.
- Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр хамгийн их авилгалд автсан нь шүүх / 79.0% /, гааль / 78.5-79.6% /, прокурор / 76.9% / бөгөөд харин авилгалд харьцангуй бага өртсөн нь ерөнхийлөгчийн тамгын газар / 42.6% /, хувийн бизнесийн салбар, боловсрол, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд / 44.9-48.6% / байна. Энэхүү дүн 1999 оны байдлаас үндсэндээ ялгагдахгүй юм. 1999 оны санал асуулгын дүнгээс үзэхэд авилгалд хамгийн их автсан нь гаалийн байгууллага / 70.1% /, банк / 69.2% /, шүүх / 46.0% /, УИХ / 39.3% /, татварын алба / 39.0% /, харин авилгалд бага өртсөн нь ерөнхийлөгчийн тамгийн газар байлаа. Эндээс үзэхэд авилгал нь төрийн байгууллагуудад түгээмэл тархсан бөгөөд энэ таван жилийн хугацаанд авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр гарсан ч сөрөг хандлага хэвээр хадгалагдсаар байна.

- Ерөнхийд нь авч үзвэл авилгал бол аль нэг төрийн албан тушаалтанд шан харамж өгч ажил хэргээ бүтээх явдал гэсэн төсөөлөл төдий хэмжээнд байна. Мөн авилгалын талаар эерэг ойлголт, хүлээлт байгааг тэмдэглэх нь зүйтэй. Авилгал нь ажил хурдан бүтээнэ, хүнд суртлыг багасгана гэхчлэн хариултууд нэлээд өндөр хувьтай байв. Энэ нь нэн түгшүүртэй үзэгдэл болно.
- Урьд өмнөх судалгаанудад авилгалд өртөгдсөн байдлаараа тэргүүлж байсан төрийн зарим институцууд энэ удаа ч жингээ хадгалсаар байна. Түүгээр зогсохгүй тэдгээр байгууллагуудад авилгал улам бүр гаар ч, цэцэглэн хөгжиж байгаа нь тодорхой байна.
- Хууль шүүхийн байгууллагууд, тухайлбал шүүх, цагдаа, прокурор, гаалийн, татварын хийгээд газрын алба зэрэг нь өнөөгийн байдлаар авилгалд идэгдсэн жишгээрээ хамгийн өндөр байгаа бол олон нийтийн зүгээс түүнийг үнэлэх үнэлгээ 1999 оноос хойш илт багассан байна.
- Санал асуулгын дүнгээс авилгалын голлох шалтгаануудыг хүчин зүйлийн шинжилгээний үндсэн дээр бүлэглэн үзэж болохоор байна. Үүнд хүмүүсийн амжиргааны түвшин доогуур, хэрэгцээгээ хангасан түвшин дорой байдал,/ялангуяа төрийн албан хаагчдын/, авилгалтай тэмцэх хууль эрхзүйн орчны хос байдал, сул хөгжил, төрийн албан тушаалтны эрх мэдэл, хариуцлагын уялдаагүй байдал зэрэг бүлэг хүчин зүйл, шалтгаанууд орж байна. Харин чанарын судалгааны явцад дээрх шалтгаанууд илэрч байсны зэрэгцээ түүний дээр хүнд суртлын талаар нэлээд хэлэлцүүлэг өрнөж байсан юм. Төрийн байгууллагуудад хүнд суртал ноёрхож, төрийн албан хаагчдын ердийн зан үйлийн нэг шинж нь хүнд суртал болсон нь авилгал цэцэглэх нэг шалтгаан болж байгаа юм.
- Фактор-анализын дүнгээс үзэхэд манайд авилгал нэлээд нарийн зохион байгуулалттай болж системт шинжийг агуулдаг болсон гэж дүгнэж болно. Шинжилгээний явцад илэрсэн авилгалд автсан таван бүлэг байгууллагууд бол нийгмийн үйл ажиллагааны тодорхой салбарыг бүрдүүлж авилгалын тодорхой хэлбэр / улс төр, бизнес, цагдаагийн г.м ./ - ийг төлөөлөх болсон нь илэрхий байна.
- Судалгаанд оролцогсод авилгалын гол шалтгааныг ёс суртахууны доройтол буюу “хүмүүс мөнгийг хэт шүтэх болсон” / 74.5% /, шүүх засаглалын буруу үйл ажиллагаа буюу ”хууль хяналтынхан авилгалын хэргийг шудрагаар шийддэггүй” / 74.2% /, төрийн албан хаагчдын тайлагнахгүй байдал буюу ” албан тушаалтнууд эрх мэдэлтэй ч хариуцлага хүлээдэггүй” / 73.8% / хуулийн хэрэгжилт хангалтгүй / 70.4% / зэрэг зүйлүүдтэй голчлон холбон үзэж байгаа юм

- Авилгал нь нийгэмд олон үр дагаварыг төрүүлж байгааг олон нийтийн зүгээс онцлохын дээр түүний хохирлыг амсагчид хэзээ ч хууль шүүхийн өмнө эрх ашгаа сэргээлгэж, хохирлоо нөхөн төлүүлэх боломжгүйд ихэд эмзэглэж байна. Санал асуулгаас үзэхэд авилгал нь хүний эрхийг зөрчиж, эрх эрх чөлөөнд цаг ямагт халддаг, нийгэмд шударга ёс, хууль ёс, ёс суртахууны хэм хэмжээ унаж доройтоход хүргэж байна гэжээ. Мөн түүнчлэн улс эх орон болон иргэн хүнд материаллаг хохирол учруулж, нийгмийн тэгш бус байдал, ялгарлыг нэмэгдүүлж, ядуурлыг гааруулж байгаа нь судалгааны дүнгээс тодорхой байна.
- Судалгаанд оролцогчидоос олонхи нь авилгалын хэрэг илрүүлэлт манай улсад хангалтгүй байгаа гэж үзээд энэ нь нэг талаас авилгалын хэрэгт эрх мэдэлтэн, албан тушаалтнууд хамаатай байдаг буюу түүнийг илрүүлэлтэд эдгээр хүмүүс оролцдогтой нөгөө талаас авилгал өгч авалцах нь нийгэмд ердийн зүйл лугаа болсонтой тус тус холбоотой гэж үзжээ.
- Төрийн болон ТББ – ууд, иргэдийн авилгалтай тэмцэж буй байдалд олон нийтийн зүгээс өгсөн үнэлгээг сонирхвол дээрх субьектүүдийн авилгалтай хийх тэмцэл маш сул байна. Өөрөөр хэлбэл нийгэм тэр чигээрээ авилгалд хүлцэнгүй байж, түүнийг хүлээн зөвшөөрчээ гэж дүгнэхээр болжээ. Судалгаанд оролцогчдын зүгээс бас нэг хөндсөн асуудал бол авилгалтай тэмцэхэд ямар байгууллага байх талаар олон нийтийн хүлээлт юм. Судалгааны дүнгээс үзэхэд авилгалтай тэмцэх байгууллага нь төрийн захиргааны бус, ТББ ч бус харин тусгай эрх мэдэлтэй бие даасан байгууллага байх ёстой гэсэн хандлага олон нийтийн дунд давамгай байна.
- Өнөөгийн байдлаар авилгалтай тэмцэх эрх зүйн орчны төлөвшил басхүү хангалтгүй гэж олон нийтийн зүгээс үнэлж байна. Авилгалтай тэмцэх үндсэн хүчин зүйл болсон түүний эрх зүйн орчны хувьд 1999 оноос хойш олон нийтэд мэдрэгдэхүйц хөгжил, өөрчлөлт гараагүй гэж хэлж болохоор байна. Авилгалын талаарх олон нийтийн эрх зүйн боловсрол маш хангалтгүй байгаа нь ч дээрх үнэлгээнд нөлөөлжээ.
- Судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь авилгал Монголын нийгэмд энэ хэвээрээ байх буюу цаашид өсөн нэмэгдэнэ гэж үзсэнээс дүгнэхэд өнөөдөр авилгалын эсрэг нийгмийн сэтгэл зүйн дархлаа үгүй, гутранги байдал бий болжээ.

***Санал зөвлөмж***

- Авилгалтай хийх тэмцлийг хэлбэрдсэн байдлаас гаргаж, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах
- Төрийн байгууллагуудын ил тод байдлыг дээшлүүлэх
- Төрийн албан хаагчдад тавих хяналтыг сайжруулах
- Хууль, хүчний байгууллагуудыг криминал үйл ажиллагаанаас дэс дараатайгаар гаргаж, тэдгээрийн дотоодод хяналтын бүтэц бий болгох
- Иргэдэд авилгалтай тэмцэх талаар сургалт сурталчилгаа хийх ажлыг эрчимжүүлж, авилгалын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, хүлээн авах үнэлэх, хяналт тавих журам тогтоох
- Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн комисст иргэний төлөөлөл оруулах, иргэний төлөөллийн тоог нэмэгдүүлэх
- Иргэний нийгмийн байгууллагууд судалгааны байгууллага, нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах
- Авилгалтай тэмцэх шинэ хуулийг нэн яаралтай батлан гаргах
- Авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулах, түүнд онц бүрэн эрх олгох

§ ХАВСРАЛТ.1

## А.Монгол улсын засгийн газрын яамдууд[1] дахь Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал(мониторинг-үнэлгээ)

| | Утга | Комисс байгуулсан эсэх | Комиссын бүрэлдэхүүн | | Төлөвлөгөө | | | Хийсэн үндсэн ажлууд | | | Төлөвлөгөөний хөтөлбөртэй уялдсан байдал | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ЯАМДЫН НЭРС | **Тийм Үгүй** | **Төрийн албан тушаалтан** | **Иргэний Төлөөлөл** | ***Заалт**/үндсэний хөтөлбөрт тусгаснаар* | **Хугацаа** | **Хариуцах эзэн** | **Тайлан мэдээ** | **Авч хэрэгжүүлсэн тодорхой асуудал** | **Сургалт судалгаа** | **НИЙТ/үүнээс Уялдсан Уялдаагүй Холбоотой** | **Биелсэн Биелээгүй Тодорхойгүй** |
| 1 | ХЗДХЯ | Тийм | 7 | Байхгүй | 5.1.б<br>4.г<br>7.е<br>3.е | 2003. II, IV–р<br>2003<br>2003.10.15<br>2004.I-р | Т/н/б-ийн дарга<br>Байхгүй<br>Байхгүй<br>Байхгүй | 2 | Веб хуудас хийсэн. | сургалт семинар | **13**<br>4<br>-<br>9 | 8<br>4<br>1 |
| 2 | НХХЯ | Тийм | 5 | Байхгүй | 5.1.б<br>3.е | 2003.04.10<br>тодорхойгүй | Дэд сайд<br>Тодорхойгүй | 1 | - | Байхгүй | Байхгүй | Байхгүй |

[1] ЖИЧ: БСШУЯ ба ЭМЯ-наас тайлан ирээгүй болно.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | СЭЗЯ | Тийм | 10 | Байхгүй | 5.1.б<br>2.а<br>5.1.д<br>2.в<br>3.б<br>3.д<br>5.1.г<br>3.ж<br>3к<br>5.1.д<br>7.е<br>7.ж | 2003.10.28<br>2003.IV<br>2003.IV<br>2003-2004<br>2003<br>2003<br>2003<br>жил бүр, 2003<br>2003<br>2003<br>2003<br>2003 | ТЗУГ<br>ТЗУГ<br>ТЗУГ,ТСГ,СЗЗС<br>ХБЗ<br>Бүх газар<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ, ЗХХ<br>Бүх газар<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ,<br>ТСГ,СЗХАБЗГ<br>ТЗУГ<br>ТЗУГ, МХШҮХ | 2 | Хэвлэлийн бага хурал 23 удаа, хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах ажил хийсэн. | 2 удаагийн сургалт | 33<br>12<br>1<br>20 | 7<br>-<br>26 |
| 4 | ГХЯ | Тийм | 6 | Байхгүй | 5.1.б<br>7.е<br>3.е | 2003<br>жилдээ<br>2003.12 | ТЗУГ<br>ТЗУГ<br>Хүний нөөцийн хэлтэс | 1 | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан ба авилгалд өртөж болзошгүй албан тушаалын жагсаалт гаргасан. | 5 удаагийн сургалт мэдээллийн ажил зохион байгуулсан. | 7<br>2<br>-<br>5 | 3<br>-<br>4 |
| 5 | БХЯ | Тийм | 6 | Байхгүй | 5.1.б<br>3.е<br>7.е<br>2а | 2003.02.05<br>02 сард<br>жилд<br>жилд | Дэд сайд<br>н/б/д<br>Ч.Батжаргал<br>гишүүд<br>н/б/д<br>Ч.Батжаргал | 1 | - | - | 13<br>4<br>1<br>8 | -<br>-<br>13 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | ҮХЯ | Тийм | 7 | 2 | 5.1.б<br>3.е<br>3.а, в<br>5.1.д<br>5.2.в<br>3.а<br>5.2.г | 2003<br>2003.II<br>жилдээ<br>жилдээ<br>жилд 2 удаа<br>жилдээ<br>жилдээ | Төрийн н/б/д<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл<br>Яамны газрууд<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл | 1 | Хууль тайлбарлах, мэдээллийн төв ажиллуулж байна. | - | 11<br>6<br>-<br>5 | -<br>1<br>10 |
| 7 | ДБЯ | Тийм | 8 | Байхгүй | 5.1.б<br>3.а,в<br>5.1.д | 2003.03<br>жилдээ<br>тухай бүр | ТЗУГ- Б.Махбал<br>ТА-ны СЗ<br>Яамны газрууд | 1 | - | - | 11<br>4<br>-<br>7 | -<br>-<br>11 |
| 8 | Хүнс ХААЯ | Тийм | 5 | Байхгүй | 5.1.б<br>3.е<br>3.а,в,д<br>6.д<br>5.1.д<br>3.д | 2003.02.02<br>2003.02<br>жилдээ<br>2003.07<br>2003.06<br>2003.II | ТА-ны салбар зөв.<br>Д.Жанцанхорол<br>ТЗУГ<br>Г.Даваадорж<br>Д.Жанцанхорол<br>Ш.Нямхүү, П. Цэдэнбал, | 1 | - | - | 9<br>6<br>-<br>3 | -<br>-<br>9 |
| 9 | БОЯ | Тийм | 7 | Байхгүй | Байхгүй | Байхгүй | Байхгүй | 1 | Хууль тогтоомж сурталчлах | Ухуулга сурталчилгаа хийсэн | -<br>-<br>-<br>- | -<br>-<br>- |

| | Утга | Комисс байгуулсан эсэх | Комиссын бүрэлдэхүүн | | Төлөвлөгөө | | | Хийсэн үндсэн ажлууд | | | Төлөвлөгөөний хөтөлбөртэй уялдсан байдал | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Нийслэлийн ИТХ | Тийм | 8 | Байхгүй | 5.1.б<br><br>7.е<br>2.а<br><br>5.2.г<br>5.2.е | 2003.01.15<br><br>жилдээ<br>2003.I<br><br>жилдээ<br>жилдээ | Г.Маналжав, К. Айнагуль<br>Гишүүд<br>Г.Маналжав, К. Айнагуль<br>Гишүүд<br>Г.Маналжав | 2 | Хэрхэн ажиллах талаар 4 удаа үүрэг өгсөн. Яриа таниулга хийсэн байна. | Судалгаа хийсэн\500 хүн хамарсан\ , мөн сурталчилгаа хийсэн. | 11<br>4<br>-<br>7 | 6<br>-<br>5 |
| | ЯАМДЫН НЭРС | Тийм Үгүй | Төрийн албан тушаалтан | Иргэний Төлөөлөл | *Заалт/үндэсний хөтөлбөрт тусгаснаар* | Хугацаа | Хариуцах эзэн | Тайлан мэдээ | Авч хэрэгжүүлсэн тодорхой асуудал | Сургалт судалгаа | НИЙТ/үүнээс Уялдсан Уялдаагүй Холбоотой | Биелсэн Биелээгүй Тодорхойгүй |
| 1 | ХЗДХЯ | Тийм | 7 | Байхгүй | 5.1.б<br>4.г<br>7.е<br>3.е | 2003. II, IV–р<br>2003<br>2003.10.15<br>2004.I-р | Т/н/б-ийн дарга<br>Байхгүй<br>Байхгүй<br>Байхгүй | 2 | Веб хуудас хийсэн. | сургалт семинар | **13**<br>4<br>-<br>9 | 8<br>4<br>1 |
| 2 | НХХЯ | Тийм | 5 | Байхгүй | 5.1.б<br>3.е | 2003.04.10<br>тодорхойгүй | Дэд сайд<br>Тодорхойгүй | 1 | - | Байхгүй | Байхгүй | Байхгүй |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | СЭЗЯ | Тийм | 10 | Байхгүй | 5.1.б<br>2.а<br>5.1.д<br>2.в<br>3.б<br>3.д<br>5.1.г<br>3.ж<br>3к<br>5.1.д<br>7.е<br>7.ж | 2003.10.28<br>2003.IV<br>2003.IV<br>2003-2004<br>2003<br>2003<br>2003<br>жил бүр, 2003<br>2003<br>2003<br>2003<br>2003 | ТЗУГ<br>ТЗУГ<br>ТЗУГ,ТСГ,СЗЗС<br>ХБЗ<br>Бүх газар<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ, ЗХХ<br>Бүх газар<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ, ЗХХ<br>ТЗУГ,<br>ТСГ,СЗХАБЗГ<br>ТЗУГ<br>ТЗУГ, МХШҮХ | 2 | Хэвлэлийн бага хурал 23 удаа, хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах ажил хийсэн. | 2 удаагийн сургалт | 33<br>12<br>1<br>20 | 7<br>-<br>26 |
| 4 | ГХЯ | Тийм | 6 | Байхгүй | 5.1.б<br>7.е<br>3.е | 2003<br>жилдээ<br>2003.12 | ТЗУГ<br>ТЗУГ<br>Хүний нөөцийн хэлтэс | 1 | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан ба авилгалд өртөж болзошгүй албан тушаалын жагсаалт гаргасан. | 5 удаагийн сургалт мэдээллийн ажил зохион байгуулсан. | 7<br>2<br>-<br>5 | 3<br>-<br>4 |
| 5 | БХЯ | Тийм | 6 | Байхгүй | 5.1.б<br>3.е<br>7.е<br>2а | 2003.02.05<br>02 сард<br>жилд<br>жилд | Дэд сайд н/б/д Ч.Батжаргал<br>гишүүд н/б/д Ч.Батжаргал | 1 | - | - | 13<br>4<br>1<br>8 | -<br>-<br>13 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | ҮХЯ | Тийм | 7 | 2 | 5.1.б<br>3.е<br>3.а, в<br>5.1.д<br>5.2.в<br>3.а<br>5.2.г | 2003<br>2003.II<br>жилдээ<br>жилдээ<br>жилд 2 удаа<br>жилдээ<br>жилдээ | Төрийн н/б/д<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл<br>Яамны газрууд<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл<br>АТҮХ-ийн зөвлөл | 1 | Хууль тайлбарлах, мэдээллийн төв ажиллуулж байна. | - | 11 6 - 5 | - 1 10 |
| 7 | ДБЯ | Тийм | 8 | Байхгүй | 5.1.б<br>3.а,в<br>5.1.д | 2003.03<br>жилдээ<br>тухай бүр | ТЗУГ- Б.Махбал<br>ТА-ны СЗ<br>Яамны газрууд | 1 | - | - | 11 4 - 7 | - - 11 |
| 8 | Хүнс ХААЯ | Тийм | 5 | Байхгүй | 5.1.б<br>3.е<br>3.а,в,д<br>6.д<br>5.1.д<br>3.д | 2003.02.02<br>2003.02<br>жилдээ<br>2003.07<br>2003.06<br>2003.II | ТА-ны салбар зөв.<br>Д.Жанцанхорол<br>ТЗУГ<br>Г.Даваадорж<br>Д.Жанцанхорол<br>Ш.Нямхүү, П. Цэдэнбал, | 1 | - | - | 9 6 - 3 | - - 9 |
| 9 | БОЯ | Тийм | 7 | Байхгүй | Байхгүй | Байхгүй | Байхгүй | 1 | Хууль тогтоомж сурталчлах | Ухуулга сурталчилгаа хийсэн | - - - - | - - - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Нийслэлийн ИТХ | Тийм | 8 | Байхгүй | 5.1.б<br><br>7.е<br>2.а<br><br>5.2.г<br>5.2.е | 2003.01.15<br><br>жилдээ<br>2003.I<br><br>жилдээ<br>жилдээ | Г.Маналжав, К. Айнагүль<br>Гишүүд<br>Г.Маналжав, К. Айнагүль<br>Гишүүд<br>Г.Маналжав | 2 | Хэрхэн ажиллах талаар 4 удаа үүрэг өгсөн. Яриа таниулга хийсэн байна. | Судалгаа хийсэн\500 хүн хамарсан\ , мөн сурталчилгаа хийсэн. | 11 4 - 7 | 6 - 5 |

**Б. Аймгууд[2] дахь авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал. (мониторинг - үнэлгээ)**

| | | **Комисс байгуулсан эсэх** | **Комиссын бүрэлдэхүүн** | | **Төлөвлөгөө** | | | **Хийсэн үндсэн ажлууд** | | | **Төлөвлөгөөний хөтөлбөртэй уялдсан байдал** | **Төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АЙМГИЙН НЭРС | **Тийм Үгүй** | **Төрийн албан тушаалтан** | **Иргэний Төлөөлөл** | **Заалт /үндэсний хөтөлбөрт тусгаснаар** | **Хугацаа** | **Хариуцах эзэн** | **Тайлан мэдээ** | **Авч хэрэгжүүлсэн тодорхой асуудал** | **Сургалт, судалгаа** | **НИЙТ/үүнээс Уялдсан Уялдаагүй Холбоотой** | **Биелэгдсэн Биелэгдээгүй Тодорхойгүй** |

[2] Дундговь, Дорнод, Сэлэнг аймгуудын материал ирээгүй болно.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Увс | Тийм | 5 | Байхгүй | 5.2.а<br>3.е<br>5.2.в<br>5.2.г<br>7.е<br>5.2.д | 2003.04<br>200.I<br>жилдээ<br>жилдээ<br>улиралд<br>жилдээ | Айтехмет<br>Батжаргал<br>Айтехмет<br>Ажлын хэсэг<br>Ажлын хэсэг<br>Буянжаргал | 1 | Гарын авлага тараасан | 2 удаа лекц яриа хийсэн | 6<br>5<br>0<br>1 | 3<br>1<br>2 |
